

**ХОЁР. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН СЭТГЭЛ
САНААНЫ ХОХИРЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ:
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА
(ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА)**

Судалгааг удирдсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
эрдэмтэн нарийн бичгийн дарга П.Амаржаргал

Судалгааг хянасан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах

Судалгааг гүйцэтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан С.Соёл-Эрдэнэ
Эрдэм шинжилгээний ажилтан Ц.Оюунчимэг
Эрдэм шинжилгээний ажилтан З.Мөнгөлжин
Эрдэм шинжилгээний ажилтан Г.Сувд-Эрдэнэ

ХУРААНГУЙ

Монгол Улсад хийгдэж байгаа эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны бодлого, шийдвэрт уялдуулан гадаадын зарим улс орнуудын гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг тооцох арга, аргачлал, үнэлгээний тарифын талаарх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсад хүний сэтгэл санааны хохирлыг тооцох арга, аргачлал, үнэлгээг бий болгох түүнд тулгуурласан эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү харьцуулсан судалгааг хийлээ.

Судалгааны тайлангийн Нэгдүгээр бүлэгт гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол, хор уршиг, гэм хорын ерөнхий ойлголт, Хоёрдугаар бүлэгт эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохиролтой холбоотой Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, үзэл баримтлал, практик, нөхөн төлбөрийн зарим асуудал, Гуравдугаар бүлэгт гадаадын зарим орны туршлагыг харьцуулан авч үзлээ.

Тухайлбал, сэтгэл санааны хохирлын талаарх ойлголтын хүрээнд олон улсын чиг хандлага, үзэл баримтлалыг судлахаас гадна Монгол Улсад гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хууль зүйн хүрээнд хэрхэн тайлбарлаж байгааг анхаарахын зэрэгцээ гадны зарим улсын хуульд хэрхэн тусгасныг судалж үзлээ.

Мөн Монгол Улсын эрх зүйн хүрээнд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр болон энэ талаарх эрх зүйн зохицуулалт практикт хэрхэн шийдвэрлэж байгааг эсэхийг уг судалгаагаар тодруулсан болно.

Бусад улсын зохицуулалтыг харьцуулан судлах хүрээнд ИБУИНВУ, АНУ, Австрали Улс, ХБНГУ, БНФУ, БНИУ, БНХАУ зэрэг улсуудын сэтгэл санааны хохирлын ерөнхий зохицуулалт, нөхөн төлбөрийг тооцох аргачлалыг харьцуулж үзлээ. Үүний хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүлэхийг зорилгоо.

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” хэмээн заажээ.

Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг шүүхээр эцэслэн барагдуулдаг хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршгийн ялгааг нарийвчлан тодорхойлсон байдаг. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус сэтгэл санааны хохирол гэм хорыг нэхэмжлэх хуулийн зүйл заалтууд байгаа хэдий ч сэтгэл санааны хохирлыг тооцож арилгах заалт байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг шийдвэрлэхгүй орхиж болохгүй юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй буюу байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй” хэмээн заасан байдаг. Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө” гэжээ. Энэ ч үүднээс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5-д “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.” Мөн Пактын 14 дүгээр зүйлийн 6-д “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ.” хэмээн тус тус заасныг үндэслэл болгон шүүх хэргийг шийдвэрлэж болох хэдий ч нарийвчлан зохицуулаагүйгээс үүдэн зөрчигдсөн эрх бүрэн сэргэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. Иймд иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээх, нөхөн төлөх эрх зүйн орчин, тогтолцоо механизмыг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын тухайд гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар бүрэн тооцож байгаа ч эдийн бус буюу сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх иргэний нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх нь аль ч талаасаа хангалтгүй учир дутагдалтай байна.

Судалгааны ажлын зорилго. Судалгааны ажлын хүрээнд эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, хүний эрхийн хэрэгжилтийг харгалзан ИБУИНВУ, АНУ, Австрали Улс, ХБНГУ, БНФУ, БНИУ, БНХАУ, зэрэг улсуудыг сонгон судалж, жишиг болохуйц туршлага илрүүлэх, мөн дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж боловсруулахад судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй. Дээрх судалгааны ажлаар хууль зүйн шинжлэх ухааны үндсэн аргууд болох норматив аргаар хэм хэмжээнүүдийг логик зарчмын үүднээс авч үзэж, тухайн асуудлыг илүү оновчтой авч үзэх үүднээс харьцуулалтын арга, нийгмийн асуудлыг тодорхой болгох үүднээс анализ, синтезийн арга, мөн тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт тэдгээрийн ойлголтыг системтэйгээр судлах үүднээс системчлэх аргыг хэрэглэсэн болно.

Судалгааны хүрээ. Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг хэрхэн барагдуулж байгаа талаарх Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд эдийн бус хохирол буюу сэтгэл санааны гэм хор, хохирлыг хэрхэн тооцож барагдуулж байгаа туршлага болон сонгож авсан гадаадын зарим улсын туршлага эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан судалж эдийн бус гэм хорыг тооцох аргачлал, шалгуур зэрэг зарим онцлог зохицуулалтыг түүвэрлэн судаллаа.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

1.1. Хууль тогтоомжид хэрэглэгддэг “гэм хор”, “хор уршиг”, “хохирол”

Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор зөрчигдсөн эрхийг хамгаалах, Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах үзэл баримтлал, иргэний эрх зүйн хохирол арилгахаас өмнөх байдалд эрхийг сэргээх¹ үндсэн зарчимд тус тус нийцнэ. Хүний эрх, эрх чөлөө нь хууль зүйн олон эх сурвалжтай учир хүний салшгүй болон бусад эрх, эрх, чөлөөг Үндсэн хуульд жагсааж бичээгүй, харин тэр бүхний үндсийг нь бэхжүүлсэн онцлог бий² болсонд оршино. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлын талаарх ойлголтыг тайлбарлахын тулд гэм хор, хор уршиг, хохирол хэмээх нэр томъёонуудыг эрх зүйн онолын түвшинд тайлбарласан эрдэмтдийн тайлбаруудыг авч үзье.

Иргэний эрх зүй дэх гэм хор түүнийг хэрхэн төлж арилгах арга хэлбэрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь сэтгэл санааны гэм хор байдаг.³ Сэтгэл санааны гэм хор гэдгийг тодорхойлохын тулд юуны өмнө гэм хорын тухай онолын тайлбарыг авч үзье.

Хуульд “гэм хор” гэсэн ойлголтыг тодорхойлж өгөөгүй. Гэм хор нь субъектийн амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчсөн явдлаар илэрдэг.⁴ Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт “хохирол” гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Гэм хор ба хохирол гэсэн нэр томъёо нь хоорондоо яг нийцдэггүй. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн эрхийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ⁵ гэж үздэг. Хохирлын гол шинж нь тооцож хэмжиж болохуйц байдаг.

1 Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2011 он. 112 дахь тал.

2 Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага. УБ., 2017 он. 194 дэх тал.

3 Б. Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (УБ, 2011),

4 Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал I дэвтэр (УБ, 1999), 89 дэх тал.

5 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (УБ, 2007), Адмон хэвлэл, 138 дахь тал.

Хор уршиг гэдэг нь арилгах болон нөхөн төлөх боломжгүй, ирээдүйд үр дагавар нь бий болох, гинжин хэлхээ мэт үргэлжлэн бий болох сөрөг үр дагавар байна гэж үздэг. Хохирол мөн эсэхийг тодорхойлоход эргэлзээ гарвал “тухайн гэмт хэрэг үйлдэгдээгүй бол, гэмт хэргийн халдлагад өртөөгүй бол энэ хохирол учрах байсан уу” гэдэг асуултад хариулах замаар тодорхойлох боломжтой юм.⁶

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд “Гэмт хэргийн хор уршиг гэдэг бол тухайн үйлдэл, эс үйлдэхүйгээс нийгмийн харилцаанд учруулсан хохирол бөгөөд тэр нь материалын, оюун санааны, улс төрийн, ёс суртахууны зэрэг олон хэлбэртэй байж болохоос гадна тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний зөрчлийн онцлогтой уялдаж их хэмжээний; ноцтой; үлэмжхэн; бага бус; хүнд; хүндэвтэр; хөнгөн гэх мэт олон хэлбэртэй байж болох” тухай бичжээ.⁷ Ингэснээр хор уршиг хохирлыг адил гэж үзсэн байна.

Доктор Б.Бат-Эрдэнэ гэмт хэргийн хохирлыг; нэр төр, алдар хүнд, санаа сэтгэлийн; бие махбодын; эд хөрөнгийн; гэж ангилан авч үзсэн байдаг.⁸ Эдийн бус гэм хор гэдэгт эдийн бус баялаг, хувийн эрх нь зөрчигдсөн байдлыг ойлгож болно. Эдийн бус баялагт амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц зэрэг орно. Эдийн бус хувийн эрх гэдэгт оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, зохиогчийн эрх, өөрийн нэрийг хэрэглэх эрх зэрэг орно.

Хохирол гэдэгт аливаа этгээдийн үнэт зүйлс нь түүний хүсэл зоригийн эсрэг устсан, дордсон, муудсан явдлыг ойлгож болно.⁹ Өөрөөр хэлбэл дараах гэмт хэргийн улмаас шалтгаалан сэтгэл санааны хохирол бий болдог байна. Тухайлбал, Ойр дотны хүмүүсийн амь нас хохирсон, өөрт нь болон ойр дотны хүмүүст хүнд гэмтэл учирсан, амьжиргааны эх үүсвэрээс салсан, их буюу онц их хэмжээний эд хөрөнгө нь устгагдсан, амь биед нь аюултай гэмтэл учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс нь хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүр мөсөн алдагдуулсан, эрхтнээсээ хагацсан, ураг зулбасан, хүүхэд дутуу төрүүлсэн, хохирогч байнгын тахир дутуу болсон, төрөл садан нь нас барсан, сонгуульд нэр дэвшихэд илтэд сөрөг нөлөө үзүүлсэн, эцэг, эх нь сэтгэл мэдрэлийн эдгэршгүй хүнд өвчнөөр өвчилсөн, амиа хорлосон, үр хөндүүлэхэд хүргэсэн, гэмт хэрэг нь гэр бүл цуцлах шалтгаан болсон, дахин хүүхэд төрүүлэх боломжгүй болсон, хохирогч орон гэргүй эсхүл ажлын байргүй болсон, халдварт өвчин тархсан түүнтэй холбоотойгоор онц их хэмжээний хохирол учирсан, аж ахуйн болон албаны үйл ажиллагаа удаан хугацаагаар саатсан гэх мэт олон ноцтой үр дагаврууд араасаа шууд сэтгэл санааны хохирлыг дагуулж байдаг. Үүнийг судлаачид сэтгэл санааны хохирлын презумпци гэж үздэг. Үнэхээр ч аливаа гэмт хэрэг зөрчил шууд 2 давхар объектыг /эдийн болоод эдийн бус баялаг, сэтгэл санааг/ нэрвэж байдаг байна.

6 Жанцан.С (2009) Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол I боть УБ., (358).

7 Г.Совд, Эрүүгийн хуулийн тайлбар. УБ.,(2002) 25 дахь тал.

8 Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй., (1 Ерөнхий анги), УБ., 1996. 86 дахь тал.

9 Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн тусгай анги. УБ., 2011 он. 110 дахь тал.

Амь нас хохирсны улмаас нэгдүгээрт хүний амь нас эрсэддэг бөгөөд нас барсан хүнийг амьдруулах, түүнд учирсан хохирлыг арилгах гэсэн ойлголт мэдээж байж болохгүй харин нас барсан этгээдийн ар гэр, ойр дотны хүмүүс үүнээс үүдээд сэтгэл санааны гүн их хохирлыг амсдаг. Энэ ч утгаар нь авч үзэх юм бол хоёр төрлийн хохирогчтой хэрэг гэж үзэж болно.

Бусдын амь нас, хохирсон хохирлын улмаас бий болж байгаа зовиур, шаналлыг биеэрээ мэдэрч байгаа этгээд нь түүний ар гэрийнхэн, ойр дотных нь хүмүүс байдаг.

Хохирлыг нөхөн сэргээх боломжгүй бол хохирогчийн сэтгэл санаанд учирсан бодит хохирлыг арилгах замаар мөнгөөр хохирлыг барагдуулж болно. Учир нь хүнд бэрх сэтгэл санааны хохирлыг бага ч болов мөнгөн төлбөрөөр орлуулах нь аливаа зөрчил гаргасан этгээд бүхий л хохирлыг хариуцах үндсэн зарчимд нийцнэ.¹⁰

Хохирлыг мөнгөөр төлүүлэх нөхөн төлүүлэх явдал нь өмнөх зөрчигдсэн эрхийн үргэлжлэл болж өгдөг. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол арилгах шаардах эрх холбогдох этгээдийн субъектив эрх, үнэт зүйлсийг зөрчсөнөөр л үүснэ. Тиймээс аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас тодорхой гэрээний үүрэг, эсвэл хамгаалагдсан эрх, үнэт зүйлд хандсан байх явдал бол хохирол шаардах эрх үүсэх анхдагч нөхцөл бүрддэг. Иймээс энэхүү шаардах эрх нь эрхийг өмнөх байдалд нь сэргээхэд чиглэх тул эрх зүйн үүднээсээ хохирол арилгаж буй явдал өөрөө тухайн эрхийн үргэлжлэл болох чиг үүрэгтэй¹¹.

1.2. Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол

1. УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлоос хамгаалах, хохирлыг барагдуулдаг болох талаар дараах байдлаар тусгасан байна.

Д/д	Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт сэтгэл санааны хохирлын талаар тусгасан нь:
1.	Гэм буруугүй хүнийг үндэслэлгүйгээр түр саатуулах, баривчлах, хорьж мөрдөх, торгож шийтгэх зэргээр эрхийг нь ноцтой зөрчсөнд хүлээлгэх хариуцлагыг хүчтэй болгох, эрүүл мэнд, сэтгэл санааны болон эдийн хохирлыг төр хариуцан арилгах журмыг гуйвалтгүй биелүүлэхийн хамт иргэний гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэсэн шалтгаанаар хувь хүнд төрийн албадлага хэрэглэх, ял хэлэлцэхийг хориглон зогсооно /1.1.3.8/.
2.	Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хүн бүрийн бие, сэтгэл санааны халдлага, дарамтаас хамгаалуулах эрхийг хангах нөхцөл, нийгэмшил эрх зүйн орчин бүрдүүлнэ /2.1.2.1/.
3.	Иргэний хувийн болон захидал харилцаа, гэр бүл, эрүүл мэнд, эд хөрөнгийн нууцыг задруулсан тохиолдолд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ хохирогчид нөхөн төлбөр олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх, хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял эдэлсэн хүмүүст эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөхийн зэрэгцээгээр хилсээр хоригдсон хоног тутамд ногдох сэтгэл санааны төлбөрийн хэмжээг тогтоож мөрдүүлнэ /2.1.3.4/.

10 Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн тусгай анги. УБ., 2011 он. 112 дахь тал.

11 Б.Буянхишиг. “Үүргийн эрх зүй (Ерөнхий анги)”, УБ., 2013 он 236 дахь тал.

Монгол Улсын хууль тогтоомжид “эдийн бус хохирол хэмээх нэр томьёо манай эрх зүйн тогтолцоонд аль хэдий нь хэрэглэгдэж, хуульд тусгагдсан боловч үндсэн агуулга, зарчмын хувьд бүрэн тодорхойлогдож шүүхийн практикт хэрэглэгдэхгүй байгааг дурдах нь зүйтэй¹² гэж заасны дагуу гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол болох сэтгэл санааны хохирлыг арилгах, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нэлээд төвөгтэй нэг мөр хараахан болж чадаагүй байгаа нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар хууль шүүхийн байгууллагад хандаж байгаа иргэдийн эрхийг хангах асуудал бүрэн эцэслэн шийдвэрлэгдэж чадахгүй хохироосон орхигдсон хэвээр байна.

Эрдэмтэн судлаачид эдийн бус хохирлыг янз бүрээр авч үздэг боловч ерөнхийдөө эдийн бус хохирол гэдэг нь “бусдын хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчснөөс бий болж байгаа нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй болон бие махбодын сөрөг үр дагавар юм” гэсэн үзэл дээр санал нэгддэг ажээ.

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт “Эдийн бус хохирол гэдэг нь материаллаг бус бүх хохирлыг хэлнэ хэмээн тайлбарлаж, бие эрхтэн болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох” зэргийг хамруулсан байна.¹³

Мөн өмнөх 2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие махбод, эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэж тодорхойлсон нь үндсэндээ эдийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан агуулга бүхий шинэлэг зохицуулалт нь тухайн үедээ эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататгасан нь Монголын эрх зүйн шинэтгэлийн явцад бий болсон чухал алхам болж чадсан юм.

Гэхдээ дээрх нэр томьёог хэт явцуу хүрээнд тодорхойлноос үүдэн эдийн бус гэм хорд хамаарах сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх боломж хязгаарлагдах зэрэг үндсэн эрхийн зөрчил одоог хүртэл оршоор байна.

Эдийн бус гэм хор хэмээх ойлголтод сэтгэл санааны хохирол багтах ба сэтгэл санааны хохирол гэдгийг юу гэж ойлгохыг хуульд тусгайлан зохицуулж өгөөгүй байна. Сэтгэл санааны хохирлыг тодорхойлохын өмнө сэтгэл санааны хямрал хэмээх ойлголтыг тодорхойлох шаардлагатай.

Сэтгэл санааны хямрал буюу дистресс¹⁴ гэдэг нь бусдын хууль бус үйлдлийн үр дүнд үүсэх сэтгэл санааны, оюуны зовлон, шаналлыг хэлэх бөгөөд уй гашуу, сэтгэл гонсойх, уур уцаар, бахархал үгүй болох, ичих, олон нийтийн доромжлол, цөхрөл зэрэг хамаарах¹⁵ ба дээрх хямрал нь сэтгэл санааны хохирол болно.

12 УДШ-ийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Дугаар 592 тогтоол УДШ-ийн 2018 оны 02 сарын 02-ны өдрийн Дугаар 169 тогтоол, УДШ-ийн 2019 оны 05 сарын 14-ны өдрийн Дугаар 692 тогтоолуудыг судлан, дүн шинжилгээ хийж үзэхэд эдийн бус гэм хор хэмээх ойлголтод зөвхөн бусдын нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамааруулан ойлгож байгаа бөгөөд харин бусдын буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас бие махбод, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учирснаас бий болох сэтгэл санааны хохирлыг иргэний хуульд тусгайлан заагаагүй гэж үзэж эдийн бус гэм хорд багтаан ойлгохгүй байна.

13 Иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/, УБ., 2005 он. 1034 дэх тал

14 Англиар “Emotional distress, mental harm, mental distress, mental suffering, mental anguish” гэх зэргээр томьёолсон байна.

15 Black' law dictionary 542 дахь тал.

Сэтгэл санааны хохирлыг дараах байдлаар ангилж үзэж болох юм. Үүнд:

1. Эд хөрөнгийн хохирлоос үүссэн сэтгэл санааны гэм хор
2. Эдийн бус хохирлоос үүссэн сэтгэл санааны гэм хор
3. Ёс суртахууны байдлаас үүссэн сэтгэл санааны гэм хор гэж ангилж болох талтай¹⁶ байна.

Эдийн бус иргэний харилцаатай холбоотой асуудлыг мөн дараах байдлаар ангилж авч үзэж болох талтай. Үүнд:

1. Эд хөрөнгийн эдийн бус харилцаа
2. Эд хөрөнгийн бус амины харилцаа гэж 2 үндсэн хэсэгт хуваан авч үзэж боломжтой байна.

Эд хөрөнгөтэй холбоотой эдийн бус харилцаа гэдэг нь шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмч болох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, аж ахуйн нэгжийн нэр, барааны тэмдэг, газар зүйн заалттай холбоотой эрхэд чиглэсэн харилцаа багтдаг. Тухайлбал, зохиогчийн эрхийг хуулиар хамгаалснаар зохиогч уг бүтээлээ хэвлэн нийтлэх онцгой эрхийг эдэлж, олон нийтэд, бүтээлээ хэвлэн нийтэлснээс олох орлогыг өмчлөх эрхтэй болно.

Мөн тодорхой аж ахуйн нэгжийн нэр, барааны тэмдэг зэргийг өөр этгээд ашигласнаар ажил, үйлчилгээний хүрээгээ тэлж, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болдог. Дээрх харилцаа нь тодорхой эдийн баялаг бий болгоход чиглэсэн байгаа боловч эдийн бус шинж нь голлож байна.

Эд хөрөнгөтэй холбоогүй эдийн бус харилцаа нь тодорхой бүтээлийг эзэмших зохиогчийн эрх нь зохиолоо ашиглан ашиг, орлого олдог эсэхээс үл хамааран тухайн бүтээлийг зохиогчийн зөвшөөрөлгүй засварлах, өөрчлөх, худалдах зэргээр “Хувь хүний халдашгүй байдал”-д халдах халдлагаас хамгаалуулах хууль зүйн баталгаа болдог. Энэхүү хамгаалуулах эрх эдийн баялагтай холбоогүй эдийн бус харилцааны хүрээнд илүү хамаарна.

Эд хөрөнгийн бус амины харилцаа нь нь эдийн бус харилцаанд хамаарах дараагийн төрлийн харилцаа нь тухайн хүний хувийн байдалтай салшгүй холбогдох эдийн бус эрх, эрх чөлөөтэй холбоотой үүсэх амины эрхийн харилцаа юм. Энэхүү амины эрхийн харилцаанд “нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд”, “хувийн ашиг сонирхол” “хувийн амьдрал, захидал харилцааны нууц” зэрэг амин хувийн ашиг сонирхолтой холбогдох харилцаа багтдаг. Хэдийгээр уг харилцаа нь мөнгөн “эквивалент”¹⁷ шинж байхгүй буюу илэрхий эдийн засгийн агуулгагүй боловч өөрийн гэсэн үнэ цэнтэй байдаг. Эдгээр нь субъектээс салшгүй шинжтэй байдаг учраас “амины” гэж нэрлэгддэг.¹⁸

16 Магистрант Г.Мягмарсүрэн. “Сэтгэл санааны гэм хор, түүнийг арилгах зам” сэдэвт магистрын зэрэг горилсон дипломын ажил.2013 он

17 Адил тэнцүү үнэ цэнэтэй байх гэсэн агуулгатай.

18 Ж.Оюунтунгалаг. Иргэний эрх зүй I., Ерөнхий анги, УБ., 2020 он х. 30-31 дэх тал.

1.3. Сэтгэл санааны үр дагавар ба сэтгэл мэдрэлийн эмгэг өвчлөл

Улсын Дээд шүүхээс 2000 оны 6 дугаар сарын 25-ны өдөр гаргасан зөвлөмжид хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар гэдэгт нийгмийн амьдралд идэвхтэй оролцож чадахгүй болох, ажлаас халагдах, шагнал, урамшлаас хасагдах, гэр бүл, захидал харилцаа болон өвчний нууц алдагдах, гэр бүл, эцэг эх үр хүүхдийн сэтгэл санаанд нөлөөлөх, сэтгэцийн гутралд орох, ажил сургуульдаа явж чадахгүй байх, гудамжинд гарахдаа олон түмнээс ичих зэргээр сэтгэл санааны таагүй байдалд орсон байхыг ойлгоно.

УДШ-ийн 2006 оны 45 дугаар тогтоолд сэтгэл санааны үр дагавар гэдэгт ... хууль бус ажиллагааны улмаас зовон тарчилсан, сэтгэл зүйн дарамтад орсон, айж балмагдсан, сэтгэлийн гутрал, сэтгэлийн өвчин эмгэгтэй болсон, нэр төр, алдар хүндээрээ хохирсон зэргийг ойлгоно. Сэтгэл санааны хохирлын үр дагавар болох сэтгэл зүйн гэм хор буюу сэтгэл мэдрэлийн эмгэг, өвчлөлийг бид судалж ялгаа заагийг тогтоох шаардлага үүсэж байна. Сэтгэц мэдрэлийн өвчнийг дагнан судалдаг судлаачид хүний бие болон оюун санаа, мэдрэлийг хоорондоо харилцан үйлчлэл бүхий нөлөө үзүүлдэг гэдгийг судлан хөгжүүлж эхэлсэн.¹⁹ Энэ үүднээс сэтгэл санааны хямрал нь үүсэн бий болохдоо бусдын учруулсан эдийн болон эдийн бус хохирлоос үүдэлтэй байдаг гэж үзэж болно. Эрүүл мэнд гэдэг нь хүнд зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие бялдар, сэтгэц оюун санаа, нийгмийн сайн сайхан байдлын цогц бүрдлийг хэлнэ.²⁰ Үүнээс харахад эрүүл мэндийг бие махбодын болон нийгмийн, сэтгэцийн эрүүл мэнд гэж 3 бүрэлдэхүүнд хуваан авч үзэж байна. Сэтгэцийн эрүүл мэнд гэсэн ойлголтыг ихэнх хүмүүс сэтгэцийн өвчин эмгэгтэй холбон андуу ташаа ойлгодог. Гэтэл сэтгэцийн эрүүл мэнд гэдэг нь маш өргөн хүрээний ойлголт юм. Тухайн хүний сэтгэхүй, сэтгэл хөдлөл, оюун санаа, бие хүний хувьд ямар нэг эмгэггүй байхыг хэлдэг.²¹ Гэтэл бусдын учруулсан эдийн болон эдийн бус хохирлын улмаас сэтгэл санааны хямралтай байгаа хүнийг эрүүл хүн гэж үзэх үү эсхүл түр зуурын стресс гэж үзэх үү гэдгийг бид анзаарах шаардлага үүснэ. Аль ч тохиолдолд хүн эрүүл бус байна гэж үзнэ. Учир нь сэтгэл санааны хямрал нь өөрөө стрессийн нэг хэлбэр юм. Гэнэтийн санамсаргүй, урьдчилан төлөвлөөгүй аливаа тааламжгүй явдлуудаас болж сэтгэл санаа, бие махбод доройтон хямрахыг стресс гэнэ.²² Стрессийг эустресс, дистресс гэж ангилан үздэг.²³

Эустресс гэдэг нь баярлах, инээх, сэтгэл ханах, сэтгэл догдлох, хөөрч баярлах, хайрлах зэрэг эерэг сэтгэл хөдлөл үүсгэдэг стрессүүдийн хэлбэрүүд ордог. Харин Дистресс гэдэг нь гомдох, уурлах, бухимдах, уйтгарлах, айх, ичих гэх мэт сөрөг сэтгэл хөдлөлүүд үүсгэдэг стрессүүдийн хэлбэрүүд багтдаг байна.²⁴ Хүний гадаад юмс үзэгдэлд ямар байр суурьтай байгаа, сэтгэл мэдрэмжийн дотоод хандлагаа илэрхийлэн гаргах хэлбэр бол хүний сэтгэлийн хөдөлгөөн юм.

19 Betsy J6 Grey, The Future of Emotional Harm, 83 Fordham L. Rev. 2605 (2015). 2624 дэх тал.

20 Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв. "Стрессийг үүсгэх шалтгаан ба оношилогоо, тусламж: Мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага". УБ., 2010 он 11 дэх тал.

21 Мөн тэнд 11 дэх тал.

22 Мөн тэнд 15 дахь тал.

23 Мөн тэнд 16 дахь тал.

24 Мөн тэнд 16 дахь тал.

Сэтгэцийн байдал бол орчны юмсад үнэлэлт дүгнэлт өгөх, баримжаалах үүрэгтэй.²⁵ Сэтгэлийн хөдөлгөөн энэ үүргээ гүйцэтгэхдээ эерэг болон сөрөг олон янзын хэлбэрээр илэрхийлнэ.²⁶

Сэтгэл санааны хямралд өртсөн этгээдэд сэтгэлийн хөдөлгөөн сөрөг хэлбэрээр илрэх ба гашуудах, нойргүйдэх, сэтгэлээр унах, сэтгэлийн шаналал, зовлонтой байх, цөхрөх, айх, уурлах, сэтгэлийн түгшүүртэй болох, санаж мартаж зэрэг хэв шинжтэй байдаг. Иймд дээрх судалгаа дүгнэлтүүдээс үзэхэд сэтгэл санааны хохирол нь бие махбодид хохирол учрахтай адил сэтгэцийн гэмтлийг үүсгэдэг бөгөөд бие махбодын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэж дүгнэж болохоор байна. Дээрх үзэл баримтлалтай холбогдуулан хувь хүний оюун санаа, сэтгэл амар тайван байх ашиг сонирхлыг хууль зүйн хувьд бие даасан байдлаар хуулиар зохицуулж хамгаалахыг хүлээн зөвшөөрсөн.²⁷ Шүүхийн хувьд хэд хэдэн шинж, урьдчилсан нөхцөлийг хангаж байгаа тохиолдолд сэтгэл санааны хохирлыг нөхөн гаргах боломжтой гэж үзсэн. Үүнд:

1-рт; Санаатай болон болгоомжгүй гэм буруутай байх,

2-рт; Үйлдэл нь жигшим зэвүүцмээр, хэнд ч мэдэгдэхүйц сэтгэл санааны хохирол учруулах үйлдлээр илэрсэн байх,

3-рт; Дээрх үйлдэл нь нэхэмжлэгчид сэтгэл санааны хохирол учрах шалтгаан болсон байх юм.²⁸

Сэтгэл санааны хохирол учирсан эсэхийг тогтоох нэг үндэслэл нь хохирол учрахад гол шалтгаан болсон үйлдэл болон үр дагаврын хоорондын шалтгаант холбоо байдаг. Энэ талаар Блэйкийн толь бичигт тайлбарлахдаа хэдийгээр сэтгэл санааны хямрал үүссэнийг нэхэмжлэгч нотлох ёстой хэдий ч хариуцагчийн зэвүүцмээр, хэн ч харсан сэтгэл санааны хохирол учруулахуйц хүнд ноцтой үйлдэл нь өөрөө сэтгэл санааны хохирол бий болсон эсэхийг тогтооход ихээхэн үр дүнтэй юм гэсэн байна.

Аливаа хуулийн зөрчил нь хүний эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхэд халддаг, Сэтгэл санааны хохирол бол хүний эрхийн зөрчилтэй салшгүй холбоотойгоор гарч ирдэг. Гэмт хэргийн нийгэмд аюултай шинжийг тодорхойлдог нэг үндсэн хэмжүүр нь хохирол, хор уршиг, гэм хор байдаг. Өнөөгийн практикаас харахад гэмт хэргийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирол түүнтэй холбогдон гарсан бусад зардлын талаар тэр бүр нарийн тогтсон нэг ойлголттой хохирлыг тооцох аргачлалтай болж хараахан чадаагүй нь харагдаж байна.

Эдийн бус гэм хор гэдэгт материаллаг бус бүх хохирлыг хэлнэ. Энд тухайлбал, бие эрхтний болон сэтгэцийн хохирол, цаашлан амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна²⁹. Эдийн бус гэм хор хэмээх нэр томъёог явцуу байдлаар хуульд

25 Б.Батсайхан, М.Дэлгэржав. Ерөнхий сэтгэл судлал. Анхны хэвлэл. УБ., 2013 он. 212 дахь тал.

26 Б.Батсайхан, М.Дэлгэржав. Ерөнхий сэтгэл судлал. Анхны хэвлэл. УБ., 2013 он. 212 дахь тал

27 M.Lee Huffaker. Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama.2003 он.1003 дахь тал, Francis X Clinch and Jodie L. Johnson, Compensation of Emotional Distress in Montana: Distinctions between Bystanders and Direct Victims, 47 Mont. L. Rev. (1986). 1 дэх тал.

28 M.Lee Huffaker. Recovery for Infliction of Emotional distress: A comment on the mental anguish accompanying such a claim in Alabama.2003 он.1004 дахь тал,

29 Ё.Кают. Э.Шпанглер нар. “Монгол Улсын иргэний хуулийн тайлбар”. УБ., 2010 он. 458 дахь тал

зааснаар өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо мөнгөн хэлбэрээр бусдаар гаргуулах боломжгүй болж байгаа юм.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлээр зөрчлийн улмаас учирсан материаллаг хохирлыг тооцож төлүүлсний дараа ч хохирлоос үүдэлтэй хор уршиг арилахгүй үлддэг билээ. Хор уршиг нь өөртөө дараах шинжийг агуулсан ойлголт болно. Үүнд:

- “Ирээдүй рүү чиглэсэн
- Тасралтгүй үргэлжлэх
- Хохирогчийн ирээдүйн боломжийг алдагдуулсан
- Нөхөн төлөгддөггүй
- Арилдаггүй”³⁰ хохирол долгиосоор л үлддэг нь сэтгэл санааны хохирол юм.

Сэтгэл санааны хохирол нь гэм буруутай этгээдийн гэм буруугаас үл харгалзан аюул ихтэй зүйлсийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол, иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан хохирол, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол хуульд заасан бусад тохиолдол”,³¹ Эдгээрээс үзвэл сэтгэл санааны хохирол гэдэг нь эд хөрөнгийн хохирол болон эд хөрөнгийн бус хохирлоос үүссэн, сэтгэл зүйд бий болсон зовлон шаналал гэж ойлгож болохоор байна.

Онол, практикаас үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол, гэм хорыг дараах төрөлд хуваан үзэж болохоор байна. Үүнд:

1. Бие махбодын хохирол /Өвчин шаналал, зовиур гэх мэт/ буюу материаллаг гэм хорыг арилгах;
2. Сэтгэл зүйн буюу Сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр гаргуулах;
3. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлыг сэргээх.³² Үндсэн 3 төрлийн хохирол барагдуулах хэлбэрүүд байна.

ХОЁР. ЭДИЙН БУС ХОХИРОЛ БУЮУ СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРОЛТОЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 онд батлагдаж Монгол Улс нэгдэж орсноос хойш хүний эрхийн хэрэгжилтийг бүрэн хангасан эрхзүйн орчин бий болгох нийгмийн шаардлага зүй ёсоор бий болсон байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлийн 2.27 дахь заалт “Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй”,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5-д “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.”

30 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол (Сургалтын гарын авлага) 2008 он 10 дахь тал.

31 Л.Дарьсүрэн, “Эдийн бус гэм хорын маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэж буй практик асуудал”, Монголын төр, эрх зүй №1 (2014): 59 дэх тал.

32 Ц.Батчимэг, Б.Энхбаяр нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, (УБ, 2005), 72 дахь тал.

Мөн Пактын 14 дүгээр зүйлийн 6-д “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ” гэж заасан байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/34 дүгээр шийдвэрээр “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” батлагдсан байна.

2.1. Монгол Улсын хуульд байгаа эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлын талаарх эрх зүйн зохицуулалт

Хувь хүн болон хуулийн этгээдийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах талаар төрийн үүргийг хэрэгжүүлэх гол механизм нь хууль тогтоомж гарган хэрэгжүүлэх явдал билээ.

Сэтгэл санааны хохирол хэмээх нэр томьёо нь Иргэний хууль /2002/, Боловсролын тухай хууль³³ /2002/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017, 2019/, Гэр бүлийн тухай хууль /1999/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2016/, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль /2012/, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль /1996/, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай /1998/, Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр /2003/, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм /2007/ зэрэг олон тооны баримт бичигт тусгагдсан байна.

Монгол Улсын 1926, 1952, 1963 оны иргэний хуулиудад сэтгэл санааны хохирлын талаар тухайлан зохицуулаагүй байна. Түүнчлэн тухайн цаг үеийн УДШ-ийн тогтоол, бүтээлүүдийг судлан үзвэл хохирол нь зөвхөн “эд материалын”³⁴ байна гэжээ. Харин 1994 оны иргэний хуулийн 392 дугаар зүйлд сэтгэл санааны хохирлын талаар анхлан зохицуулжээ.

Эрх нь зөрчигдсөн Монгол Улсын иргэн нь өөрийн эрх, эрх чөлөөг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалах, түүний дотор учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13-т... нэр төрийг нь доромжилж болохгүй. 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх,... эрхтэй”³⁵ хэмээн иргэний эрхийг баталгаажуулж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж төрийн үүргийг хуульчилсан байна.

33 Сэтгэл санааны дарамт гэсэн нэр томьёо хэрэглэсэн,

34 Т.Дэндэв. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэлүүд. УБ., 1969. 19 дахь тал “БНМАУ-ын Иргэний хуулийн 318, 319, 320-р зүйлүүдийг шүүхээс хэрэглэх журмын тухай” 6/22 дугаар тогтоол.

35 Монгол Улсын Үндсэн хууль (УБ., 1992), Төрийн мэдээллийн эмхэтгэл. 1992 он №1

Монгол Улсад хуулийн хэрэгжилтэд учирч байгаа хүндрэл бэрхшээл нь гэмт хэргийн улмаас хохирсон хүний хохирол арилахгүй, зөрчигдсөн эрх нөхөн сэргээлгэхгүй байгаа нь нийгмийн болон хууль зүйн шинжлэх ухааны өмнө тулгамдсан асуудал болсоор байна.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний хувийн амьдралд, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хүний үндсэн эрх эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж хамгаалахаар заасан байна.

Монголчуудын ёс зүйн түүхэн уламжлалт өв соёлд “Эд хөрөнгөө алдвал багыг алдсанд тооц, нэр төрөө алдвал ихийг алдсанд тооц, эрүүл мэндээ алдвал бүгдийг алдсанд тооц” хэмээн хүнийг доромжлох гүтгэх гэмт үйлдлийн үр дагавраас болоод хүнд сэтгэл санааны гэм хор уршиг бас бий болох нь тодорхой юм.

Дээрх хуулийн үзэл баримтлалтай уялдуулан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуулиудад зохицуулсан байдаг.

Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө гэжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ сэргээн тогтоолгох эрхтэй гэж заажээ.

Эд хөрөнгийн хохирол /материаллаг хохирол/ нь гэм хорын мөнгөн хэлбэрээр тодорхойлогдсон үнэлгээ, хэмжээ гэж ойлговол эд хөрөнгийн бус буюу эдийн бус гэм хор /материаллаг бус/ нь хүний эрүүл мэндийг сарниулах, амь насыг хохироох, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдах, гутаах, доромжлох, хувийн нууцад халдах зэргээр тухайн субъектын амин хувийн эрхийг зөрчих явдлаар илэрнэ.

Эрх зүйт төр, иргэний ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцдаг бол эрх нь зөрчигдсөн иргэн өөрийн эрх, эрх чөлөөг хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр хамгаалах, түүний дотор учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

Иргэний эрх зүй дэх гэм хор түүнийг хэрхэн нөхөн төлж арилгах арга хэлбэрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь сэтгэл санааны гэм хор байдаг. Эрх зүйн тогтолцоонд хэн ч халдаж үл болох эрхүүдийг хамгаалах зорилгоор хуулиар хориглосон үйлдэл гэж байх ба энэ хоригийг давсан үйлдлийг эрх зүйн зөрчил гэж үзэх бөгөөд Иргэний хуульд ийм зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох тогтолцоог тусгасан ба зөрчлөөс үүдэн хохирол бий болох явдлыг гэм хор учруулах хэмээн нэрлэсэн байна.³⁶

Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Иргэний эрх зүйн харилцаа дараах үндэслэлээр үүснэ”, 8.1.5-д “Гэм хор учруулах.”

Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т “Иргэний эрхийг дараах аргаар хамгаална”, 9.4-д “Эдийн бус гэм хор арилгуулах.”

36 Б.Буянхишиг. Иргэний эрх зүй тусгай анги. УБ., 2011 он.

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй”, мөн зүйлийн 21.5-д “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.”

Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1-т “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнө байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй.”

Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.”

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1.-т “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөнд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.” Мөн хуулийн 497.3-д Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ... гэж заасан байдаг.

Монгол Улсын Иргэний хуульд төрийн албан хаагчийн болон төрийн буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирлыг арилгах талаар тусгайлан заасан байдаг. Тухайлбал,

Иргэний хуулийн 498 дугаар зүйл, 498.1-т “Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ. Мөн хуулийн 498.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана. Мөн хуулийн 498.4-т хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана гэж тус тус тусгайлан зохицуулсан байдаг.

Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-т “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. Мөн хуулийн 511.2 дахь хэсэгт “Эдийн бус гэм хорын хэмжээг мэдээ тараасан хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох” бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно. 511.3-т “Энэ зүйлд энэ хуулийн 21.4, 21.5, 21.6,- д заасан журам нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус зааснаас үзэхэд сэтгэл санаанд учирсан үр дагавар буюу сэтгэл санааны гэм хор нь эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэг үзүүлэлт болж байгаа нь харагдаж байна. Иймд манай хууль тогтоомжид заасны дагуу сэтгэл санааны гэм хорыг эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх аргаар арилгаж болох үндэслэл байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйл “Шүүхэд мэдүүлэх эрх”-ийн 3.1-т Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй буюу байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлнэ” гэж зааснаас үзэхэд хүний эрх зөрчигдвөл шүүхээр хамгаалах нь ойлгомжтой байна.

Гэтэл эндээс харахад сэтгэл санаанд учруулсан гэм хорын талаар дурдаагүй зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан эдийн ба эдийн бус хохирлыг гаргаж байгаа нь хүний эрхийг бүрэн хангаж чадахгүй байгааг харуулж байна.

Эдийн бус гэм хорийг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй хэдий ч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд үүрэг бүхий этгээд /гэм хор учруулагч/ эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр Иргэний хуулийн 230 дугаар зүйлд зохицуулснаас үзэхэд эдийн бус гэм хорыг арилгахад хамаарах хуулийн зохицуулалт нь “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд зааснаас өөрөөр эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг арилгах арга, хэлбэрийг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Иймээс Иргэний хууль, бусад хууль тогтоомжид эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх, арилгах талаарх хохирогчийн эрхийн хамгаалалт туйлын хангалтгүй хэрэгждэг гэж үзэхээр байна.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт: Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно, ... тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тус тус тооцохоор тодорхойлсон бөгөөд энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинжийг тодорхойлоход хамаарахаар зохицуулагдсан, харин гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн иргэний сэтгэл санаанд учирсан үр дагавар буюу хохирлыг тодорхойлоход шууд хамааралгүй гэж ойлгогдохоор байна.

2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1-д “Гэмт хэргийн хохирогч гэдэг нь гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг гэмт хэргийн хохирогч” гэж мөн хуулийн 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “...Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах

эрхтэй...” бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ” гэж хохирогчийн сэтгэл санааны хохирлыг шүүх хэргийн хамт хамтатган шийдвэрлэх талаар хуульчилсан бөгөөд “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” Улсын 2002 оны хуульд өгсөн Дээд шүүхийн тайлбарт 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолын 1.1-т “эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол гэдэгт эрүүл мэнд, нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд учруулсан гэм хорыг ойлгоно”³⁷ гэж тайлбарласан байгаа нь гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан эдийн бус хохирлыг нарийвчлан тогтоогоогүй, зөвхөн нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарласан байгаа нь харагдаж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.8 дугаар зүйл буюу “Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах”, мөн хуулийн 13.10 дугаар зүйл буюу “Хувь хүний нууцад халдах”, мөн хуулийн 13.11 дугаар зүйл буюу “Хувь хүний нууцыг задруулах” гэсэн тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогч нар өөрт учирсан эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг шаардан нэхэмжлэх, үндэслэлтэй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах талаар дараах хуулийн заалтуудад туссан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн /Дөчин тавдугаар бүлэг/ 45.1-д “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй”. /Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/, мөн хуулийн 45.4 дүгээр зүйлд “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй” гэх зэргээр эдийн бус хохирлыг нэхэмжлэх эрхийг хуульчилсан байна.

1999 оны Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт эд хөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл санааны хохирлоо буруутай этгээдээс гаргуулах тэгш эрхтэй,” мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчийн эрх, ашиг сонирхол хохирсон нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн тал өөрт учирсан материалын болон сэтгэл санааны хохирлыг буруутай этгээдээс Иргэний хуульд заасны дагуу гаргуулах эрхтэй” гэж зохицуулжээ. Гэр бүлийн тухай хуульд сэтгэл санааны хохирлоо шаардах боломжийг олгосон ч мөнгөн хэлбэрээр барагдуулах талаар тусгаагүй юм. Мөн сэтгэл санааны хохирлоо шаардах урьдчилсан нөхцөл нь гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчийн эрх, ашиг сонирхол хохирсон нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон байх ёстой. Хуулийн нөхцөлөөс үзэхэд сэтгэл санааны хохирлоо шаардах хүрээ хязгаар нь дээрх урьдчилсан нөхцөл байх юм.

37 Г.Мягмарсүрэн Сэтгэл санааны хохирлыг эргэн төлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь., Монголын төр, эрх зүй сэтгүүл., (02-2020)19-21 тал, мөн тэнд., Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл УБ., 2010 он 335 дахь тал

2016 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “Гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг”, мөн хуулийн 5.1.2-т “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” /цаашид “хохирогч” гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг”, Мөн хуулийн 6 дугаар бүлгийн 6.1-т Энэ хуульд заасан дараах үйлдлийг гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр гэж үзнэ. Мөн энэ хуулийн 6.1.2-т Сэтгэл санааны хүчирхийлэл, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ”, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Сум, багийн Засаг дарга хохирогч бие махбод, сэтгэл санааны хувьд ноцтой хохирол хүлээсэн, хохирч болзошгүй, эсхүл хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй гэж үзвэл хохирогч зөвшөөрөл өгсөн эсэхийг үл харгалзан харьяа сум, баг, хорооны нийгмийн ажилтанд, эсхүл сургуулийн нийгмийн ажилтанд мэдэгдэнэ.” Мөн энэ хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хүүхэдтэй хүнлэг бус хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.”

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд сэтгэл санааны хохирол бүү хэл ажилтан хохирлоо арилгуулах эрхтэй гэсэн ганц ч өгүүлбэр алга. Харин тухайн хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.4-д хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үед эрүүл мэнд нь хохирсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажилтны нэхэмжлэлийг шүүх хүлээн авч шийдвэрлэхээр харьяалал тогтоохдоо бусад хохирлыг орхигдуулж дахин хүний эрхийг хязгаарлажээ. Гэтэл өнөөдөр Монгол Улсад хамгийн ихээр хөдөлмөрийн салбарт боолчлол, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, аюулгүй байдал, эрүүл ахуй зөрчигдөх, тэгш бус шан хөлс олгох, алагчлах зэрэг олон ноцтой зөрчил гарч байгаа бөгөөд түүнээс улбаалсан сэтгэл санааны хохирлыг олон улсын гэрээгээр шийдвэрлэхээс өөр аргагүй болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 2-т зааснаар хөдөлмөрлөх нь иргэний журамт үүрэг боловч мөн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 4-т зааснаар хөдөлмөрлөх аятай нөхцөлөөр хангуулах үндсэн эрхтэй.

Орчин үед дэлхий нийтэд тулгарч байгаа хөдөлмөрийн харилцаанаас үүдэлтэй асуудал нэг нь ажлын байран дээрх дарамт шахалтаас үүдсэн сэтгэл санааны хохирлын асуудал хурцаар тавигдах боллоо. Монгол Улсын хувьд ажлын байрны дарамт шахалтын талаарх нарийвчилсан хууль, тогтоомжийн зохицуулалт учир дутагдалтай, хэрэгцээ шаардлага гарч байгаа гэж үзэх үндэслэлтэй байна.

Ажлын байрны дарамт, ажлын байранд дээрэлхэх зан үйлдэл нь хүний эрх, хүний аюулгүй, ая тухтай хөдөлмөрийн нөхцөлөөр хангагдах талаар хөдөлмөрлөх эрхийн ноцтой зөрчил юм. Ажлын байрны дарамт шахалтаас болж ажилтан ажлын байрнаасаа болж эрүүл мэндээ хохироох, сэтгэцийн гэмтэл, эмгэг өвчинтэй болох ёсгүй бөгөөд ажлын байрны дарамт нь тухайн хүний ажил мэргэжлийн байр суурь, хувь хүний нэр төр, үнэ цэнэ, ажлын бүтээмж болон ажил гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлдөг. Цаашлаад ажлын байрны дарамт шахалтад өртсөн хүн нь хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэг, өвчтэй болох, байнга шаналах, хохирогч амиа

егүүтгэх нөхцөл байдалд хүргэж болзошгүй ихээхэн хор хөнөөлтэй үзэгдэл бөгөөд олон судлаачид, байгууллагын судалгаанд үүнийг ажлын байрны аюулгүй байдлын эрсдэл төдийгүй нийгэм-сэтгэл зүйн эрсдэл гэж үздэг байна. Гадаадын зарим улс орнуудад ажлын байрны дарамт, ажлын байранд дээрэлхэх асуудлыг Франц, Норвеги, Польш, Швед, Австрали, Шинэ Зеланд зэрэг улсад хууль батлан гаргах замаар онцгойлон анхаарч гэм буруутай этгээдэд эрүүгийн ял шийтгэх, учруулсан гэм хорыг нь нөхөн төлүүлэх, хохирогчид сэтгэцийн болон нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээ үйлчилгээний үр нөлөөтэй арга замыг нэвтрүүлэх, турших зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO)-н хувьд ажлын байрны хүчирхийлэл гэж айлган сүрдүүлэх буюу бодит гэмтэл учруулах, амь насаа алдахад хүргэх, сэтгэл санааны хохирол болон сэтгэл зүйн гэмтэл учруулах, буруу хөгжил, эрх, боломжоос нь салгах үр дүнд хүргэсэн буюу хүргэх өндөр магадлалтай өөрийн, бусад хүн буюу бүлэг этгээдийн эсрэг биеийн эсрэг биеийн хүч буюу эрх мэдлийг санаатайгаар ашиглахыг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Хөдөлмөрийн тухай хуулийг үндэслэн хувь хүн хуулийн этгээдийн хооронд хийгдсэн ажлаас үндэслэлгүйгээр халагдсан гэж ажлаас халагдсан үндэслэлээ ажлын байрны дарамт шахалт, шахалтаас улбаалж ажилтан өөрөө хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох санал гаргах тохиолдол шүүхэд маргаан шийдвэрлэх ажиллагаанд үе үе тохиолдож байна. Энэ тохиолдолд ажилтан нь аргагүй байдалд орж ажлаас чөлөөлөгдөх өргөдөл гаргасан, эсхүл өөр зорилгоор гаргасан эсэхийг хянаж, хэргийн бодит байдлыг тогтоох нь шүүхийн гол анхаарах асуудал болдог байна.

Ажлын байран дахь дарамт, шахалт, доромжлол, гадуурхалтаас болж сэтгэл санаа эд материал хохирч байгаа хүмүүст дараах сэтгэл зүйн эмгэгүүд илэрдэг байна. Үүнд:

- Стресс, сэтгэл түгшилт, нойргүйдэлд, байнгын шаналал зовнол,
- Өөртөө итгэлгүй болох, өөрийгөө хүндлэхгүй болох, айж сандарч тэвдэх, шийдвэр гаргах чадваргүй болох,
- Ажиллах чадваргүй болох, ажлын гүйцэтгэл буурах, төвлөрөх чадвар сулрах,
- Дипресс болон тусгаарлагдах мэдрэмж,
- Бие махбодын гэмтэл согог үүсэх/Хавдар тусах/
- Гэр бүлийн амьдралын чанар буурах амьдрах хүсэлгүй болох,
- Их хүндэрсэн үед амиа хорлох,
- Ажиллах дур сонирхолгүй болох, ажилдаа ирэхдээ айдастай, цаашлаад тухайн ажлын байрыг орхих гэх мэт өөрчлөлтүүд гардаг байна.

Ажил олгогчийн зүгээс ажилтан буюу хохирогчид шууд халдсан үйлдлийн хувьд эрүүгийн журмаар шалгуулах, улмаар тухайн хууль бус үйлдлийг тогтоох боломжтой боловч сэтгэл санааны хувьд дарамт, шахалт үзүүлснээс болж ажлаас гарах өргөдөл гаргасан эсэх байдлыг тогтоох нь зайлшгүй шаардлага зүй ёсоор урган гарч байна. Энэ асуудлыг дотоодын хууль тогтоомжоор оновчтой зохицуулж өгөх нь хүний эрх, эрх чөлөө, тэгш эрх, шударга ёсонд бүрнээ нийцүүлбэл зохилтой.

Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох тухай болон мөн хуулийн 8 дугаар зүйлд хамтын гэрээ

хэлэлцээр байгуулах зарчмыг тодорхойлсон байна. Энэ заалт нь нилээд тунхаглалын шинжтэй өнөөгийн хөдөлмөрийн харилцааг зохицуулахад учир дутагдалтай байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн талаар дэлгэрэнгүй тайлбар гаргах явдал юм. Хэдийгээр Улсын дээд шүүхийн 2006 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 33 дугаар тогтоолд энэ талаар заасан боловч төдийлөн нарийвчилж өгөөгүй байна.

Мөн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд Бүтээлийн халдашгүй байдал болон зохиогчийн эдийн бус баялгийн бусад эрхийг зөрчсөн тохиолдолд..., зөрчигдсэн эрхийг зохих журмын дагуу сэргээн тогтоохыг эрх зөрчсөн этгээдээс шаардах тухай заасан боловч зохих журам нь дахиад явсаар Иргэний хууль руу орж ирнэ. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 15 дугаар зүйлийн /с/-д өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах эрх эдлэхийг зөвшөөрнө гэжээ.

Түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын талаарх нотлох баримтыг бүрдүүлээгүйгээс сэтгэл санаанд учирсан хохирлыг эрүүгийн хэрэгтэй хамтатган шийдвэрлэхгүйгээр шүүх уг хохирлыг иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдан шийдвэрлэж байна. Энэ нь хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээг хэрхэн тогтоох, үнэлэх арга замыг хууль тогтоомжид нарийвчлан хуульчлаагүйтэй холбоотой, нөгөө талаас зарим мөрдөгч хуульд заасан ажиллагааг дутуу дулимаг хийдэгтэй холбоотой юм.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай 2012 оны хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй” мөн хуулийн 15.2-т “Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө” мөн хуулийн 15.3-т “Хохирогчийн сэтгэл санааны хохирлын хэмжээг түүний нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэмжээг харгалзан шүүх тогтооно” гэж заасан байсан.

“Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох аргачлал” судалгаанаас үзэхэд хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох ажиллагаа огт хийгддэггүй болох нь тогтоогдсон байна. Иймд мөрдөгч нарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх талаарх ойлголт, ажлаа гүйцэтгэх идэвх, санаачилгыг бий болгох үүднээс “хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг арилгах нөхөн төлүүлэхэд шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх талаар” холбогдох ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимаас 2000 онд “эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх аргачлалын талаар зөвлөмж гарсан байна.

- Монгол Улсын дээд шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг зөвхөн Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасан хохирол, гэм хороор хязгаарласан учир сэтгэл зүйн хохирлыг шийдвэрлэх боломжгүй³⁸ гэх мэтээр хариулсан байна. Иймд бид хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах хуулийн зохицуулалтыг бий болгох зайлшгүй шаардлага тулгарч байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

38 Г.Мягмарсүрэн Сэтгэл санааны хохирлыг эргэн төлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь., Монголын төр, эрх зүй сэтгүүл., (02-2020)19-21 дэх тал.

Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол нэхэмжлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нэлээд төвөгтэй байна. Энэхүү зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн шинжлэх ухаанд чухал судлагдахуун болон оршиж байна. Энэхүү асуудлаар зарим судлаачид дараах дүгнэлтийг өгсөн байдаг. Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдийн бус хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоох ажиллагаа хийгддэггүй;
- Эдийн бус хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэх, уг хохирлыг мөнгөөр тооцон үнэлэх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болоогүй байна.³⁹

Монгол Улсын эрх зүйн орчинд сэтгэл санааны хохирлыг тодорхойлсон тодорхойлолт байхгүй зөвхөн нэр төр, алдар хүнд хэмээн ойлгогдохоор хуульчилсан байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг илтгэж байна.

Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас гаргасан /2014 оны байдлаар/ сүүлийн 3 жилийн хугацаанд гэрээний бус харилцаанаас үүссэн эдийн бус гэм хорыг арилгуулахыг шаардсан гомдол бүхий нэхэмжлэлтэй 246 хэрэг улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн байгаа нь гэм хор учруулснаас үүссэн хэргийн 6.2-9.8%-ийг эзэлж, эдийн бус гэм хор арилгуулахыг хүссэн хэрэг 2013 онд урьд онтой харьцуулахад 2.8-5% өссөн үзүүлэлттэй, эдийн бус гэм хорын хохирлыг нэхэмжилсэн хэргийн дийлэнх хувийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ мэдээлэл тараасан гэх нэхэмжлэл эзэлж байгаа талаар тэмдэглэсэн байдаг.⁴⁰

УДШ-ийн 2009 оны 15 дугаар тогтоолын 6.2.4 дэх заалтын “иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй. Иргэний хуулийн 21 дүгээр зүйл “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах”- тухай заалтуудыг зөрчсөн бол тус хуулийн 497, 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгана” гэж тайлбарласан зэргээс Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн зохицуулалт нь “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ мэдээлэл тараасантай” холбоотой учирсан хохирлыг арилгахтай хамааралтай гэж ойлгогдож байна.⁴¹ Уг тайлбар шууд утгаараа шүүхийн практикт хэрэглэгдэх бөгөөд тухайн хохирогч сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх боломжгүй байна.

Эндээс дүгнэхэд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсгийн “гагцхүү хуульд тусгайлан заасан...” гэсэн нөхцөл нь бидний үзэж байгаагаар холбогдох хуулиар сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар зөвшөөрөн зохицуулсан бол гэсэн агуулгыг илэрхийлнэ. Тийм ч учраас нэлээдгүй хуулиудад сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх талаар зөвшөөрсөн зохицуулалт тусгах болсон. Харин УДШ дээр дурдсан тайлбараараа “... эдийн бус

39 Н.Амарзаяа, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт”, Монголын төр, эрх зүй №2 (2014): 9 дэх тал.

40 2014 оны 12 дугаар сарын байдлаарх УДШ-ийн Иргэний хэргийн танхимаас гаргасан судалгаа.

41 С.Базарханд. Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах хууль зүйн үндэслэлийн зарим асуудал., Монголын төр, эрх зүй сэтгүүл., (№1-2018), мөн тэнд “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” УДШ-ийн 2009 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоол.

хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй...” гэсэн нэмэлт хязгаарлалт тогтоох замаар энэ төрлийн нэхэмжлэлийг шүүхээс шийдвэрлэх боломжгүй болгожээ. Мөн судлаачид тогтоолын дээрх заалт “... хүний эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарласан сөрөг талтай болсон⁴² гэж дүгнэсэн байна.

УДШ-ийн Иргэний хэргийн тэнхим Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгийг тайлбарлахдаа Эрүүгийн байцаан шийтгэх тухай 2002 оны хуулийн 388 дугаар зүйлийн 388.1-т, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуулийн 45.1. дүгээр зүйлийн 1-т “хууль зөрчсөн ажиллагаа”-ны эрх зүйн үр дагаврын талаар заасан боловч энэхүү ажиллагаанд холбогдох албан тушаалтны хууль бус үйлдэл бүхий ажиллагаа хамаарахаас гадна яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл шүүгдэгч, ял шийтгэсэн этгээдийг цагаатгасан бол хуулийн дагуу явагдсан ажиллагаа ч мөн адил хамаарна.

Учир нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрх зүйн презумпци нь иргэн бүрийг эрхийн үндэслэлгүй хязгаарлалтаас хамгаалах зарчим юм. Ийнхүү төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан, байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч ийнхүү зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй тохиолдолд дээрх эрхийн хязгаарлалт хууль бусад тооцогддог болно. Улмаар үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульд “хууль бус ажиллагаа”-нд хамааруулдаг байна.

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх тухай тусгайлсан зохицуулалт байхгүй байна гэж УДШ-ийн тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл ЭХХШТХ-ийн 45.1 дээр Сэтгэл санааны хохирлыг арилгуулах эрхтэй хэмээн заасан байна Гэхдээ үнэлэх тухай зохицуулалт байхгүй байна гэсэн тайлбар гаргасан байдаг. Энэхүү УДШ-ийн тайлбарыг буруу тайлбарласан байна гэж үзсэн. Тэд хариу тайлбарлахдаа Иргэний эрх зүйн хэм хэмжээ дотроо хоёр том хэсэгт хуваагддаг. Нэгдүгээрт: Нэгийг харьцах нь нэг утгатай зохицуулалт байна. Тухайлбал, Худалдах худалдан авах гэрээний дагуу өмчлөх эрх шилжүүлэх гэсэн тодорхой утгатай зохицуулалт байна Хоёрдугаарт нийтийн зан суртахууны хэм хэмжээнд харшлах буюу эрхээ урвуулан ашигласан гэм буруу гэдэг ойлголт байна. Мөн Иргэний хуульд ийм нэр томъёонууд байна. Ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ гэж үздэг. Өөрөөр хэлбэл нэгийг харьцах нь нэг гэсэн утгатай биш тухайн нөхцөл байдлыг шүүгч өөрөө үнэлэх байдлаар дүгнэлт өгдөг, түүний адилаар сэтгэл санааны үр дагаврыг үнэлэх нь шүүгч өөрөө үнэлэх, практик тогтоох бүрэн боломжтой байна. Бусад орны хувьд бол шүүгч нар нь өөрөө шийдээд хохирол барагдуулах бүрэн боломжтой байна. Хуульд нь заасан тусгайлсан заалт бол байхгүй гэсэн дүгнэлтийг өгсөн байна. Үүнээс үзэхэд шүүгч өөрөө хуульд заасан боломжоо үнэлэхгүй байна гэж үзсэн. 45.4 дүгээр зүйлд Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах мөн үгүйсгэсэн байна. Тухайлбал, Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан ба мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан сэтгэл санааны хохирлыг гаргуулах, үнэлэх талаар хуульд тусгайлан заагаагүй тул хохирол гаргуулах боломжгүй гэсэн нь нэг талаараа өрөөсгөл тайлбар болсон зохицуулалт гэж үзсэн байна.

42 А.Доржготов. Эдийн бус гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалт. “Гэм хор учруулснаас үүсэх үүрэг ба иргэний хууль хэрэглэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал” /Иргэний хуулийн 52-дугаар бүлэг/. УБ. 2012., 102 дахь тал.

Судлаачид болон шүүгч нарыг хамруулсан эдийн бус хохирлын талаарх хийгдсэн судалгааны тайлангуудаас харахад:

- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “эдийн бус хохирлыг нэхэмжлэх” эрхийг хуульчилсан боловч иргэний хуульд хохирлыг хэрхэн тогтоох, үнэлэх арга замыг хуульчлаагүй учир шийдвэрлэдэггүй;
- Мөрдөн байцаалтын шатанд сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох ажиллагааг хийдэггүй, яаж тогтоох нь тодорхой биш;
- Монгол Улсад сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох боловсон хүчин дутагдалтай, сэтгэл зүйн хохирлыг тусад нь авч үзэх ёстой гэсэн байр суурийг илэрхийлсэн байна.

Шүүхийн практикт иргэд зөвхөн өөрийгөө хамгаалаад зогсохгүй, нийгэм төр, засгийн газарт хандсан хүний эрхтэй холбоотой шаардлагуудыг тавьдаг болж эхэлж байгаа өнөө үед хүний эрхийг цогцоор, бүрэн хязгаарлалтгүйгээр, харилцан уялдаатай хамгаалах шаардлага тулгарч байна.

2.2. Зарим гэмт хэрэгтэй холбоотой хохирогчдын талаарх тоо баримт

Үндсэн хуулийн суурь зарчмууд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зөрчигдсэн эрхийг сэргээх зорилтод нийцэх үү гэдэг нь анхаарах ёстой асуудал болоод байна. Тухайлбал, улсын хэмжээнд “ноцтой” асуудал болоод буй хүчиндэх гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол багагүй хувийн эзэлж байна.

Монгол Улсад хүчиндэх гэмт хэргийн улмаас 2015-2017 онд 950 хүн хохирсны 936 эмэгтэй, 14 эрэгтэй хүн байна. Энэ хугацаанд 6 хүний амь нас хохирч, 262 хүн гэмтжээ. Нийт хохирсон хүмүүсийн 469 буюу 49.4 хувь нь буюу 18 хүртэлх насны хүн хохирчээ. Нийслэлийн эрүүл мэндийн газраас авсан тоогоор 2017 онд 10-18 хүртэлх насны 1633 хүүхэд жирэмсэлсэн гэсэн тоо мэдээ байна. Сүүлийн 3 жилийн байдлаар Монгол Улсад хүчиндэх гэмт хэргийн улмаас 14 эмэгтэй хохирсон бөгөөд орон нутагт 7, нийслэлд 7 оршин суудаг бөгөөд сурагч 6, оюутан 1, малчин 1, ажилгүй 3 байна. Насны байдлаар нь харуулбал: 7 хүртэлх насны 3, 8-17 насны 5, түүнээс дээш насны 6 хүн хохирсон байх бөгөөд 57,1 хувь нь бага насны эрэгтэй хүүхэд хохирчээ.⁴³ Гэр бүлийн орчинд буюу ураг төрлийн хүрээнд үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг: “Хүчиндэх” гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдсан хүмүүсийн 73 буюу 9,7 хувь нь “Ураг төрлийн хамааралтай” хүмүүс байна. Эдгээр хүмүүсийн 43.8 хувь нь хойд эцэг, 21,9 хувь нь төрөл садангийн хүн, 12,3 хувь нь хүргэн 10,2 хувь нь төрсөн эцэг нь байна.

Шүүхийн практикаас үзэхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болох өсвөр насны хүүхдүүдийн хувьд сэтгэл санааны буюу сэтгэц зүйн хувьд ноцтой уршиг учирсан байдаг. Сэтгэцийн эмч нарын дүгнэж байгаагаар өсвөр насны хүүхдэд сэтгэц, сэтгэл зүйн хувьд маш олон төрөл, хэлбэрийн эмгэг үүсдэг байх ба эдгээр нь эмчлэгдэхгүй бол эрүүл мэндэд ноцтой хохирол, хор уршиг /амиа хорлох, эдгэршгүй сэтгэцийн өвчтэй болох гэх мэт/ учруулахад хүргэдэг байна.

Бодит хэргийн практикаас үзэхэд хүчиндэх гэмт хэргийн бага насны хохирогчийн хувьд айдас түгшүүрт автах, зожгирах, сэтгэл гутралд орох зэргээр холимог хариу урвал бүхий дасан зохицолтын эмгэг, эдгэршгүй сэтгэцийн өөрчлөлтөд орох өвчтэй болж энэ нь бие даасан эрүүл мэндийн хохирлын төрөлд хамаарахгүй байх хэдий ч сэтгэл зүйн, сэтгэл заслын эмчилгээ зайлшгүй хийлгэх шаардлагатай болдог байна.

43 Нийслэлийн цагдаагийн газрын статистик мэдээлэл.

Энэхүү нөхцөл байдлыг сэтгэл санаанд хохирол, эсхүл хор уршиг учирсан гэж / эдийн бус гэм хор/ үзэхгүй байх үндэслэлгүй боловч эдийн бус гэм хорыг арилгах, хангах хуулийн тодорхой заалт юу вэ, тийнхүү хангах арга, аргачлал, шалгуур нь юу байх вэ, сэтгэл санааны хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр тогтоох тодорхой аргачлал, эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байгаа юм.

2.3. Монгол Улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй шүүхийн практик

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгахдаа Иргэний хуулиар сэтгэл санааны хохирлыг гаргах боломжийг хязгаарласан байдгаас Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шийдвэрүүд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэргийг үндэслэж сэтгэл санааны хохирлыг гаргажээ. Уг конвенцуудад 9 дүгээр зүйлийн 5-д Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй. 14 дүгээр зүйлд Эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тусгажээ.⁴⁴

Хан-Уул дүүргийн шүүхэд нэхэмжлэгч нарыг төлөөлж Хүний эрхийн үндэсний комисс гаргасан нэхэмжлэлдээ “шүүхийн тогтоолоор цаазаар авах ялаар шийтгүүлж маш хүнд байдалд орсон, нотлогдоогүй хилс хэргийн улмаас цагдан хорих төвийн байранд хохироосон гэж үзсэн бөгөөд шүүхээс “хэргийн нөхцөл байдал, хоригдсон хугацаа, хоригдсон нөхцөл” зэргийг харгалзсан байна.⁴⁵

Баянзүрх дүүргийн шүүхэд хүсэлт гаргагч сэтгэл санаанд учирсан хохирлоо “хилсээр гүтгэгдэж шалгагдаж, цочирдон балмагдаж, айж сүрдэн, гуньж гутран, хожим мартагдашгүй сэтгэл зүйн хүнд дарамтад орсон” гэж тодорхойлсон бөгөөд тус шүүхээс мөрдөгдөж, хоригдсон хугацааг харгалзан үзжээ.⁴⁶

Баянзүрх дүүргийн шүүхэд нэхэмжлэгчийг төлөөлж Хүний эрхийн үндэсний комисс гаргасан нэхэмжлэлдээ “ шүүхийн тогтоолоор цаазаар авах ялаар шийтгүүлээд цаазаар авхуулах ялтай хүмүүсийг тусгаарладаг өрөөнд байсан, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор гянданд ял эдэлсэн, нотлогдоогүй хилс хэрэгт урьдчилан хорих байранд хоригдсон” зэргээс сэтгэл санааны хохирол учирсан гэж нэхэмжилсэн бөгөөд шүүхээс “хэргийн нөхцөл байдал, хоригдсон хугацаа, хоригдсон нөхцөл” зэргийг харгалзан үзжээ.⁴⁷

Жишээ 1. Монгол Улсад 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль”, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ЭБШХ-аар зөвхөн хууль бусаар хоригдсон болон шийтгүүлсний улмаас учирсан эдийн бус хохирлыг арилгахаар зохицуулсан байна.

44 Ш.Оюунханд. Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ. Монголын төр, эрх зүй сэтгүүл., (03-2013) 37 дахь тал.

45 Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 07 тоот шийдвэр. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл /Иргэний хэрэг/. УБ. 2008. Цуврал 6., 49-57 дахь тал

46 Мөн тэнд 107-110 дахь тал.

47 Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн 2004 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 970 дугаар шийдвэр. Хүний эрхийн үндэсний комисс. Арван жилд /2001-2011/. УБ. 2011., 92-106 дахь тал.

“Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль”-ийг батлан, улс төрийн хилс хэрэгт шийтгүүлэн хэлмэгдэгчдийг цагаатган нэр төрийг хилс хэрэгт шийтгүүлэн хэлмэгдэгчдийг цагаатган нэр төрийг нь сэргээж, тэдэнд нэг удаагийн нөхөх олговор олгох, улс төрийн бусад үр дагаврыг арилгах асуудлыг зохицуулжээ.

Уг хуулиар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэн шийтгүүлсний улмаас учирсан хохирол /эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх зөрчсөн/-ыг нөхөх олговор хэлбэрээр нөхөн төлүүлэхээр тогтоосон бөгөөд уг нөхөх олговор буюу хохирлыг хэлмэгдэгч өөрөө, хэрэв өөрөө нас барсан бол түүнийг амьд байхад нь төрсөн болон үрчилж авсан, түүнчлэн хэлсэгдэгчдийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, ач зээ нар хуульд заасан дарааллын дагуу нэхэмжлэн авах эрхтэй. Харин хэлмэгдэгчдийн шийтгүүлсэн ялын төрлөөс хамаарч харилцан адилгүй нөхөх олговор олгохоор хуульчилсан нь хохирогчдын сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг харгалзан үзэх гэсэн шалгуур хийх гэж оролдсон өнгөц төдий зүйл болсон байна. Энэхүү хуулиар хохирогчдын болон хохирогчдын ар гэрийнхэнд учирсан сэтгэл зүй, сэтгэл санааны хохирлыг арилгахаар зохицуулсан хуулийг анх удаа баталсан нь хүний эрхийг дээдэлсэн, хүндэтгэсэн чухал алхам болсон хэдий ч хохирлын хэмжээг бодитой гаргаж тогтоолгүйгээр хохирлын үнэлгээг тогтоосон нь учир улс төрийн шийдвэр болсон.

Жишээ 2. Монгол Улсын шүүхийн практикт гарсан бас нэг сэтгэл санааны хохиролтой холбоотой шийдвэр бол Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхээр 2004 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хүний Эрхийн Үндэсний комиссын нэхэмжлэлтэй Санхүү эдийн засгийн яамны Төрийн сангийн газарт холбогдох хууль бусаар хоригдсоны улмаас үүссэн эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлын 53.699.225 төгрөг гаргуулах тухай хэргийг шийдвэрлэхдээ сэтгэл зүй, эрүүл мэндэд учирсан хохирлын шаардлагаас зарим хэсгийг буюу 16.000.000 төгрөгийг хангаж үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгосон байна.

Ийнхүү нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа ЭБШХ-ийн 331.3-ийн “эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно”, 391.3-ийн “сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу” гаргана гэдгийг үндэслэн хэргийн нөхцөл байдал байдал, хоригдсон хугацаа, нөхцөл, зэргийг харгалзан сэтгэл зүйн хохиролд 16.000.000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Харин нэр төрөө сэргээлгэж, 1 сая төгрөг гаргуулах тухай шаардлагыг хэрхэн шийдвэрлэсэн талаар шийдвэрийн үндэслэл болон тогтоох хэсэгт зааж өгөөгүй байна. Энэхүү хэргийг шийдвэрлэсэн байдлыг авч үзэхэд хэргийн нөхцөл байдал, хоригдсон хугацаа, нөхцөл зэргийг хэрхэн үнэлж, өөрөөр хэлбэл, хэргийн нөхцөл байдлыг яаж үнэлэх, хоригдсон хугацааны ямар хэмжигдэхүүн /цаг, хоног, сар, жил,/ бүрд хэдий хэмжээний хохирол учирсан гэж үнэлэх, мөн хоригдсон нөхцөл /хорих ангийн дэглэм хохирлын хэмжээнд хэрхэн хамаарах/- өөр хэрхэн хохирлыг үнэлэх гэх мэт тодорхой баримт зүйлгүйгээр шийдвэрлэсэн байдал хэргийг шүүх туйлын үнэн зөв нэг мөр шийдвэрлэсэн гэж үзэхэд учир дутагдалтай болсон байна.

Жишээ 3. Нэхэмжлэгч С нь “Ачтан-Элит” эмнэлгийн мэдрэлийн мэс заслын тасгийн хяналтанд нурууны зөөлөн эд дарагдсан оношоор 2 жилийн турш эмчлүүлж байгаад тус эмнэлгийн тасгийн эрхлэгч, эмч А.Нотагийн зөвлөснөөр уг эмнэлгийн урилгаар Герман улсаас ирсэн мэдрэлийн мэс заслын эмч гэх Зиерский, Хорацек нараар зөөлөн эд чөлөөлөх мэс заслыг 2007 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хийлгэсэн Эмч нарын алдааны талаар 2009 оны 5 дугаар

сарын 04-ний өдрийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч эмч Ц.Ганболдын 2242 дүгнэлт, мөн 2010 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 565 дугаар хамтарсан шинжээчдийн дүгнэлт гарсан бөгөөд энэ дүгнэлтүүд нь бүгд эмч нар хэт хайхрамжгүй байдлаар алдаа гаргаснаас зүүн гуяны артери судас гэмтэж /бөглөрч/ хиймэл судас залгахад хүрч С-ийн биед хүнд гэмтэл болон цаашид үр хүүхэд гаргах боломжгүй болсон хүнд хор уршиг учирсан. Тухайлбал, уг алдааны хор уршгаар зүүн гуяны артерид 20 см орчим хиймэл судас тавиулсан бөгөөд хожим тогтсон 8-9 долоо хоногтой жирэмслэлтийг дээрх шалтгаанаар 2009 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр эмч нарын зөвлөгөөн, хяналтын комиссын 320, “гол судасны гуяны артерийг холбосон протоз хагалгааны дараах байдал” гэсэн оношоор хүүхэд төрүүлэхийг амь насанд аюултай гэж үзэж, эмч нарын зөвлөгөөн, комиссын шийдвэрээр хориглож ургийг эмнэлгийн журмаар тасалсан. Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэс эмч өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж 4 жилийн турш шалгаад эмч Зиерский, Хорацек нар нь мэс заслын үйл ажиллагаанд голчлох буруутай гэж үзээд эдгээр эмч нарт холбогдох хэрэгт байцаан шийтгэх ажиллагааг “Герман Улсад явуулах боломжгүй” гэсэн үндэслэлээр хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Хохирогч С нь шүүхэд гаргасан тайлбартаа Хамгийн ноцтой хор уршиг нь сэтгэл санаа бие махбодоороо насан туршдаа хохироод зогсохгүй, үрийн зулай үнэрлэж, эх байх эрхээ хасуулан, тээж байсан ургаа авхуулж, эргээд хүүхэд төрүүлэх ямар ч боломжгүй болсон. Өөрийн бие махбод, сэтгэл санаа, үр хүүхэдтэй болох боломжгүй болсон гэм хорын хохиролд 50 сая төгрөг, эд хөрөнгийн хохиролд 31,098,432 төгрөг, нийт 81,098,423 төгрөгийг “Ачтан-Элит” эмнэлгээс нэхэмжилсэн байдаг.

Уг хэргийг Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс Нэхэмжлэгч С-ийн нэхэмжлэлийн шаардлагаас хавтаст хэрэгт авагдсан баримтуудыг үндэслэн түүний эм тариа авсан, нотариатын үйлчилгээ, ХБНГУ-д очиж эмчилгээ хийлгэсэн болон замын зардал, хөдөлмөрийн чадвараа 70 хувь алдсанаас дутуу авсан цалин хөлсний зөрүүнд 18,452,502 төгрөг, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар, эрүүл мэндийн байдлыг харгалзан хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2-т заасныг баримтлан сэтгэл санааны хохиролд 10 сая төгрөг, нийт 28,452,502 төгрөгийг “Ачтан-Элит” эмнэлгээс гаргуулан нэхэмжлэгчид олгон, үлдэх 51,866,653 төгрөгийг хэрэгсэхгүй болгож анхан шатны шүүхийн шийдвэр⁴⁸ гарсан байдаг.

Нийслэл дэх иргэний хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан үзээд Нэхэмжлэгч С нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1-д заасны дагуу өөрийн эрүүл мэнд, сэтгэл санаанд учирсан хохирлоо хариуцагчаас шаардах эрхтэй байх ба хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг татгалзаж байгаа үндэслэлээ нотолж чадаагүй байна. гэж үзэн анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь дэмжиж хэвээр нь үлдээсэн шүүхийн магадлал гаргасан байна.

Дээд шүүхийн шийдвэрлэсэн байдал нь Иргэний хэргийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан үүргийг хариуцагчид ногдуулахын тулд нэхэмжлэгчид гэм хор учирсан байх шаардлагатайгаас гадна хариуцагчийн үйлдэл эс үйлдлээр илэрхийлэгдсэн буруутай үйл ажиллагаа хоорондоо шалтгаант холбоотой байж, хариуцагч өөрийн үйлдэл, эс үйлдлийн үр дагаврыг мэдсэн, эсхүл мэдэх ёстой буюу гэм буруутай байх шаардлагатай болно. Нэхэмжлэлийн шаардлагын нэг болох сэтгэл санааны

48 Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 978 дугаар шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 568 дугаар магадлал, УДШ-ийн 2012 оны 10 сарын 11-ний дугаар 592 тогтоол.

хохирол буюу нэхэмжлэгчид хариуцагчийн үйлдлийн улмаас сэтгэл санааны хохирол учирсан гэж үзэх үндэслэлтэй бөгөөд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-д зааснаар хохирогч эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй боловч мөн зүйлийн 230.2-т “гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгах мөн хуулийн 511 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлыг арилгах асуудал зохицуулагдаагүй тул нэхэмжлэлийн шаардлагын энэ хэсгийг хангах боломжгүй тул нэхэмжлэлийн шаардлагын энэ хэсгийг хангах үндэслэлгүй юм гэсэн тогтоол гарсан байдаг.

Жишээ 4: Иргэн О-г 2005 оны гуравдугаар сарын 18-наас 2013 оны гуравдугаар сарын 27 хүртэлх найман жил, нэг сар, 12 хоногийн хугацаанд онц хүнд, хүндэвтэр гэмт хэргүүдэд холбогдуулан шалгажээ. Энэ хугацаанд нийт 276 хоног эрх чөлөөг нь хязгаарлан түүнийг цагдан хорьсон байдаг. Гэвч хожим хууль бусаар эрүүгийн хэрэгт шалгагдсан болох нь тогтоогдсон. Улмаар Хүний эрхийн үндэсний комисс иргэн О-г төлөөлөн, хууль бусаар эрүүгийн хэрэгт шалгагдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Хэнтий аймгийн сум дундын шүүхэд гаргасан юм. Шүүх Засгийн газрын нөөц сангаас 24 сая төгрөг гаргуулж, иргэн О-д олгохоор шийдвэрлэсэн. Товчхондоо, найман жил гаруйн хугацаанд эрүүгийн хэрэгт хууль бусаар шалгагдсан иргэн О-д учирсан бүхий л төрлийн хохирлыг төр 24 сая төгрөгөөр үнэлсэн нь энэ. Иргэн О-д тохиолдсон явдлаар хязгаарлагдахгүй ийм төрлийн хэрэг Монгол Улсад гарсаар байдаг. Хүний эрхийн үндэсний комиссоос жил бүр гаргадаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлд та, бидний амьдралд тохиолдож буй ийм бодит «жишээ»-нүүдийг дурдсан байдаг. Нэг талаар төр өөрийн буруугаа хүлээн зөвшөөрч, гэмээ цайруулж буй үзэгдэл боловч нөгөө талдаа хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг үнэгүйдүүлж буйн тод жишээ юм.

Дээрх үндэслэлд тулгуурлан хоёрдугаар бүлгийн агуулгыг товч дүгнэхэд:

Гэмт хэргийн хохирогчийн сэтгэл санаанд учирсан гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтыг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар хязгаарлах бус “сэтгэл санаа, бие махбодын хохирол” учирсан тохиолдолд мөнгөн хэлбэрээр тооцон нөхөн төлбөр авах эрхтэй байж болохоор агуулгыг өргөжүүлж өөрчлөлт оруулах,

- Эдийн бус гэм хорыг үнэлэх, арилгах журмыг буюу эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг хуульчлах,
- Гэмт хэргийн хохирогчийн сэтгэл санаанд учирсан гэм хорыг мөнгөн дүнгээр тооцох арга, аргачлалыг Иргэний хууль, холбогдох бусад хуульд тогтоомжид нийцүүлэн боловсруулж тодорхой болгох,
- Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.8, 13.10, 13.11 дүгээр зүйлд зааснаас бусад гэмт хэргийн хохирогчийн сэтгэл санааны гэм хорыг арилгах хуулийн зохицуулалт байхгүй хэдий ч зарим төрлийн гэмт хэргийн хувьд Иргэний хуулийн 505 дугаар зүйлийн 505.1-д /Эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах/ заасан “... зэрэг зайлшгүй бүх зардал” гэдэгт хамааруулан шийдвэрлэж болох зэрэг саналыг дэвшүүлж байна.⁴⁹

49 С.Базарханд. Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах хууль зүйн үндэслэлийн зарим асуудал., Монголын төр, эрх зүй сэтгүүл., (№1, 2018) 19 дэх тал.

Өнөөдрийн байдлаар манай улсад нийгмээс ирэх сэтгэл зүйн дайралт, дарамтыг хэрхэн тэсвэрлэж, нэр алдар, бие эрхтэнд учирсан хохирлоо яаж барагдуулах нь тодорхойгүй байна. Зөвхөн хуульд холбогдох заалтыг тусгаснаар сэтгэл санааны хохирлыг тооцох, барагдуулах эрх зүйн орчин бүрдсэн гэвэл өрөөсгөл ойлголт юм.

Өмнөх Эрүүгийн хуульд зөвхөн гэмтлийн зэргээр нь хохирлын хэмжээг тогтоодог байсан. Харин сэтгэл санааны болон бусад хохирлыг иргэний нэхэмжлэлээр хангуулдаг тогтолцоотой байсан. 2017 оны долдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуульд сэтгэл санааны хохирлыг тооцож олгохоор тусгасан. Гэхдээ сэтгэл санааны хохирлыг бүрэн тооцдог практик туршлага Монгол Улсад байхгүй байгаа нь хүний зөрчигдсөн эрхийг хамгаалах ёстой хуулийн үндсэн үзэл баримтлалтайгаа нийцэхгүй учир дутагдалтай өрөөсгөл байгаа юм.

Монгол Улсын хууль тогтоомжид ялангуяа ЭХХШТХ-иар хохирогчид олгосон эдийн бус хохирол нэхэмжлэх эрхийг зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлоор хязгаарлаж байгаа нь нийгмийн өнөөгийн нөхцөлд тохирохгүй болсон гэж үзэж байна.

Шүүхүүд дээрх байдлаар тайлбарлаж, хэрэглэж байгаа боловч сэтгэл санаанд бий болсон өөрчлөлт, зовлон шаналал, өвдөлт зовиурыг ердийн нотолгоогоор нотолж, үнэлэхэд бэрхшээлтэй байдаг. Иймээс сэтгэл санаа, бие махбодын зовлон зүдгүүрийг сэтгэл судлаач, эмнэлгийн нэрийн мэргэжлийн эмч нараар нэгдсэн дүгнэлт гаргуулж байх нь практикт тулгамдсан асуудал болж байна. Өөрөөр хэлбэл дээрх дүгнэлтийг зөвхөн шинжээч эмч нараар төдийгүй сэтгэл судлаачийг оролцуулан гаргуулах нь бодитой дүгнэлт болно гэж үзэж байна.

Мөн Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах зохицуулалтыг нэмж оруулах шаардлагатай байна. Тухайлбал, 511.2-т “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг сэргээн тогтоох арга нь тухайн мэдээний эсрэг няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгох” явдлаар хуульчилсан нь Иргэний хуулийн тэгш эрхийн болон мэтгэлцэх зарчмыг зөрчсөн гэж үзэж болохоор байна. Үүний талаар зарим судлаачид нотлох баримтын хуваарилалтын хувьд хариуцагчид гол ачааг үүрүүлсэн нь оновчтой болсон, хариуцагч өөрөө энэ маргааныг бий болгосон учир хариуцагч гол нотолгооны үүргийг хүлээх нь шударга болно гэж үзсэн байна. Энэ зарчмын хувьд тохиромжгүй шударга бус асуудал гэж байгаа тул нотлох үүргийг 2 талд тэнцүү хариуцуулах нь зүйтэй гэж зарим судлаачид үзсэн байна.

Иргэний хуулийн 230 дугаар зүйл нь “эдийн бус хохирол зөвхөн хуульд заасан нөхцөлд арилгах боломжтойг” дурдсан бөгөөд энэ нь мөн хуулийн 511 дүгээр зүйлээс өөр эдийн бус хохирол байхгүйг харуулдаг. Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 230 дугаар зүйл нь гагцхүү нэр төрийн болон дүрсийн эрхэд халдсанаас учирсан эдийн бус хохирлыг авч үзэхэд хүргэж байгаа бөгөөд дээрхээс бусад эдийн бус хохирлыг арилгуулах боломжгүй байдалд хүргэж байна.

УДШ-ийн хэрэг шийдэж байгаа практикаас харахад төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс үүссэн гэм хор хохирлыг нэхэмжлэхдээ хохирол нэхэмжлэх, нөхөн төлүүлэх шаардах эрхийн үндэслэл нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-г байна гэж үзэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйл 45.1-г хэрэглэхгүй Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн зүйл, заалтуудыг хэрэглэж хэргийг шийдвэрлэж байна. Дээрх УДШ-ийн Иргэний хэргийн тайлбарт МУИС-ийн багш ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш судлаач Н.Норовсамбуу, Монголын хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч Ж.Содномдаржаа нар дүн шинжилгээ судалгаа хийхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйл 45.1-г хэрэглэх нь зүйтэй юм гэж үзсэн байна.

Мөн УДШ-ийн тайлбараар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйл. Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах 1. “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй” гэх зэргээр эдийн бус хохирлыг нэхэмжлэх эрхийг хуульчилсан байна. Үүнийг тайлбарлахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн 1-д болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах эрхтэйг журамласан явдал нь тухайн нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл болохгүй юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь иргэний эрх зүйн маргааныг иргэний шүүх хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг болно хэмээн тайлбарласан байна. Үүнийг МУИС-ийн багш ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Н.Норовсамбуу судлаач үзэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйл 45.4-г буруу тайлбарласан гэж үзсэн байна.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйл. Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах гэсэн агуулга бүхий хэдий иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль биш ч гэсэн тухайн ЭХХШТХ-ийн агуулгыг нь харвал мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах эрхтэй байхад яагаад хууль зүйн үндэслэл болохгүй вэ гэдэг асуудал яригдана.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэл гаргах эрхтэй байхад сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй байна гэж ойлгох үндэслэлтэй байна. Тэгэхээр ингэж тайлбарлах нь хэт явцуу хэлбэрийн шалтаг болгон тайлбарлаж байна гэж дүгнэж байна. Процессын хууль дээр байгаа агуулга бол процессын агуулга байна гэж дүгнэсэн тайлбар нь нь ХЗШУ-ны хувьд өрөөсгөл учир нь тухай хууль процессын хууль байлаа гээд процессын агуулгатай байх албагүй юм.

Өөрөөр хэлбэл, ЭХХШТХ-ийн ажиллагааны улмаас учирсан хохирлын хүрээнд сэтгэл санааны хохирол учирсан байгааг ЭХХШТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1-д болон 45.4 дээр заасан байна гэж үзэж байна. Үүнийг үгүйсгэсэн тайлбарыг буруу тайлбар гэж МУИС-ийн багш ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Н.Норовсамбуу судлаач нар үзсэн байна.

Ийнхүү судалгааны явцад эдийн бус хохирол /сэтгэл зүй, бие махбодын болон амь нас, эрхтэн/-ыг хохирогч нэхэмжилдэг боловч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд энэхүү хохирлыг нотлох ажиллагаа хийдэггүй, улмаар шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох буюу зарим тохиолдолд хэсэгчлэн нэхэмжлэлийг хангасан тохиолдлууд практикт харагдаж байна.

Тухайлбал, саяхан болсон Зам тээврийн яамны ажилтан залуугийн амь насыг нь хөнөөсөн хэрэгт яллагдагчаар татагдсан гэм буруутан иргэн М нь хохирогчийн ар гэрт уг гэмт хэргийн улмаас учирсан бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг барагдуулах өөрийн зүгээс санаачилга гаргасан саналыг шүүх дэмжиж түүний хүсэлтийг шүүх хангаж хохирогчийн ар гэр, үр хүүхэд, эхнэрт нь 500,000,000 сая төгрөг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн сайн жишээ байна. Цаашдаа Монгол Улс дэлхий нийтийн жишгийг баримтлан хүний эрхийг бүрэн дүүрэн хангасан хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгож дагаж мөрдөх хэрэгтэй байна.

ГУРАВ. ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ТУРШЛАГА

Гадаад улсын нийтлэг туршлагаас үзэхэд гэмт хэрэгт өртсөн хэнд боловч сэтгэл санааны хохирол учирдаг гэж үзэж, сэтгэл санааны хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэдэг бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ гэмт хэргийн төрөл бүрээр тооцсон тарифын үнэлгээг үндэслэдэг байна. Тэр ч утгаараа энэхүү судалгаагаар дараах улсуудыг эрх зүйн бүлээр ангилан. Тухайлбал:

I. Англи саксоны эрх зүйн бүлийн

- Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс,
- Америкийн Нэгдсэн Улс,
- Австрали Улс,

II. Роман-Германы буюу “континенталь” эх газрын эрх зүйн тогтолцоотой улс

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс,
- Бүгд Найрамдах Итали Улс,
- Бүгд Найрамдах Франц Улс,
- Бүгд Найрамдах Хятад ард Улс,

зэрэг орнуудын эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал, түүнд ноогдуулж байгаа нөхөн төлбөр болох мөнгөн төлбөрийн дүнг харьцуулан авч үзлээ.

Англи саксоны эрх зүйн бүл улсууд болох Англи Улс, АНУ-ын эрх зүйд сэтгэл санааны гэм хорыг олон хэлбэрээр тодорхойлдог байна. Үүнд: “psychological injury” (сэтгэл зүйн гэм хор), “psychiatric injury” (сэтгэцийн гэм хор), “nervous shock” (мэдрэлийн шок, мэдрэлийн гэмтэл), “ordinary shock” (ердийн шок, ердийн хямрал) гэх мэтээр нэрлэдэг байна.⁵⁰ Эдгээр нэр томъёог сэтгэл санааны гэм хор учруулснаас үүсэх үүргийн институтэд янз бүрийн арга хандлагаар хандаж байсны нөлөөллөөс үүссэн гэж үздэг. Мөн гэм хор нь санаатай эсхүл болгоомжгүй үйлдлээс болсноос хамаарч хариуцлага ногдуулах үндэслэлүүдийг ялгамжтайгаар тогтоожээ.

Энэ системийн улс орнуудад болгоомжгүй үйлдлээс учирсан сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлбөр олгох аргаар арилгадаг бол санаатай учруулсан гэм хорыг торгуулийн ногдуулах аргыг хэрэглэдэг байна.

3.1. ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ВАНТ УЛС

ИБУИНВУ-д Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг нөхөн төлөх асуудал хариуцсан комисс байгуулагдаж 1964 оны 8 дугаар сарын 1-ний өдөр нөхөн төлбөрийн схемийг хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн ба байнга шинэчлэгддэг байна.

Уг схем нь шүүхийн практик болон инфляцыг харгалзан тогтмол шинэчлэгддэг бөгөөд зөвхөн зөвлөмжийн шинж чанартай байдаг. Гэсэн хэдий ч практикт шүүгчид дээрх зөвлөмжийг дагаж мөрддөг. Гэхдээ хэргийн тодорхой нөхцөл байдлаас хамаарч талууд хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх эсхүл бууруулах талаар маргаж болдог. Сэтгэл санааны хохирлын нийт хэмжээг “шударга болон үндэслэл” бүхий байх зарчмыг баримтлан тодорхойлдог.

50 Эрделевский А.М “Компенсация морального вреда” Москва, Издательство БЕК,2000, 9 дэх тал

Английн хууль зүйн сурах бичгүүдэд мэдрэлийн шокийг болгоомжгүйгээр гэм хор учруулснаас үүсдэг гэж үзжээ. Мэдрэлийн шок гэх томъёоллыг хуучирсан гэж үздэг бөгөөд түүнд эмнэлгийн нэр томъёоны утгыг агуулаагүй, харин болгоомжгүй буюу санаатай үйлдлээс, эсхүл гэрээ зөрчсөнөөс учирсан сэтгэл санааны гэм хор нэхэмжилсэн нэхэмжлэлийг ялгахад хэрэглэдэг байна. Сэтгэл санааны гэм хор нь мэдрэлийн шокийн хэлбэрээр илэрч буйг тогтооход энэ гэм хор нь оношлогдох боломжтой, сэтгэл зүйн өөрчлөлт гарсан байх зэргийг харгалздаг бөгөөд ердийн өөрчлөлт болон эсхүл айх, гашуудах гэх мэт сөрөг сэтгэл хөдлөл бол ордоггүй.

ИБУИНВУ нь гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг “2012 оны Эрүүгийн гэмтлээс үүдэх хохирлын нөхөн төлбөрийн схем”-ийн дагуу зохицуулдаг. Энэхүү схемийг 1995 онд Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай хуулийн 11 (1) хэсэгт заасны дагуу парламентад танилцуулж, уг хуулийн 11 (3) хэсэгт заасны дагуу нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

ИБУИНВУ-ийн хохирол барагдуулахдаа бага зэргийн сэтгэл санааны хохирлыг 1290-4900 фунт стерлингээр үнэлдэг байна. Харин дунд зэргийнх бол 4.9-45 мянга, хүнд зэргийн сэтгэл санааны хохирол учирсан хэмээн үзвэл 45-96 мянга хүртэлх фунт стерлингээр үнэлж, тооцдог аж. Эдгээрийг төгрөгт хөрвүүлэн тооцож үзвэл сэтгэл санааны хохирлыг 4сая-300. сая хүртэлх төгрөгөөр үнэлдэг байна.

Одоогийн байдлаар системтэйгээр шинэчлэгдэж байгаа доорх хүснэгт нь эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг тооцох үндэс суурь болж байна.

Жич: Энэхүү схемээр гэмт хэргийн улмаас учирсан бие махбодынн болон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосон тул зөвхөн сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөртэй холбоотой хэсгийг хэсэгчлэн авсан.

2012 оны Эрүүгийн гэмтлээс үүдэх хохирлын нөхөн төлбөрийн схем⁵¹

/хэсэгчлэн авав/

Сэтгэцийн гэмтэл⁵²

Тэмдэглэл [2]: «Сэтгэцийн гэмтэл»-д түр зуурын сэтгэлийн түгшүүр эсхүл үүнтэй төстэй түр зуурын нөхцөлийг оруулахгүй болно.

Сэтгэцийн гэмтэл нь тодорхой хугацаанд тухайн хүний өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадварт сөрөг нөлөө үзүүлэх тохиолдолд хөгжлийн бэрхшээл гэж тодорхойлж болно. (жишээлбэл, ажил, сургуулийн гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэх, нийгмийн харилцаа, эсхүл бэлгийн харьцаанд ороход нөлөөлөх гэх мэт).

Сэтгэцийн гэмтлийг сэтгэцийн эмч, клиник сэтгэл судлаачийн оношилгоо, прогнозоор тодорхойлно:

Гэмтлийн тодорхойлолт	Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £
6 долоо хоног-28 долоо хоног хүртэл	A1	1,000
28 долоо хоног- 2 жил хүртэл	A4	2,400
2 жил-5 жил хүртэл	A7	6,200
5 ба түүнээс дээш жил	A9	13,500

51 Ministry of justice, The Criminal Injuries Compensation Scheme 2012, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/808343/criminal-injuries-compensation-scheme-2012.pdf?fbclid=IwAR0a47xYkPhCvO4Ago0B3LV_6SxhA-ij0954sxTl7CeAVdGKCZHpvcame5g, Сүүлд үзсэн: 2021.01.26

52 Мөн тэнд 48 дахь тал.

Сэтгэцийн байнгын гэмтлийг сэтгэцийн эмч, клиник сэтгэл судлаачийн оношилгоо, прогнозоор тодорхойлно:

Гэмтлийн тодорхойлолт	Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £
дунд зэргийн идэвхгүй болгох	A11	19,000
ноцтой идэвхгүй болгох	A13	27,000

Тархины гэмтэл⁵³

Тэмдэглэл[3]: Тархины гэмтэл нь булчин, мэдрэлийн хяналт, тэнцвэр алдагдахад хүргэх, биеэ барих чадваргүй болох, төвлөрөл, ой санамж, хүсэл эрмэлзэл, хувийн шинж чанараа алдах зэрэг бие махбодын болон сэтгэл санааны гэмтэлд хүргэдэг. Энэ нь их, бага хэмжээгээр эпилепси үүсгэдэг. Хэрэв гэмтэл нь тархины гэмтлээс болсон бол гэмтэлд нэмэлт төлбөр олгохгүй, гэхдээ хуримтлагдсан нөлөөллийн зэрэглэлийг хамааран хамтад нь хэмжинэ.

Тархины дунд зэргийн гэмтэл

Гэмтлийн тодорхойлолт	Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £
Мэргэжлийн болон бусад тусламж үйлчилгээнээс шууд хамаарах бие бялдар болон сэтгэл санааг ноцтой доройтуулж, оюун ухаан, хувийн шинж чанар эрс буурч, хэвийн бус зан авир, харилцаа холбоо муудах	A18	110,000

Аль ч насны бэлгийн гэмт хэргийн хохирогч⁵⁴

Тэмдэглэл [6]: Хэрэв хүн тус тусдаа төлбөрт хамрагдах боломжтой бэлгийн гэмт хэргийн цуврал хүчирхийллийн хохирогч болсон бол хамгийн хүнд тохиолдлуудыг үндэслэн хүчирхийллийн нөхөн төлбөрийг төлнө. Гэмт хэргийн нөхцөл байдлыг хүчирхийлэл үйлдсэн хэлбэр, нөхцөл байдал, хохирогчийн тоо, хохирол, үйлдсэн хугацаа зэргийг харгалзан үзнэ.

Хэрэв хүн бэлгийн хүчирхийллийн улмаас сэтгэцийн гэмтэл авсан бол тарифт заасан хамгийн өндөр хэмжээг нөхөн төлбөрийн хохирол болгон авна.

Бэлгийн хүчирхийлэл:

Гэмтлийн тодорхойлолт	Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £	
Сэтгэцийн эмгэгийн урьдчилсан оношны дагуу эргэлт буцалтгүй хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоох	- дунд зэргийн сэтгэцийн эмгэг	B12	22,000
	- хүнд сэтгэцийн эмгэг	B13	27,000

Үтрээ, анус, амны аль нэг буюу хэд хэдэн хэсэгт бэлэг эрхтэн оруулах

Гэмтлийн тодорхойлолт	Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £	
Сэтгэцийн эмгэгийн урьдчилсан оношны дагуу эргэлт буцалтгүй хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоох	- дунд зэргийн сэтгэцийн эмгэг	B12	22,000
	- хүнд сэтгэцийн эмгэг	B13	27,000
	-		

⁵³ Мөн тэнд 50 дахь тал.

⁵⁴ Мөн тэнд 69 дэх тал.

Сэтгэцийн эмгэгийн урьдчилсан оношны дагуу дотоод хүнд гэмтлийн улмаас бүх	- дунд зэргийн сэтгэцийн эмгэг	B14	33,000
насаараа сэтгэцийн өвчтэй болохыг тогтоох	- хүнд сэтгэцийн эмгэг	B15	44,000

Гэмт хэргийн хохирогч нь 18 насанд хүрээгүй хүүхэд буюу сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлээ удирдах чадваргүй насанд хүрсэн хүн.

Тэмдэглэл [6] Хохирогч нь зөвшөөрөл өгөх чадамжгүй хүүхэд эсвэл насанд хүрсэн хүнд хамаарна.

Бэлгийн хүчирхийлэл:

Гэмтлийн тодорхойлолт		Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £
Сэтгэцийн эмгэгийн урьдчилсан оношны дагуу эргэлт буцалтгүй хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоох	- дунд зэргийн сэтгэцийн эмгэг	B12	22,000
	- хүнд сэтгэцийн эмгэг	B13	27,000

Үтрээ, анус, амны аль нэг буюу хэд хэдэн хэсэгт бэлэг эрхтэн оруулах

Гэмтлийн тодорхойлолт		Түвшингийн стандарт	Төлбөрийн үнэлгээний дүн £
Сэтгэцийн эмгэгийн урьдчилсан оношны дагуу эргэлт буцалтгүй хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоох	- дунд зэргийн сэтгэцийн эмгэг	B12	22,000
	- хүнд сэтгэцийн эмгэг	B13	27,000
Сэтгэцийн эмгэгийн урьдчилсан оношны дагуу дотоод хүнд гэмтлийн улмаас бүх насаараа сэтгэцийн өвчтэй болохыг тогтоох	- дунд зэргийн сэтгэцийн эмгэг	B14	33,000
	- хүнд сэтгэцийн эмгэг	B15	44,000

3.2. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Англи саксоны эрх зүйн бүлд хамаардаг болохоороо ИБУИНВУ болон АНУ-ын эрх зүйн бүлийн нийтлэг байдлаас хамаарч эрх зүйн зохицуулалтын харилцаанд ижил төстэй зүйл их байдаг байна.

АНУ-ын муж улс бүр нь өөрийн эрх зүйн системтэй тул сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх асуудалд янз бүрээр хандах асуудал гардаг. АНУ-д сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг шүүх тогтоодог байна. Зарим муж улсад сэтгэл санааны гэм хорын хохирлыг зөвхөн хохирогчид нөхөн төлдөг бол зарим нэг муж улсад гуравдагч этгээдэд уг хохирол учирсан гэж үзвэл хохирлын асуудлыг шийдвэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл, гэмт үйлдлийг харсан этгээдэд сэтгэл санааны гэм хор учирсан гэж үзэж нөхөн төлөх асуудлыг шийдвэрлэдэг байна.

Америкийн нэгдсэн улсын хувьд гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг шүүхийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон “case law” /тодорхой хэргүүдийг шийдсэн шүүхийн туршлага буюу жишиг эрх зүй/⁵⁵-ээр шийдвэрлэдэг.

Америкийн “common law”-д гэм хор учруулснаас үүсэх үүргийн бүх тохиолдлыг хамарсан ерөнхий зохицуулалт байдаггүй. Харин тухайн тохиолдол бүрийн гэм хорд холбогдох тусгайлан эрх зүй үйлчилдэг.

55 Christopher Osakwe. /Russian civil code with annotations/ 2000 Comparative Restatement of American Law of Torts, 169-190

АНУ-ын эрх зүйд эдийн бус хохирлыг төрөл бүрийн сэтгэлийн зовлон шаналал (доромжлуулсан, бухимдсан, уур, ичгүүртэй, таагүй байдал зэрэг) хэлбэрээр илрэх буюу, эсхүл бие махбодын зовлон шаналал (бие махбодын өвдөлт, айдас, дутуу төрөх) гэх мэт хэлбэртэй байж болно гэж үздэг бөгөөд харин ёс суртахууны гэм хорыг бий болгож болох тодорхой тохиолдлуудад “зовоох (зовоон тарчилгах буюу эрүүл мэндэд гэм хор учруулснаас эрүүл мэнд нь доройтсон), эмэгтэй хүнтэй хүчээр буюу албадаж бэлгийн харилцаанд орох” зэрэг тодорхой тохиолдлуудыг оруулдаг байна.

- Нэр төрд халдсанаас бий болох эдийн бус хохирлыг Америкийн эрх зүйд өвөрмөц байдлаар авч үздэг байна. Нэр төрд учирсан хохирлыг нөхөн сэргээх үндсэн хэлбэр нь мөнгөн төлбөр олгох арга байдаг. Жишээлбэл:
- Нэрлэсэн гэм хорыг нөхөн төлөх (хууль, шүүхийн жишгээр тогтоогдсон тодорхой хэмжээгээр),
- Сэтгэл санаа ёс суртахууны хохирлыг хохирогчид бий болсон сөрөг үр дагаврыг харгалзан нөхөн төлөх,
- Бие махбодын гэм хорыг арилгах,
- Шийтгэлд нөхөн төлбөр,
- Багасгасан буюу зөөлрүүлсэн нөхөн төлбөр зэрэг төрлүүд байдаг.

Хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотойгоор ердийн журмаар хариуцагч хэрвээ бусад хариуцлага хүлээсэн бол нэр төрд халдсан мэдээг заавал залруулах үүрэггүй байдаг. Урьд гарсан нийтлэлийг дахин залруулахыг шаардсан ямар ч дүрэм журам нь Үндсэн хуультай зөрчилдөнө гэж үздэг байна.

Мөн АНУ-д хүнийг хууль бусаар хорьсон бол хоригдсон жилээс нь хамааруулан 10,000-35,000 ам.долларыг нөхөн төлүүлдэг ба хэрэв эрүүл мэндэд нь гэм хор учруулсан бол хэргийн байдлаас хамааран эдийн бус хохирлын хэмжээг тогтоодог байна.⁵⁶

АНУ-д хохирлоо барагдуулахаар шүүхэд хандсан нэхэмжлэгч хувийн гэмтэл, болон эмнэлгийн мэргэжилтний буруу үйлдлээс улбаалсан хохирлыг нотолж чадвал эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой.

АНУ-д хүний эрүүл мэндэд учирсан хохирлын нэхэмжлэлд нөхөн төлбөрийг барагдуулж болох хоёр үндсэн хэлбэр нь эдийн болон эдийн бус хохирол юм. Эдийн засгийн хохирол нь хохирогчийн урьд болон ирээдүйд учирсан санхүүгийн зардал буюу олох байсан цалин, эмнэлгийн зардал, хөдөлмөрийн чадвараа алдах, мэргэжлийн нөхөн сэргээлт, ахуйн үйлчилгээ, халааснаас гарах зардал, шүүхийн зардлыг тооцон нөхөн төлнө. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хохирол нь хэргийн улмаас учирсан мөнгөний хохирлын үр дүнд олж буй нөхөн төлбөр юм. Харин эдийн бус хохирол нь гэмтлээс үүдсэн өвдөлт, шаналлын нөхөн төлбөрийг барагдуулах тухай ойлголт юм.

Эдийн бус хохирол нь тангарагтны шүүхээр субъектив байдлаар үнэлэгддэг.

Эдийн бус хохирол нь өвдөлт, сэтгэл санааны шаналал, доромжлол, нэр хүндэд хохирол учруулах, үйл ажиллагаанаас таашаал алдах, урьд өмнө бэртэж гэмтэх зэрэг орно. Зарим муж, улсад тэднийг зовлон, шаналал гэж нэрлэдэг. Жишээлбэл, тархи, нуруу нугасны зарим гэмтэл авсны дараа урьд нь стрессээ тайлахын тулд бүжиглэх, урт удаан алхах, спортоор хичээллэх идэвхтэй амьдралын хэв маягийг

56 Herald J. Morris & Professor. Andrew Burrows. The Law Commission №257 “Damages for personal injury: Non- Pecuniary Loss”. <http://www.open.gov.uk/lawcom/>.

эрхэлж байсан хүмүүс эдгээр үйл ажиллагааг хийх боломжгүй эсвэл эдгээр үйл ажиллагааг эрс хязгаарлаж болно. Энэ нь эргээд нийгмийн харилцааг багасгаж, амьдралын хэв маягийг өөрчилснөөр нэхэмжлэгчид амьдралаасаа таашаал авахад бэрхшээл учруулж болзошгүй юм. Нэмж дурдахад, эхнэр, нөхөр нь консорциумын алдагдал гэж нэрлэгддэг эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байдаг. Эдийн бус хохирол нь гэрээс гадуур ажил хийдэггүй гэмтсэн хүмүүс, тэр дундаа ахмад настан, хүүхэд, гэрийн эзэгтэй нарт нэн чухал нөлөөтэй байдаг.

Эдийн бус хохирлын зохих хэмжээний талаар тангарагтны шүүх өөр өөр дүгнэлт хийж болно. Энэ нь илүү хийсвэр, субъектив шинж чанартай тул эдийн бус хохирол нь олон муж, улсад хохирлын нөхөн олговрын талаарх дээд хэмжээг гэмтлийн төрлөөс хамааран хуульчилсан байдаг. Ихэнх муж, улсад хүн гэмтсэн тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх хязгаар гэж байхгүй, харин эмнэлгийн буруутай үйлдлээс болж хүн хохирсон тохиолдолд эдийн бус хохирлын хэмжээ хязгаарыг тогтоон нөхөн төлбөрийг барагдуулдаг.

АНУ-ын нутаг дэвсгэрт нийтэд нь эдийн бус хохирол нь өвдөлт, шаналал, бусад эрүүл мэндийн бус гэмтлийг хамардаг бөгөөд эмнэлгийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон тохиолдлуудад олон мужууд 250,000-750,000 ам.доллар ба түүнээс дээш долларын хооронд хязгаар тогтоодог байна.⁵⁷

Олон улс орнууд эдийн бус хохирлын хэмжээг тусгайлсан хуулиар тогтоосон байдаг. Тухайлбал:

3.2.1. Иллинойс муж улс

Иллинойс муж улсын Дээд шүүх 1997 оны Best and Taylor Machine Works-ийн хэрэгт⁵⁸ эдийн бус хохирлыг 500,000 ам.доллараар тогтоосон байна. Энэ нь хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсан буюу хамгийн хүнд хохирол буюу насан туршдаа хөдөлмөрийн чадвараа алдахад дээд нөхөн төлбөрийн хэмжээ юм гэдгийг шүүхээс тогтоожээ. Тус шүүхийн шийдвэрийг Public Act буюу олон нийтийн тухай хуульд эдийн бус хохирлыг нөхөн төлөх дараах байдлаар зүйлчлэн заасан байна.

Хууль тогтоомж

Олон нийтийн тухай хуулийн 101-651 хэсэгт зааснаар

735-р хэсэг ILCS 5 / 2-1115.1 - Эдийн бус хохирлыг нөхөн төлөх хязгаарлалт

(а) Нийтлэг хууль тогтоомжийн дагуу нас баралт, бие махбодод гэмтэл учруулах, хайхрамжгүй байдлын улмаас эд хөрөнгөнд учирсан хохирол, эсхүл бүтээгдэхүүний хариуцлага зэргээс үүдсэн хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардсан хууль ёсны болон бусад үйл ажиллагаанд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан байна. Нэг нэхэмжлэгч тутамд 500,000 ам.доллараар хязгаарлана.

(б) 1997 оноос эхлэн 1-р сарын 20-ны өдөр (а) дэд хэсэгт заасан өр төлбөрийн хязгаарыг хэрэглээний үнийн өмнөх индексийн өөрчлөлтийн хувьтай тэнцүү хувиар автоматаар нэмэгдүүлж, бууруулж байх ёстой. “Хэрэглээний үнийн индекс-” гэж АНУ-ын Хөдөлмөрийн яамны хөдөлмөрийн статистикийн товчооноос гаргасан нийт АНУ-ын хотын хэрэглэгчдийн худалдан авсан дундаж бараа, үйлчилгээний үнийн дундаж өөрчлөлтийг хэмждэг индексийг хэлнэ. Жил бүрийн шинэ дүнг хяналтын мэргэжилтэн тодорхойлж, шүүх тойрог тус бүрийн ерөнхий шүүгчид танилцуулна.

57 *Morgenstern, Michael (9 September 2015). «Medical Malpractice Damages Caps: A State By State Comparison». The Expert Institute. Retrieved 2 July 2017.*

58 *“Best v. Taylor Mach. Works 689 NE 2d 1057, 179 Ill. 2d 367 (1997)”. Google Scholar. Retrieved 3 October 2017.*

(с) Ийм хязгаарлалтын улмаас үүссэн хохирлыг эцсийн шүүлт буюу шийдвэрээр шийдвэрлэж байх үеийн хариуцлагын хязгаарыг шүүх хэрэглэнэ.

(d) Энэхүү хэсэгт дурдсан зүйлийг эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бий болгох үүднээс тайлбарлаж болохгүй.

(д) 1995 оны энэхүү нэмэлт өөрчлөлтийн тухай хууль нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш буюу түүнээс хойших хугацаанд хуримтлагдсан үйл ажиллагааны шалтгаануудад хамаарна.

3.2.2. Калифорни муж улс

Калифорни муж улсад эмнэлгийн буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн эдийн бус хохирлыг 250,000 ам.доллараар тооцдог байна.⁵⁹ Эдийн бус хохирлыг «өвчин зовлон, тав тухгүй байдал, бие махбодийн доройтол, хэлбэр дүрсээ алдсан байдал болон бусад эрүүл мэндийн бус хохирлыг нөхөн төлөх зорилгоор» хохирлыг барагдуулна хэмээн заасан байна.

Зүйл 2. Алдааны гэм хор [3333 - 3343.7] (1872 оны 2 дугаар зүйл.)

3333.2-р зүйл.

(а) Мэргэжлийн онцлогоос хамааран хайхрамжгүй байдлаас үүдсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн эсрэг гэмтлийн талаарх аливаа үйлдэлд хохирогч нэхэмжлэгч эдийн бус хохирлыг нөхөн төлөх, өвчин зовлон, тав тухгүй байдал, бие махбодын доройтол, хэлбэр дүрсээ алдсан болон бусад эрүүл мэндийн бус хохирлыг нөхөн төлөх эрхтэй.

(б) Эдийн бус алдагдлын хохирлын хэмжээ ямар ч тохиолдолд хоёр зуун тавин мянган доллараас (250,000 ам.доллар) хэтрэхгүй байх ёстой.

(в) Энэ хэсгийн зорилгоор,

(1) “эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч” гэж Бизнес ба Мэргэжлийн тухай хуулийн 2-р хэлтсийн дагуу (500-р зүйлээс эхлэн) зөвшөөрөл авсан, эсвэл Остеопатик санаачилгын тухай хууль, Chiropractic санаачилгын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан эсвэл гэрчилгээжсэн, эсхүл тусгай зөвшөөрлөөр олгогдсон аливаа этгээдийг хэлнэ. Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн 2-р бүлгийн 2.5-р бүлэг (1440-р хэсгээс эхлэн); мөн Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн 2-р хэлтсийн (1200-р хэсгээс эхлэн) зөвшөөрөлтэй клиник, эрүүл мэндийн диспансер, эрүүл мэндийн байгууллага. “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч” гэдэгт эрүүл мэндийн байгууллагын хууль ёсны төлөөлөгчид багтана;

(2) “Мэргэжлийн хайхрамжгүй байдал” гэж мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхдээ эрүүл мэндийн байгууллагын хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэхүйг, тухайн үйлдэл нь тухайн хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хууль бусаар амь насаа алдах магадлалтай шалтгаан болох үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөл олгох байгууллага эсвэл тусгай зөвшөөрөл бүхий эмнэлгээс тогтоосон хязгаарлалтад хамаарахгүй үйлчилгээний цар хүрээ.

АНУ-ын Калифорн муж улсын “Эрүүгийн хуулийн 236.1, 261, 262, 271, 273а, 273d, 285, 286, 288, 288а, 288.5, 289, 653.2 болон 311.4 (б), (в) зүйлд заасан гэмт хэрэг үйлдэгдсэн бол “...сэтгэл санааны хохирол үүссэн гэж үзнэ.” хэмээн шууд тодорхой хуульчилсан байдаг. АНУ-ын Калифорн муж улсад 2017 оноос өмнө тухайлбал, насанд хүрээгүй этгээдтэй бэлгийн харьцаанд орсон 21-ээс дээш насны гэмт хэрэгтэн этгээдээс сэтгэл санааны хохирлын гэмтлийг барагдуулах

59 Ann.Cal. Civ. Code&3333.2(a)(West)Ann.

нөхөн төлбөрийн дээд хэмжээг 5000 ам.доллар байхаар хязгаарлалт тогтоож байсан. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар сэтгэл зүйн эрүүл мэндийн зөвлөгөөний үйлчилгээг 10,000 ам.доллороос хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан. Шууд хохирогчид олгох нөхөн төлбөрийн нийт хэмжээг 35,000-70,000 ам.доллороос хэтрүүлэхгүй хэмээн хязгаарлалт тогтоосон.

Хохирогчийн судалгаанд хамрагдах үйлдэл, гэмт явдал нь тэр бүр “гэмт хэрэг” хэмээх нэр томъёотой нийцэх шаардлагагүй гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

3.2.3. Мэрилэнд муж улс

Мэрилэнд муж улсад эдийн бус хохирлыг 800,000 ам.доллороор тооцдог⁶⁰. Хүний биед гэмтэл учруулсан тохиолдолд эдийн бус хохирлыг “өвдөлт, шаналал, тав тухгүй байдал, бие махбодын доройтол, хэлбэр дүрсгүй болох, консорциумаа алдах, бусад эрүүл мэндийн бус гэмтэл» гэж тодорхойлдог. Хууль бусаар буюу гэмт хэргийн улмаас нас барсан тохиолдолд эдийн бус хохирлыг «сэтгэцийн шаналал, зовлон, нийгмээс салангид болох, нөхөрлөх чадвараа алдах, тайтгарал, хамгаалалт, гэр бүл, эцэг эхийн асрамж, үр хүүхдийн асрамж, анхаарал, зөвлөгөө, сургалт, удирдамж» гэж тодорхойлдог. - энэ зүйлийн 9-р гарчгийн 3-р гарчгийн дагуу олгосон эдийн бус бусад хохирол.»⁶¹

Хууль тогтоомж

Мэрилэнд код 2010

ШҮҮХ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

11-р ХЭРЭГ - ШҮҮХ

Дэд гарчиг 1 - Шүүлтүүд - Бусад

Хэсэг 11-108 - Осол гэмтлийн талаархи арга хэмжээ - Эдийн бус хохирлыг хязгаарлах.

§ 11-108. Осол гэмтлийн арга хэмжээ - Эдийн бус хохирлыг хязгаарлах.

(a) Тодорхойлолтууд.

(1) Энэ хэсэгт дараах үгсийг заасан утгатай байна.

(2) (i) “Эдийн бус хохирол” гэж:

1. Хүний гэмтэл, шаналал, тав тухгүй байдал, бие махбодын доройтол, хэлбэр өөрчлөгдсөн, консорциумаа алдсан болон бусад эрүүл мэндийн бус гэмтлийн төлөө үйл ажиллагаанд болон,

2. Хууль бус үхэл, сэтгэлийн шаналал, зовлонг арилгах, нийгмээ алдах, нөхөрлөл, тайтгарал, хамгаалалт, асрамж, гэр бүлийн асрамж, эцэг эхийн асрамж, үрийн асрамж, анхаарал, зөвлөгөө, сургалт, удирдамж эсвэл боловсролд зориулсан үйл ажиллагаанд, эсвэл энэ зүйлийн 9-р гарчгийн 3-т заасны дагуу олгосон эдийн бус бусад хохирол

(ii) “Эдийн бус хохирол” -д шийтгэлийн нөхөн төлбөр ороогүй болно.

(3) “Анхан шатны нэхэмжлэгч” гэж энэ зүйлийн § 3-904 (d) -д заасны дагуу хүний амь насыг хохироосон нэхэмжлэгчийг хэлнэ.

(4) “Хоёрдогч нэхэмжлэгч” гэж энэ зүйлийн § 3-904 (д) -д заасны дагуу хүний амь насыг хохироосон нэхэмжлэгчийг хэлнэ.

60 Md. Code Ann., Cts. & Jud. Proc. § 11-108 (West)

61 <https://law.justia.com/codes/maryland/2010/courts-and-judicial-proceedings/title-11/subtitle-1/11-108>

(б) Хохирлын хэмжээг тогтоосон хязгаарлалт

(1) Үйлдлийн шалтгаан нь 1986 оны 7-р сарын 1-ний өдрөөс хойш үүссэн хувийн гэмтлийн хохирлыг арилгах аливаа үйл ажиллагаанд эдийн бус хохирлыг 350,000 ам.доллараас хэтрүүлж болохгүй

(2) (i) Энэ хэсгийн дэд хэсгийн (3) (ii) -т зааснаас бусад тохиолдолд үйлдсэн шалтгаан нь 1994 оны 10-р сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш үүссэн хүний бие махбодын гэмтэл, хууль бусаар нас барсны хохирлыг арилгах аливаа арга хэмжээнд эдийн бус хохирол 500,000 ам.доллараас хэтрэхгүй байж болно.

3.2.4. Мичиган муж улс

Мичиган муж улс нь «эдийн бус алдагдал»-ын хувьд 280,000 ам.долларын дээд хязгаартай байдаг⁶². Эдийн бус хохирол гэдэг нь хуулийн 29222 хэсэгт заасны дагуу нэхэмжилсэн гэмтлээс үүдэлтэй “өвдөлт, зовлон, тав тухгүй байдал, бие махбодын доройтол, нийгмийн амьдралын алдагдлыг хэлнэ.”⁶³

Хэрэв тархины гэмтэл болон нугасны гэмтлээс болж 1 ба түүнээс дээш үе мөчний үйл ажиллагааны үүрдийн алдагдалд оруулсан тохиолдолд дээд хязгаарыг 500,000 ам.доллар хүртэл нэмэгдүүлдэг. Үүнээс үүдэн нэхэмжлэгч нь танин мэдэхүйн чадвараа доройтуулж, бие даасан, хариуцлагатай амьдралын шийдвэр гаргах чадваргүй, хэвийн үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадваргүй, өдөр тутмын амьдралд чадваргүй болгосон тохиолдолд нөхөн төлбөрийн дээд хэмжээг олгохоор заасан байдаг.

1961 Оны шүүх ажиллагааны тухай хууль,

1961 оны 236-р хууль,

600.1483 Эмнэлгийн буруу үйлдлийн улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл; эдийн бус хохирлын хязгаарлалт; үл хамаарах зүйл; хохирлыг эдийн болон эдийн бус алдагдал болгон ангилах; “Эдийн бус алдагдал” гэж тодорхойлсон, эдийн бус алдагдлын хязгаарлалтыг тохируулах.

Сек 1483.

(1) Эмнэлгийн буруутай үйлдлийг хүн эсвэл талтай холбоотой гэм буруутай гэж үзэн хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлд бүх хариуцагчдын эрүүл мэндийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн бүх нэхэмжлэгчдийн нөхөн төлсөн эдийн бус хохирлын нийт хохирлын хэмжээ 280,000.00 ам.доллараас хэтрэхгүй байна. Шүүгдэгчдийн 1 ба түүнээс дээш тооны хайхрамжгүй байдлаас 6304-р хэсэгт заасны дагуу шүүхээс тогтоосон дараахь 1 ба түүнээс дээш үл хамаарах зүйл хамаарах бөгөөд энэ тохиолдолд эдийн бус хохирлын хохирол 500,000.00 ам.доллараас хэтрэхгүй байна.

(а) Нэхэмжлэгч нь хөлийн цус харвах, параплегик, квадриплегик шинжтэй тул дараах зүйлсийн 1 ба түүнээс дээш шалтгаанаар 1 ба түүнээс дээш мөчний үйл ажиллагааны байнгын алдагдалд орно.

(i) Тархины гэмтэл.

(ii) Нуруу нугасны гэмтэл.

(б) Нэхэмжлэгч нь танин мэдэхүйн чадавхыг байнга бууруулж, бие даасан, хариуцлагатай амьдралын шийдвэр гаргах чадваргүй, хэвийн, өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг бие даан гүйцэтгэх чадваргүй болгож байна.

62 Mich. Comp. Laws Ann.&600.1483(West).

63 Mich. Comp. Laws Ann.&600.1483(West).

(в) нөхөн үржихүйн эрхтэн нөхөн үржих чадваргүй болоход байнгын алдагдал буюу гэмтэл гарсан.

(2) Эмнэлгийн буруутай үйлдлийг нотолсон үйлдлийн улмаас хохирлыг барагдуулахдаа илүү бодит байдал дээр гарсан хохирлыг эдийн болон эдийн бус хохирлын нөхөн төлбөр гэж тодорхойлно.

(3) Энэ хэсэгт хэрэглэсэн “эдийн бус алдагдал” гэдэг нь өвдөлт, зовлон, тав тухгүй байдал, бие махбодын доройтол, бие махбодын өөрчлөлт, нийгмийн алдагдал, нөхөрлөлийн улмаас үүссэн хохирол, алдагдлыг 2922-р хэсэгт заасны дагуу эсхүл өөр хэлбэрээр консорциум алдагдсаныг хэлнэ. эсвэл эдийн бус бусад алдагдал.

(4) 1994 оны 4-р сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн нярав нь (1) дэд хэсэгт заасан эдийн бус хохирлын хязгаарлалтыг хуанлийн жил бүрийн эцэст улсын няравын тогтоосон хэмжээгээр, жилийн хуримтлагдсан жилийн өөрчлөлтийн хувь хэмжээгээр тохируулна. хэрэглээний үнийн индекс. Энэхүү дэд хэсэгт хэрэглэсэн “хэрэглээний үнийн индекс” гэдэг нь АНУ-ын Хөдөлмөрийн яамны хөдөлмөрийн статистикийн товчооноос энэ мужид авах боломжтой өргөн хэрэглээний үнийн индексийг хэлнэ.

3.2.5. Баруун Виржиниа муж улс

Баруун Виржиниа муж улсад эдийн бус хохирлыг 500,000 ам.доллороор тооцдог. Эдийн бус хохирол гэдэгт :

1) хууль бусаар нас барах,

(2) байнгын болон үлэмж хэмжээний бие махбодын гажиг, болон биеийн эрхтэн ажиллагаагүй болох, биеийн эрхтний тогтолцоо алдагдах;

(3) бие даан өөрийгөө халамжилж, амьдралыг тэтгэх үйл ажиллагаа эрхлэх чадваргүй болгоход хүргэх махбодын болон сэтгэцийн насан туршийн гэмтлийг хэлдэг байна.⁶⁴

Баруун Виржиниа муж улс

БҮЛЭГ 55. Арга хэмжээ, шүүх, арбитрациалт, шүүхийн хямдрал.

Зүйл 7В. Эмнэлгийн мэргэжлийн хариуцлага

§55-7В-8. Эдийн бус алдагдлын хариуцлагын хязгаар.

(а) Энэ зүйлд заасны дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид ногдуулсан мэргэжлийн хариуцлагын талаарх аливаа арга хэмжээнд эдийн бус хохирлыг нөхөн төлсөн тохиолдолд нөхөн төлүүлэх дээд хэмжээ нь нэхэмжлэгчдийн тоо, хариуцагчийн тооноос үл хамааран гарсан тохиолдол бүрд 250,000 ам.доллороос хэтрэхгүй байх ёстой.

Хууль бусаар буюу гэмт хэргийн улмаас нас барсан тохиолдолд түгээгчийн тооноос үл хамааран энэ хэсгийн (b) дэд хэсэгт зааснаас бусад тохиолдолд.

(б) Нэхэмжлэгч эдийн бус алдагдлын нөхөн төлбөрийг энэ хэсгийн (а) дэд хэсэгт заасан хязгаарлалтаас хэтрүүлсэн боловч нөхөн олговрыг нэхэмжлэгчдийн тоо, хариуцагчийн тооноос үл хамааран гарсан тохиолдол бүрд 500,000 ам.доллороос хэтрэхгүй хэмжээгээр нөхөн төлүүлж болно.

64 W. va. Code Ann. 55-7B-8 &(west).

<http://www.wvlegislature.gov/WVCODE/chapterEntire.cfm?chap=55&art=7B§ion=8>.

Хууль бусаар буюу гэмт хэргийн улмаас нас барсан тохиолдолд нэхэмжлэгчийн эдийн бус хохирол учирсан хохирлыг дараах байдлаар хуваарилсан хүмүүсийн тооноос үл хамааран:

(1) цаг бусын үхэл,

(2) бие махбодын байнгын ба үлэмж хэлбэрийн гажиг, үе мөчний ашиглалт, биеийн эрхтний тогтолцоог алдах,

(3) бие махбодын болон сэтгэцийн байнгын гэмтэл нь гэмтсэн хүнийг бие даан халамжлах, амьдрал тэтгэх үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрмөсөн зогсооно.

(в) 2004 оны 1-р сарын 1-ний өдөр, түүнээс хойших жил, энэ хэсгийн (а) ба (б) дэд хэсэгт багтсан нөхөн төлбөрийн хязгаарлалтыг инфляцыг дансанд нийтлүүлсэн хэрэглэгчийн үнийн индекстэй тэнцэх хэмжээгээр нэмэгдүүлнэ. АНУ-ын Хөдөлмөрийн яам, энэ дэд хэсэгт заасан дүнгийн нэг зуун тавин хувиас хэтрэхгүй байх. (d) Энэ хэсгийн (а), (б), (в) ба (д) дэд хэсэгт багтсан эдийн засгийн бус хохирлын хязгаарлалт нь энэ зүйлд заасны дагуу эмнэлгийн мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдаагүй аливаа хариуцагч авах боломжгүй юм. Үйл ажиллагааны сэдэв болох эмнэлгийн гэмтлийг хамарсан тохиолдол тус бүрт дор хаяж 1 сая ам.доллар.

(е) Хууль тогтоох байгууллагын 2003 оны ээлжит чуулганы үеэр батлагдсан энэ хэсгийн (а) эсвэл (б) дэд хэсэг, эсхүл түүнийг ямар нэгэн этгээд, нөхцөл байдалд хэрэглэхийг Үндсэн хууль зөрчсөн, эсхүл өөр хүчин төгөлдөр бус гэж шүүх тогтоосон. Энэ зүйлд заасны дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид ногдуулсан мэргэжлийн хариуцлага хүлээлгэх ажиллагааны улмаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд шаардагдах нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь 1 сая ам.доллороос хэтрэхгүй байна.

3.2.6. Висконсин муж улс

Висконсин муж улсад эмнэлгийн буруу үйл ажиллагаанаас үүдсэн эдийн бус хохирлыг 750,000 ам.доллороор тооцдог.

Эдийн бус хохирол гэдэг нь «өвчин шаналал, зовлон, доромжлол, ичих, санаа зовох, сэтгэл санааны хямрал, болон хөгжлийн бэрхшээлтэй болсноос үүдсэн эдийн бус үр нөлөө болох амьдралын хэвийн үйл ажиллагаагаа алдах, амьдралын хэвийн таашаал ханамж эдлэхээ алдах, сэтгэцийн болон биеийн эрүүл мэндээрээ хохирох, сайн сайхан байдал эсвэл бие махбодын үйл ажиллагаа, консорциум, нийгэмд эзлэх байр суурь, нөхөрлөлөө алдах зэрэг эдийн бус хохирлууд ордог байна.

3.3. АВСТРАЛИ УЛС

Австралид эдийн бус гэм хорын ойлголт өргөн хүрээтэй бөгөөд эдийн бус хохиролд тооцогдох өвдөлт, шаналал, сэтгэцийн гэмтлийг нөхөн сэргээх, нөхөн төлөх хамрах хүрээ маш нарийн зохицуулалттай байдаг⁶⁵. Австрали улс нь 6 муж улсуудтай. Муж улс болгон нь хохирол тооцох аргачлалуудыг өөрсдийн парламентуудаас батлан гаргасан хууль тогтоомжийн дагуу хэрэглэдэг ба өмнөх шүүхийн прецидент хэргүүд дээр үндэслэж, шүүх хохирлыг хэмжээг харьцуулан нөхөн олговрыг олгодог байна.⁶⁶ Тэрч утгаараа Австрали улсын тэдгээр аргачлал, хууль тогтоомжид тусгасан байдлыг судлах нь олон улсын чиг хандлагыг тогтоох,

65 Улсын дээд шүүх. "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг ба иргэний хууль хэрэглэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал" УБ 2012 он

66 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. Journal of law and medicine, 11(4), pp.446-481.

хохирлыг тооцох аргачлалыг олон талаас нь судлах боломжийг нээх өндөр ач холбогдолтой юм.

Австрали улсын шүүх нь хувь хүнд учирсан гэмтэл, нэхэмжлэгчийн амьдралын хэв маяг, ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөөлөл, хохирлын үр дагавар, ирээдүйн боломжит зардлыг харгалзан нийт нөхөн олговрыг тооцдог байна. Тухайлбал, эдийн засгийн хохирлын нөхөн олговорт хохирогчийн урьд өмнө олсон орлого, ирээдүйд олох байсан орлого зэргийг тус бүр тооцон нөхөн төлдөг боловч нөхөн олговрын тодорхой хязгаарлалт нь долоо хоногийн дундаж орлогоос гурав дахин ихээс хэтрэхгүй байхаар заасан байдаг байна.⁶⁷ Харин эдийн бус хохирол гэх ойлголтод нь хувь хүний гэмтлийн улмаас учирсан сэтгэл санааны мэдрэмжүүд хамаарах бөгөөд тарчлаалт, өвдөлт, шаналах, амьдралын үр өгөөж, амьдралаас мэдрэх таашаал болон кайфыг алдах зэрэг сэтгэл зүйн хохиролд нөхөн олговор олгохыг ойлгодог байна.⁶⁸

Австрали улсад тэр дундаа эдийн бус хохирлын нөхөн олговрыг олгох, тооцох аргачлал нь гэмтлийн төрлөөс хамаарч өөр өөр байдаг. Тухайлбал,

- Ажлын байран дахь осол аваараас учирсан гэмтэл,
- Автомашины осол аваараас учирсан гэмтэл зэрэг тус тусад нь ялгамжтайгаар хуульчлан нөхөн олговрын үнэлгээг тооцдог байна.

Хүснэгт №1⁶⁹

Австралийн сэтгэц, сэтгэл санааны хохирлыг үнэлэх аргуудын харьцуулалт “Comparison of Methods for the Assessment of Psychiatric Impairment within Australian Jurisdictions”		
Муж улс	Ажлын байран дахь осол аваараас учирсан сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал:	Автомашины осол аваараас учирсан гэмтэл сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал:
Шинэ Өмнөд Уэльс муж улс “New South Wales”	Анхан шатны гэмтэл нь сэтгэцийн гэмтлийн шинжтэй байх. WorkCover үнэлгээнд үндэслэн, сэтгэцийн эмгэгийн үнэлгээ нь 15% буюу түүнээс дээш босгыг давсан байх.	Автомашины ослын газрын эрүүл мэндийн удирдамжид заасны дагуу “Сэтгэцийн эмгэгийн үнэлгээ”-нд үндэслэн, үнэлгээ нь 10% -ийн босгыг давсан байх
Квинсланд муж улс “Queensland”	Америкийн эрүүл мэндийн холбооны гарын авлагад хохирлын үнэлгээг үндэслэн эдийн бус нөхөн олговор олгоно.	Тодорхой аргачлалгүй, хувь хүний эрүүл мэндийн оношоор эдийн засгийн бус хохирлын нөхөн төлбөрийг үнэлнэ.
Өмнөд Австрали муж улс “South Australia”	Нөхөн олговрыг Маймсын хүснэгтээр эсвэл AMA Guides 3 дахь хэвлэлийг үндэслэн тооцож эдийн бус нөхөн олговор олгоно.	Буруугийн тухай хуулийн дагуу 0-ээс 60 хүртэлх оноогоор үнэлнэ.
Тасмания муж улс “Tasmania”	Сэтгэцийн эмгэгийн үнэлгээний хуваарь нь WorkCover Тасманийн маягт удирдамжын дагуу тооцож, тус үнэлгээний 10% -ийн босгыг давсан байвал эдийн бус нөхөн олговор олгоно.	Хохирлыг тогтоох албан ёсны аргачлалгүй, хувь хүний эрүүл мэндийн тайланг үндэслэн эдийн засгийн бус хохирлын нөхөн төлбөрийг үнэлнэ.
Виктория муж улс “Victoria”	“Сэтгэцийн эмгэгийн зэрэглэлийг тогтоох клиник гарын авлагыг” ашиглан сэтгэцийн гэмтлийн үнэлгээний 30% босгыг давсан байвал эдийн бус нөхөн олговор олгоно.	“Сэтгэцийн эмгэгийн зэрэглэлийг тогтоох клиник гарын авлага” -ыг ашиглан сэтгэцийн гэмтлийн үнэлгээний 10% босгыг давсан байвал эдийн бус нөхөн олговор олгоно.

67 28B Тодорхойлолт, Буруугийн тухай хууль 1958, Wrongs Act 1958 (Vic)

68 28B Тодорхойлолт, Буруугийн тухай хууль 1958, Wrongs Act 1958 (Vic)

69 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. Journal of law and medicine, 11(4), pp.446-481.

Баруун Австраль муж улс “Western Australia”	Баруун Австраль мужийн анагаах ухааны холбооны гаргасан гарын авлагын дагуу сэтгэл санааны хохирол нь 30% үнэлгээний босгыг давсан байх аль эсвэл 16% -ийн үнэлгээтэй ба бие махбодийн “их хэмжээний хөгжлийн бэрхшээл” хавсарсан тохиолдолд эдийн бус нөхөн олговор олгоно.	Хохирлын үнэлгээг тогтоосон аргачлалгүй; хамгийн онц ноцтой хохиролтой хэрэгтэй харьцуулан шийдсэн шийдвэрт үндэслэн эдийн бус хохирлын үнэлгээг тооцно.
Австралийн нийслэл газар нутаг муж улс “Australian Capital Territory”	Маймсын хүснэгтийн дагуу тооцно	Тогтоосон аргачлалгүй
Хойд Нутаг дэвсгэр муж улс “Northern Territory”	Америкийн Эрүүл Мэндийн Холбооны 4дэх хэвлэл бүхий гарын авлага, үнэлгээг ашиглана. Үнэлгээний 5% ийн босгыг давсан байвал эдийн бус нөхөн олговор олгоно.	Америкийн Эрүүл Мэндийн Холбооны 4дэх хэвлэл бүхий гарын авлага, үнэлгээг ашиглана. Тус үнэлгээний 5% ийн босгыг давсан байвал эдийн бус нөхөн олговор олгоно.

Энэхүү харьцуулсан хүснэгтийг харахад, Австрали улсад орших 6 муж улс нь хууль тогтоомжийн ялгаатай байдлаас хамааран хохирол тооцох аргачлал нь харилцан адилгүй байгаа бөгөөд юуны түрүүнд эдийн бус хохирлын нөхөн төлбөр авахаас өмнө нэхэмжлэгчид хуульд заасан гэмтлийн зэргийн босгыг давсан байх ёстой⁷⁰. Жишээ нь, Шинэ Өмнөд Уэльсын Авто тээврийн хэрэгслийн ослын тухай хууль тогтоомжийн дагуу нэхэмжлэгч шаналал, зовиурын нөхөн олговор авахын тулд чадвар алдалтын нийт үнэлгээг тогтоосон байх бөгөөд энэ нь 10% -аас дээш үзүүлэлттэй байх урьдчилсан шаардлагыг тавьдаг байна⁷¹. Австралид аливаа нөхөн олговор нь хуулийн дагуу холбогдох хохирлыг тооцох үнэлгээн дээр суурилах бөгөөд шүүхээс гаргасан «хамгийн ноцтой хохиролтой» хэргийг 100 хувь гэж үзэн, хэргүүдийг хүндээс хөнгөн хүртэл хохирлын хэмжээг нь харьцуулж, өмнөх шийдсэн хэргүүдийг харгалзан үздэг байна.

Сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх урьдчилсан босгыг Австралийн муж улсууд нийтдээ 20 орчим тодорхой хууль тогтоомжоор зохицуулсан байна⁷². Тухайлбал, эдгээрээс Квинсланд (Queensland), Шинэ Өмнөд Уэльс (New South Wales), Австралийн нийслэл газар нутаг (Australian Capital Territory), Тасманиа (Tasmania), Өмнөд Австрали (South Australia), Баруун Австрали (Western Australia) гэсэн муж улсууд нь сэтгэл санааны тооцох аргачлалыг хууль тогтоох байгууллагаас батлан гаргасан “Иргэний хариуцлагын тухай хууль” (Civil Liability Act), Автотээврийн хэрэгслийн ослын тухай хууль тогтоомж, Ажлын байрны ослын тухай хуулиар ялгамжтайгаар зохицуулдаг байна. Харин Австралийн Хойд нутаг (Northern Territory) муж улсад “Хувийн осол гэмтэл (өр төлбөр ба хохирол) -ын тухай хууль 2003” (Personal Injuries (Liabilities and Damages) Act 2003 (NT)-аар зохицуулдаг бол харин Викториа (Victoria) муж улс нь “Буруугийн тухай хууль 1958” (Wrongs Act 1958 (Vic)) зэрэг хууль тогтоомжоор сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцохоор зохицуулсан байна.

70 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. Journal of law and medicine, 11(4), pp.446-481.

71 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. Journal of law and medicine, 11(4), pp.446-481.

72 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. Journal of law and medicine, 11(4), pp.446-481.

Тус хуулиудаар Австралийн Квинсланд (Queensland) гэх муж нь эдийн бус хохирлыг нөхөн олговрын дээд хэмжээг 250,000 ам.доллар байхаар тогтоосон бол Шинэ Өмнөд Уэльс ба Хойд нутаг гэх муж улсууд нь эдийн бус хохирлын хязгаарыг 350,000 ам.доллараар тогтоожээ⁷³. Харин Викториагийн эдийн бус хохирлын дээд хэмжээ нь 371,380.26 ам.доллар гэж тогтоосон байна⁷⁴. Ингэж хуулиар нөхөн олговрын дээд хэмжээг тусган хуульчлах нь хууль тогтоох байгууллагаас шүүхийн шийдвэрт үндэслэл бүхий хяналт тавих явдал юм хэмээн хуулийн үзэл баримтлалдаа тусгажээ.⁷⁵

Дээрх муж улсуудаас зөвхөн гурав муж улс ажилчдын нөхөн олговрын болон тээврийн ослын хэргүүдэд сэтгэцийн эмгэгийг үнэлдэг үнэлгээний тусгайлсан аргыг ашигладаг. Бусад муж улс нь сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг тусад нь хэрэглэхээс илүүтэйгээр хөгжлийн бэрхшээл алдалт зэрэг нийт бие махбодын хохиролд тооцуулан үнэлэх хандлагатай. Мөн тооцохдоо зарим тохиолдолд бие махбодын хохирлыг үнэлгээтэй уялдуулж тооцох хандлага бас ажиглагдаж байна. Тухайлбал, Баруун Австрали муж улсад “Western Australia” сэтгэл санааны хохирлын үнэлгээ 30% заавал хүрсэн тохиолдолд, аль эсвэл сэтгэл санааны 16% үнэлгээ нь “их хэмжээний бие мах бодын хөгжлийн бэрхшээл” хавсарсан байгаа тохиолдолд эдийн бус нөхөн олговор олгодог байна. Гэвч чухам хохирлыг хэрхэн тооцож, ялгамжтайгаар нөхөн олговрыг олгодог болох, эдгээр хууль тогтоомжийг тус бүрээр нь харьцуулан, хууль зүйн зохицуулалт, тооцох аргачлалын онцлогийг энэхүү судалгаагаар дэлгэрүүлэн авч үзье.

1. Викториа (Victoria) муж улс

Викториа муж улсын Буруугийн тухай (Wrongs Act 1958 (Vic)) хуулийн агуулга нь төрийн эрх бүхий байгууллагуудын хариуцлагын тогтолцоо, хайхрамжгүй байдлаас үүдсэн гэм хор, сэтгэцийн хохирлын нөхөн төлбөрийн тухай нарийвчилсан зохицуулалтаас бүрддэг.⁷⁶ Тус хуулийн 43-р хэсэгт «гэмтэл» (injury) гэдэгт нь «сэтгэлзүйн болон сэтгэцийн гэмтэл» (psychological or psychiatric injury) орно гэж нарийвчлан тусгасан байна⁷⁷. Гэвч чухам юуг “Сэтгэлзүйн болон сэтгэцийн гэмтэл” гэсэн албан ёсны тодорхойлолтыг уг хуульд тусгайлан заагаагүй хэдий ч тус хуулийн 75-р хэсэгт “гэмт хэргийн сэтгэцийн хохирлыг шүүх тогтоохдоо тус хохирол нь заавал хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчин хамаарах ёстой бөгөөд хэрэв хамаарахгүй бол нөхөн төлүүлэх боломжгүй”⁷⁸ хэмээн заасныг дүгнэвэл мэргэжлийн байгууллагаас буюу эрүүл мэндийн байгууллагаас батлан гаргасан «хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэл зүйн болон сэтгэцийн өвчин» -ий жагсаалтад сэтгэл санааны хохирлыг үндэслэн үнэлнэ гэсэн шууд бус санааг агуулж байна.

73 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. *Journal of law and medicine*, 11(4), pp.446-481.

74 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. *Journal of law and medicine*, 11(4), pp.446-481.

75 Mendelson, G., 2004. Survey of methods for the rating of psychiatric impairment in Australia. *Journal of law and medicine*, 11(4), pp.446-481.

76 Section 43, Wrongs Act 1958 (Vic), “injury” includes “psychological or psychiatric injury”.

77 Wrongs Act 1958 (Vic)

78 Section 75 of the Wrongs Act 1958: “A court cannot make an award of damages for economic loss for mental harm resulting from negligence unless the harm consists of a recognised psychiatric illness.”

Тус хуулийн VBA хэсэгт “эдийн бус хохирлын нөхөн төлбөртэй холбоотой босго хэмжээ” -г тодорхойлсон болно.⁷⁹ Тус хуульд тодорхойлохдоо “сэтгэл зүйн чадвар алдалтын зэргийн үнэлгээ нь 10% буюу түүнээс дээш” -байх хэмээн хуульчлан тогтоосон байна.⁸⁰

Тэгвэл сэтгэл зүйн хохирлын чадвар алдалтыг хэн, хэрхэн тооцох вэ гэдэг асуулт гарч ирж байна. Тус хуулийн 28L1 хэсгийн дагуу сэтгэцийн эмгэгийг “Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл, үнэлгээг тогтоох клиник удирдамжийг ашиглан үнэлнэ” хэмээн нарийвчлан заасан байна. Тиймээс энэхүү босго түвшнийг давсан үгүйг батлах нь цэвэр эмнэлгийн салбарын ажилчдын үнэлэмжийн дагуу шийдэгддэг болох нь харагдаж байна. Мөн тус хуулийн зохицуулалтаас харвал тэрхүү “Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл, үнэлгээг тогтоох клиник удирдамж” нь Америкийн Эрүүл мэндийн холбооноос гаргасан “Сэтгэцийн эмгэгийн үнэлгээний гарын авлага”-д үндэслэсэн байх ёстойг доорх хуулиар нарийвчлан заасан байна.

Викториа муж улсын Буруугийн тухай хууль 1958
Wrongs Act 1958
No. 6420 of 1958

Authorised Version incorporating amendments as at
6 April 2020

VB хэсэг - Хүний гэмтлийн хохирол
28B Тодорхойлолт

Энэ хэсэгт нөхөн олговор гэдэг нь хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн олгохыг хэлнэ.
Гэмтэл гэдэг нь хувийн болон бие махбодод гэмтэл учруулахыг хэлнэ

(a) нярайн өмнөх гэмтэл,
(b) сэтгэлзүйн болон сэтгэцийн гэмтэл,
(в) өвчин,
(d) гэмтлийн хүндрэх, давтагдах байдал,

Эдийн бус хохирол гэдэг нь

(a) шаналал, зовлон,
(b) амьдралын тав тухыг алдах,
(в) амьдралын таашаал алдах,

Хувийн гэмтлийн нөхөн олговор гэдэг нь өөр хүний буруугаас хүний амь нас хохирсон, гэмтсэнтэй холбоотой хохирлыг хэлнэ.

28D Шүүхийн нөхөн олговол олгох ерөнхий журам
Шүүх энэ хэсэгт зааснаас өөр нэхэмжлэгчид учирсан хохирлыг барагдуулж болохгүй

28G Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх тухай
Нэхэмжлэгчид эдийн бус хохирол учруулж болзошгүй хохирлын дээд хэмжээ 577050 ам.доллар.
Тодорхой хэмжээний индексжүүлэлт - хэрэглээний үнийн индекс

28G хэсэгт заасан хэмжээг томъёоны дагуу 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхэлсэн санхүүгийн жил болон дараа дараагийн санхүүгийн жил бүрийн хувьд өөрчилж байх ёстой.

$A \times \frac{B}{C}$

A нь 28G хэсэгт заасан дүн юм уу эсвэл энэ хэсгийн дагуу энэ хэмжээг өөрчилсөн бол хамгийн сүүлд өөрчлөгдсөн дүн,
B бол Мельбурн хотын бүх бүлгийн хэрэглээний үнийн индексийг өөрчлөлт оруулсан өдрөөс өмнөхөн буюу зургаадугаар сарын 15-ны байдлаар Австралийн Статистикийн товчооноос хамгийн сүүлд гаргасан мөнгөн дүн,
C нь Австралийн Статистикийн товчооноос 6-р сарын 15-ны байдлаар нийтэлсэн B-д дурдсан лавлагааны хугацаанаас нэг жилийн өмнө харгалзах Мельбурнийн хэрэглээний үнийн индексийг анхны нэр томъёогоор илэрхийлсэн болно.

79 Wrongs Act 1958 (Vic)

80 threshold level means—

- (a) in the case of injury (other than psychiatric injury or spinal injury), impairment of more than 5 per cent;
- (b) in the case of psychiatric injury, impairment of 10 per cent or more;
- (c) in the case of spinal injury, impairment of 5 per cent or more.

28НА Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн тариф

(1) Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг тогтооходоо шүүх тухайн процессын явцад зохих нөхөн олговрын хэмжээг тогтоох зорилгоор тухайн болон бусад шүүхийн урьд гаргасан шийдвэрийг дурдаж болно.

(2) Үүний тулд байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч талууд эсвэл тэдний өмгөөлөгч нар шүүхийн өмнөх анхаарлын төвд байгаа эдийн бус хохирлын нөхөн төлбөрт шүүгчийг чиглүүлж болно.

(3) Энэ хэсэг нь бусад хохирлыг тодорхойлох дүрмийг өөрчлөхгүй.

28LI Тодорхой чадвар алдалтын үнэлгээ⁸¹

(1) Сэтгэцийн эмгэгийн түвшинг үнэлэхийн тулд Америкийн эрүүл мэндийн холбооноос гаргасан удирдамжийг ашиглана. Энэ бүлэгт 14-р зориулан гаргасан журмын дагуу орлуулан хэрэглэх гарын авлага, удирдамжийг "Эмч нарт зориулсан сэтгэцийн эмгэгийн үнэлгээний гарын авлага" хэмээн нэрлэнэ.

28LJ⁸² "Энэ хэсэгт заасны дагуу хувь хүний чадвар алдалт, хохирлын түвшинг үнэлэхдээ сэтгэцийн болон сэтгэлзүйн гэмтэл, аливаа эмгэг, шинж тэмдэг нь заавал бие махбодийн гэмтлийн улмаас улбаалан үүссэн байх албагүй.

- Ажлын байрны ослын улмаас учирсан хохиролд нөхөн олговор тооцох аргачлал

Викториа муж улсын Ажлын байрны ослын нөхөн олговрын тухай хууль 1997 оны 11-р сарын 12-ноос өмнө гэмтэж бэртсэн ажилчид «Маймуудын хүснэгт» -ийн дагуу хохирлын үнэлгээг гаргаж, босго хувийг давсан тохиолдолд хамгийн ихдээ 11,270 ам.долларын нэг удаагийн нөхөн төлбөр авах эрхтэй. 1997 оны 11-р сарын 12-ны өдөр буюу түүнээс хойш гэмтсэн хүмүүст Америкийн эрүүл мэндийн холбооноос гаргасан гарын авлагын дөрөв дэх хэвлэлийг ашигласан үнэлгээний дагуу «хүний бие махбодын гэмтэл 10%, сэтгэцийн эмгэгийн 30%» -ын хуульд заасан хохирлын босго үнэлгээг давсан тохиолдолд нөхөн олговор олгохоор заасан байна.⁸³

- Авто тээврийн ослын улмаас учирсан хохиролд нөхөн олговор тооцох аргачлал

1986 оны Тээврийн ослын тухай хууль (Vic) -ийн 47-р зүйлд нөхөн олговор авахын тулд хувь хүний чадвар алдалтын зэрэг нь 10-аас дээш хувьтай байх босго оноог тогтоосон байна⁸⁴. Хохирлын үнэлгээг ослоос хойш 18 сарын дотор хийх ёстой талаар хуульд заасан байна⁸⁵. Харин хохирлын үнэлгээ нь гарсан тохиолдолд нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг дараах байдлаар тооцон гаргадаг байна

(A - B) / C x \$ 61,940

A нь чадвар алдалтын түвшин,

B нь 10%,

C нь 90%.

Хохирлын үнэлгээ нь 30% ба түүнээс дээш байвал ноцтой хохиролд хамаарна. Харин 50% -иас доош хувьтай байвал 3 жилээс илүүгүй нөхөн олговрын тэтгэмжийг авах бөгөөд нөхөн олговрын дээд хязгаар нь \$99, 220 байна хэмээн тус хуулийн

81 28LI Assessment of certain impairments

(1) For the purposes of assessing the degree of psychiatric impairment the A.M.A. Guides apply, subject to any regulations made for the purposes of this section, as if for Chapter 14 there were substituted the guidelines entitled "The Guide to the Evaluation of Psychiatric Impairment for Clinicians".

82 28LJ Regard not to be had to secondary psychiatric or psychological impairment

In assessing a degree of impairment of a person under this Part, regard must not be had to any psychiatric or psychological injury, impairment or symptoms arising as a consequence of, or secondary to, a physical injury.

83 Accident Compensation Act 1985 (Vic)

84 s 47, Transport Accident Act 1986 (Vic)

85 s 46A, Transport Accident Act 1986 (Vic)

53-р зүйл заасан байна.⁸⁶ Мөн зарим муж улсуудын хууль тогтоомжид заасанчлан тус хуульд хохирлын үнэлгээ нь Америкийн эрүүл мэндийн холбооноос гаргасан 1993 онд хэвлэгдсэн “Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягт, гарын авлага”-т үндэслэсэн байх ёстойг дахин дахин заасан байгааг дурдах нь зүйтэй.

2. Хойд нутаг (Northern Territory) муж улс

Тус муж улсын 2003 оны Хувь хүний гэмтэл (хариуцлага ба хохирол) -ын тухай хуульд хохирлын үнэлгээ 5% аас доошгүй тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлөхөөр ялгамжтайгаар зохицуулжээ⁸⁷. Тэр ч утгаараа энэхүү хохирлын хувь хэмжээг хэрхэн гаргадаг болохыг мөн “Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл, үнэлгээг тогтоох клиник удирдамж”, Америкийн эрүүл мэндийн холбооноос гаргасан “Сэтгэцийн эмгэгийн үнэлгээний гарын авлага”-ыг судлан харах шаардлагатай байна.

“Хувийн осол гэмтэл (өр төлбөр ба хохирол нөхөн барагдуулах) -ын тухай хууль 2003” (Personal Injuries (Liabilities and Damages) Act 2003 (NT))⁸⁸

Энэхүү хуулийн дагуу гаргасан журам. 27-р зүйлийн 2-т: «Хэрэв шүүх байнгын хохирлын түвшинг (non pecuniary loss) нийт хүний 5% -иас бага байхаар тогтоосон бол шүүх [A] шүүхэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ёсгүй.»

A. Чадвар алдалтын (impairment) түвшинг тогтоосон гарын авлагаар үнэлнэ эсвэл

B. Журамд заасны дагуу гарын авлага гаргаагүй бол Америкийн Анагаах ухааны нийгэмлэг хүний чадвар алдалтыг (impairment) үнэлэх удирдамжийг хэрэглэнэ хэмээн заасан байна. Америкийн анагаах ухааны нийгэмлэгийн гарын авлагын хамгийн сүүлийн хувилбарыг (тав дахь хэвлэл, 2001 онд хэвлэгдсэн) ашиглаж ирсэн байна.

3. Шинэ Өмнөд Уэльс (NEW SOUTH WALES) муж

Австрали улсын хамгийн том газар нутагтай муж улс болох Шинэ Өмнөд Уэльс (NSW)-д сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх тухай зохицуулалтыг хэдхэн нарийвчилсан хуулиар зохицуулдаг байна. Үүнд, ажлын байран дахь гэмтэл, үүнээс үүдсэн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг “Ажилчдад олгох нөхөн олговрын тухай хууль” тогтоомжоор, харин тээврийн хэрэгслийн ослоос үүдсэн гэмтэл бэртэл нь 1999 оны “Автомашинны ослын нөхөн төлбөрийн тухай хуулиар” болон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай хууль, 2002 оны Иргэний хариуцлагын тухай хууль (NSW) тус тус зохицуулагддаг байна. Эдгээр хуулийн зорилго нь хөгжлийн бэрхшээл болон хэвийн амьдралын чадвараа алдсан хүмүүст нөхөн төлбөрийг бүрэн олгож хохирлыг бүрэн барагдуулах явдал юм.

Автомашинны ослын нөхөн төлбөрийн тухай хууль 1999 (NSW)

Тус хуулийн 44(1)(c) хэсэгт зааснаар «Автомашинны ослын улмаас учирсан гэмтлийн чадвар алдалтын зэргийг тооцон үнэлэх тухай заасан байна.⁸⁹

Тус хуулийн 131-р хэсэгт хэсэгт “Автомашинны ослын улмаас гэмтэж бэртсэн хүний чадвар алдалтын зэрэг нь 10 хувиас хэтрэхгүй бол эдийн бус хохирлыг нөхөн тооцож болохгүй хэмээн заасан байна⁹⁰”.

Мөн тус хуулийн 133 дугаар хэсэгт зааснаар “Байнгын хөгжлийн бэрхшээлийн түвшинг үнэлэхдээ дараах журмаар тооцно.”

(а) Автомашинны ослын газраас гаргасан эмнэлэг зүйн гарын авлага, эсвэл

(б) Америкийн Анагаах ухааны холбооноос гаргасан чадвар алдалтын түвшинг тогтоох гарын авлага удирдамжийг хэрэглэх хэмээн тус тус заасан байна.

86 s 53, Transport Accident Act 1986 (Vic)

87 Personal Injuries (Liabilities and Damages) Act 2003 (NT)

88 Personal Injuries (Liabilities and Damages) Act 2003 (NT)

89 Автомашинны ослын нөхөн төлбөрийн тухай хууль 1999 (NSW) Motor Accidents Compensation Act 1999 (NSW)

90 Автомашинны ослын нөхөн төлбөрийн тухай хууль 1999 (NSW) Motor Accidents Compensation Act 1999 (NSW)

Мөн тус мужийн Автомашины Ослын газар (МАО) нь дараах тоот тушаалыг батлан гаргаж, даган мөрддөг байна.⁹¹

Эмнэлгийн үнэлгээний удирдамж - 19 дугаар⁹²

Сэтгэцийн өвчний оношийг тодорхойлох

Чадвар алдалтын зэргийг тогтоохдоо “Сэтгэцийн эмгэгийг оношлох статистикийн гарын авлага (4-р хэвлэл) [DSM IV]”, “Өвчний дотоод ангиалал (10-р хэвлэл) [ICD 10]” эсвэл тодорхой судалгаанд үндэслэсэн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн оношилогоонд тулгарласан байх ёстой. Чадвар алдалтын зэргийг тогтоохдоо үнэлгээний тайланд тодорхой шинж тэмдэг, оношийг үндэслэсэн оношлогооны шалгуурыг тодорхойлох ёстой.

Тиймээс дээрх тогтоол шийдвэр дээр үндэслэн Шинэ Өмнөд Уэльсийн Авто тээврийн ослын газар (МАО) нь Автотээврийн ослыг нөхөн төлөх тухай 1999 оны (NSW) дагуу Виктория дахь Эрүүл мэндийн зөвлөлөөс (Сэтгэцийн эмгэг) бэлтгэсэн “Сэтгэцийн эмгэгийн зэрэглэлийг тогтоох клиник удирдамж”-ийг батлах тухай хэлэлцсэн хэдий ч тус гарын авлага нь хохирогчид буюу нэхэмжлэгчдэд хэтэрхий давуу талыг бий болгосон, нэг талыг баримталсан хэмээн үзсэн байна. Тиймдээ ч тус гарын авлагын зохиогчидтой холбоо тогтоосны дараа тус мужийн Автомашины ослын газар нь “Сэтгэцийн эмгэгийн талаарх лавлагаа” болох “Сэтгэцийн хохирлын түвшинг тодорхойлох удирдамж, гарын авлага” боловсруулсан байна. Автомашины ослын нөхөн төлбөрийн тухай хууль 1999 (NSW) хуулийн 5 (1) (д)-д “Хуулийн зорилго нь «хохирлын нөхөн төлбөрийг боломжийн түвшинд байлгах, тухайлбал, харьцангуй хөнгөн гэмтсэн тохиолдолд эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг хязгаарлана» хэмээн заасан байна. Тэрч утгаараа энэхүү эдийн засгийн тооцооллын, зайлшгүй шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд эдийн бус хохирлын түвшинг барагдуулахын тулд чадвар алдалтын зэрэг 10%-аас доошгүй байхаар хуульд заасан байна.

Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягт, гарын авлага

Эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан «Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл» тогтоох маягыг ихэнх тохиолдолд үнэлгээний гол хэрэгсэл болгон ашигладаг байна. Авто ослын газраас батлан гаргасан гарын авлагад өөрийгөө үнэлэх, хувийн эрүүл ахуй, нийгмийн болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, нийгмийн үйл ажиллагаа, төвлөрөлт, тэсвэр тэвчээр, хурд, дасан зохицох зэрэг амьдралын зургаан үйл ажиллагааны чиглэлийг үнэлж тодорхойлсны үндсэн дээр сэтгэл санааны хохирлыг үнэлдэг байна. Энэхүү маягт гарын авлагыг Америкийн сэтгэцийн холбооны гарын авлагын дөрөв дэх хэвлэлтийн холбогдох бүлгээс шууд авсан бөгөөд энэхүү гарын авлагыг зохиогчид хэлэхдээ “Сэтгэцийн эмгэгийн түвшинг 10% -д хүрсэн эсэхийг тодорхойлохын тулд эхлээд бие мах бодийн гэмтлийн түвшин 10% -ийн зэрэгт хүрсэн эсэхийг тогтоох явдал юм” хэмээжээ.

91 Motor accidents authority, Medical Assessor Guidance Note – Number 19

92 Clause 7.13 of the MAA Guidelines directs that: “The impairment must be attributable to a recognised psychiatric diagnosis in accordance with the Diagnostic Statistics Manual of Mental Disorders (4 th Edition) [DSM IV], Internal Classification of Diseases (10 th Edition) [ICD 10] or a substantial body of peer review research literature. 1 The impairment evaluation report must specify the diagnostic criteria upon which the diagnosis is based.”

Үүнээс үзвэл зарим муж улсууд дан ганц сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээс илүүтэй, бие махбодын гэмтэл дээр суурилан үүссэн байхыг шаарддаг байна.

Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягт⁹³

Psychiatric Impairment Rating Scale

J. Parmegiani, D.Lovell, Y.Skinner, R.Milton Sydney NSW Australia 2001

Сэтгэцийн эмгэгийн үнэлгээ нь хүний амьдралын зургаан үйл ажиллагааны түвшинд судалдаг. Үүнд:

1. Өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа

A. Өөртөө анхаарал тавих байдал, хувийн эрүүл ахуйн байдал

B. Нийгмийн болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа

C. Аялал жуулчлал

2. Нийгмийн үйл ажиллагаа (харилцаа холбоо)

3. Төвлөрөлт

4. Дасан зохицох чадвар

Тухайн ангиллын дагуу зэрэглэлийг тогтоодог байна. Ангилал нь хүндийн зэргээсээ хамааран 1-5 хооронд ангилагдан үнэлэгддэг. Үнэлгээг тогтоохдоо стандарт маягтыг заавал ашиглах ёстой.

Өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа

Ангилал 1 Нийт хүн амын дунд хэвийн амьдрах чадвар алдагдалт бага зэрэг байх аль эсвэл чадвар алдагдалт байхгүй байх.

Ангилал 2 Бага зэргийн чадвар алдагдалт (Mild impairment): Бие даан амьдрах чадвартай, биеэ хангалттай харж чаддаг, гэхдээ хааяа эмх замбараагүй харагддаг, заримдаа хоол иддэггүй, эсвэл хүргэлтийн хоол иддэг.

Ангилал 3 Дунд зэргийн чадвар алдагдалт (Moderate impairment): Тогтмол дэмжлэггүйгээр бие даан амьдрах боломжгүй. Өдөр бүр шүршүүрт орж, цэвэр хувцас өмсөх шаардлагатай. Хоолоо өөрөө хийдэггүй, хоолоо тогтмол иддэггүй. Гэр бүлийн гишүүн эсвэл эрүүл мэндийн ажилтан эрүүл ахуй, хоол тэжээлийн доод түвшинг хангахын тулд долоо хоногт 2-3 удаа очдог (эсвэл очих ёстой).

Ангилал 4 Хүнд зэргийн чадвар алдагдалт (Severe impairment): Орон байрны хяналтанд байх шаардлагатай. Хэрэв хараа хяналтгүй бол санамсаргүйгээр эсвэл зориудаар өөрийгөө гэмтээж болзошгүй юм.

Ангилал 5 Бүх чадвараа алдах: Хооллох, бие засах гэх мэт үндсэн функцүүдийн хувьд тусламж хэрэгтэй байна.

Нийгмийн болон амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа

Ангилал 1 Нийт хүн амын дунд хэвийн амьдрах чадвар алдагдалт бага зэрэг байх аль эсвэл чадвар алдагдалт байхгүй байх. Кино театр, ресторан эсвэл бусад амралт зугаалгын газар руу тогтмол явдаг. Клуб эсвэл холбоодод харьяалагддаг бөгөөд эдгээрт идэвхтэй оролцдог.

Ангилал 2 Бага зэргийн чадвар алдагдалт (Mild impairment): Заримдаа нийгмийн харилцаанд оролцоходоо туслах хүн шаардлагагүйгээр гадуур явдаг боловч идэвхтэй оролцдоггүй: Жишээлбэл, бүжиглэх, дуртай багаа хөгжөөн дэмжих зэрэг.

Ангилал 3 Дунд зэргийн чадвар алдагдалт (Moderate impairment): Нийгмийн арга хэмжээнд оролцох нь ховор бөгөөд ихэнхдээ гэр бүл эсвэл дотны найзынхаа хүсэлтээр ирдэг. Дэмжигч хүнгүйгээр гарахгүй. Идэвхтэй оролцдоггүй, чимээгүй хэвээр үлддэг.

Ангилал 4 Хүнд зэргийн чадвар алдагдалт (Severe impairment): Оршин суугаа газраасаа хэзээ ч гарахгүй. Гэр бүлийн гишүүн эсвэл дотны найзынхаа компанийг хүлцэн тэвчдэг боловч бусад нь гэр бүл эсвэл ханьтайгаа уулзахаар ирэхэд өөр өөрөө эсвэл цэцэрлэг рүү явах болно.

Ангилал 5 Бүх чадвараа алдах (Totally impaired). Хэн нэгэнтэй хамт амьдрахыг тэвчихгүй, гэр бүлийнхээ ойр дотны хүн очиход туйлын таагүй байдаг.

93 Psychiatric Impairment Rating Scale J. Parmegiani, D.Lovell, Y.Skinner, R.Milton Sydney NSW Australia 2001

Аялал жуулчлал

Ангилал 1 Нийт хүн амын дунд хэвийн амьдрах чадвар алдагдалт бага зэрэг байх аль эсвэл чадвар алдагдалт байхгүй байх: Хяналтгүйгээр шинэ орчинд аялах боломжтой.

Ангилал 2 Бага зэргийн чадвар алдагдалт (Mild impairment). Дэмжигч хүнгүйгээр аялах боломжтой, гэхдээ зөвхөн орон нутгийн дэлгүүр гэх мэт танил газар, хөршдөө зочлох боломжтой

Ангилал 3 Дунд зэргийн чадвар алдагдалт (Moderate impairment): Туслах хүнгүйгээр өөрийн оршин суух газраас хол явах боломжгүй. Асуудал нь хэт их сэтгэлийн түгшүүр, танин мэдэхүйн доройтлоос үүдэлтэй байж болно

Ангилал 4 Хүнд зэргийн, ноцтой чадвар алдагдалт (Severe impairment): Итгэмжлэгдсэн хүнтэй ч гэсэн өөрийн оршин суух газраас гарах нь туйлын эвгүй санагддаг.

Ангилал 5 Бүх чадвараа алдах (Totally impaired). Гэртээ ч гэсэн хараа хяналтгүй орхиж болохгүй. Хоёр ба түүнээс дээш хүн аялахдаа хяналт тавихыг шаардаж болно.

Нийгмийн үйл ажиллагаа (харилцаа холбоо)

Ангилал 1 Нийт хүн амын дунд хэвийн амьдрах чадвар алдагдалт бага зэрэг байх аль эсвэл чадвар алдагдалт огт байхгүй байх: Олон жилийн турш үргэлжлэх түншлэл, ойр дотно нөхөрлөлийг бий болгох, тогтвортой хэвийн амьдрахад саадгүй байх.

Ангилал 2 Бага зэргийн чадвар алдагдалт (Mild impairment). Одоо байгаа нийгмийн харилцаа хурцадсан. Хамтрагч эсвэл ойр дотны гэр бүлийн гишүүн, хурцадмал байдлын, маргаантай, болон найз нөхөдтэй болсон байх.

Ангилал 3 Дунд зэргийн чадвар алдагдалт (Moderate impairment): Өмнө нь тогтоосон байсан хувийн харилцаа нь бүтэлгүйтэж байсан нь гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалтаар нотлогдсон байх. Гэр бүлийн хүн, хамаатан садан эсвэл олон нийтийн үйлчилгээ нь хүүхдүүдийг нь хардаг байх.

Ангилал 4 Хүнд зэргийн ноцтой чадвар алдагдалт (Severe impairment): Урт хугацааны хувийн тогтвортой харилцаа үүсгэх чадамжгүй. Урьд өмнө байсан дотны найзуудын, хамтран амьдрагчийн харилцаа нь дуусгавар болсон байх. Өөрийн хүүхдүүд, өндөр настай эцэг эх зэрэг өөрөөс нь хамааралтай хүмүүсийг асран хамгаалах чадваргүй байх.

Ангилал 5 Бүх чадвараа алдах (Totally impaired). Нийгмийн хүрээнд ажиллах боломжгүй. Хүн ам ихтэй газраас хол амьдардаг, нийгмийн харилцаанаас зайлсхийдэг.

Төвлөрөлт, тууштай байдал, ба хурд

Ангилал 1 Нийт хүн амын дунд хэвийн амьдрах чадвар алдагдалт бага зэрэг байх аль эсвэл чадвар алдагдалт огт байхгүй байх: коллеж эсвэл их сургуулийн дамжаанд тэнцэн, элсэн орох боломжтой.

Ангилал 2 Бага зэргийн чадвар алдагдалт (Mild impairment): Бага ачаалалтай давтан сургах анхан шатны курс, эсвэл ердийн сургалтад сурах чадвартай байх. Гучин минут хүртэлх хугацааны оюуны өндөр ачаалалтай хийх даалгавар дээр анхаарлаа төвлөрүүлж чаддаг ч дараа нь толгой өвдөх, их хэмжээний ядаргаа мэдрэх шинж тэмдэг илэрдэг.

Ангилал 3 Дунд зэргийн чадвар алдагдалт (Moderate impairment): Өдөр тутмын сонин унших чадваргүй байх. Барилгын төлөвлөгөө, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ зэрэг аливаа үйл ажиллагааны гарын авлага, хэрэглэх заавар зөвлөмжийг уншиж ойлгоход хүндрэлтэй байдаг.

Ангилал 4 Хүнд зэргийн ноцтой чадвар алдагдалт (Severe impairment): Хэдхэн мөр уншсаны дараа анхаарал төвлөрөлтөө алддаг. Энгийн зааврыг дагаж мөрдөхөд бэрхшээлтэй байдаг. Энгийн харилцан ярианы үеэр анхаарал хандуулалт, төвлөрөлтөө алддаг. Ганцаараа амьдрах боломжгүй эсвэл хамаатан садан, нийтийн халамжийн үйлчилгээнээс байнгын тусалцаа авах шаардлагатай байдаг.

Ангилал 5 Бүх чадвараа алдах (Totally impaired): Байгууллагын хүрээнд байнгын хяналт, тусламж хэрэгтэй.

Дасан зохицох чадвар

Ангилал 1 Нийт хүн амын дунд хэвийн амьдрах чадвар алдагдалт бага зэрэг байх аль эсвэл чадвар алдагдалт огт байхгүй байх: Бүтэн цагаар ажиллах боломжтой. Үүрэг, ажлын гүйцэтгэл нь тухайн хүний боловсрол, сургалтын түвшинд таарсан байдаг. Тухайн хүн ажлын энгийн бэрхшээл, шаардлагыг даван туулах чадвартай байдаг.

Ангилал 2 Бага зэргийн чадвар алдагдалт (Mild impairment): Өөр өөр орчинд бүтэн цагаар ажиллах чадвартай. Ажлын үүрэг нь тодорхой хэмжээний ур чадвар, ухаалаг байдлыг шаарддаг. Ижил албан тушаалд ажиллах боломжтой боловч долоо хоногт 20 цагаас илүү ажиллаж чадаггүй. Жишээлбэл: тодорхой хүмүүстэй ажиллахдаа сэтгэл ханамжтай байхаа больсон, нэг тодорхой байршилд ажилладаг.

Ангилал 3 Дунд зэргийн чадвар алдагдалт (Moderate impairment): Нэг байрлалд огт ажиллах боломжгүй. Долоо хоногт 20-оос бага цагийг бага стресс, бага ур чадвар шаарддаг ажлын байранд үүрэг гүйцэтгэдэг.

Ангилал 4 Хүнд зэргийн ноцтой чадвар алдагдалт (Severe impairment): 14 хоногт 20 цаг хүрэхгүй ажиллах, эсвэл 1-2 хоногоос илүү хугацаанд ажиллах чадваргүй. Ажлын ирц тогтворгүй, амьдралын идэвхгүй байна.

Ангилал 5 Бүх чадвараа алдах (Totally impaired): Огтхон ажилдаггүй байх.

Ерөнхий зарчим

Энэхүү чадвар алдалтын зэрэг нь нь хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн эмгэгээс (recognized mental disorder) үүдэн шалтгаалсан байх ёстой. Жишээлбэл, өөртөө анхаарал тавихгүй байгаагаас шалтгаалан танин мэдэхүйн чадвараа алдсан, гадуур явж аялахгүй байгаагаас шалтгаалан хараа муудсан байх зэрэгт энэхүү үнэлгээний маягыг ашиглахгүй.

Энэхүү “Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл”-ийг тогтоох маягыг өвдөлт, соматоформ эмгэгийн улмаас үүссэн чадвар алдалтыг хэмжихэд ашиглахгүй.

Америкийн эмнэлгийн холбооны эрүүл мэндийн гарын авлагыг үүрдийн хөгжлийн бэрхшээл болон эмчилгээний үр нөлөө, эмчилгээ хийлгэхээс татгалзах үндэслэлийн үнэлгээг тогтооход ашиглана.

Урьд өмнө үүссэн гэмтэл байгаа тохиолдолд, дараа нь үүссэн гэмтлийн үнэлгээг өмнө тогтоогдсон гэмтлийн үнэлгээг хасаж тооцно.

Энэхүү үнэлгээний маягыг ашиглан сэтгэцийн эмгэгийг зэрэглэлийг тогтоох нь 2 үйл явцтай байна.

Ангиллын дундаж оноог тодорхойлох

Нийт оноог тооцоолох

Ангиллын голч оноог тодорхойлох: энэхүү үнэлгээнд заасан чиглэл бүрт чадвар алдалтын зэргийн 1-ээс 5-р хүртэл оноог тооцон үнэлгээг өгнө. Өгсөн 6 төрлийн үнэлгээг есөх дарааллаар байрлуулна.

Дараа нь медиан буюу дундаж оноог гаргахдаа эрэмбэлэн байгаа тоон дарааллын голын 2 утгын дунджаар тооцно.

Жишээ А: 1, 2, 3, 3, 4, 5

Медиан дундаж дүн= 3

Жишээ В: 1, 2, 2, 3, 3, 4

Медиан дүн= 2.5 = 3*

Жишээ С: 1, 2, 3, 5, 5, 5

Медиан дүн= 4

Тайлбар- хэрэв дундаж үнэлгээ нь бутархай тоо гарвал дараагийн тоо руу тоймлоно. Жишээ нь- 2.5-ийн дундаж оноо нь 3 болж байна.

Дундаж онооны үнэлгээ ба чадвар бууралтын хувийн хамаарал: Дараах байдлаар дундаж онооны үнэлгээ тус бүр чадвар алдалтын хувьчлалыг тодорхойлно. Медиан ангийн оноо ба хувь буурсан байдал: Медиан ангийн оноо тус бүр дор дурдсанчлан үнэ цэнийн бууралтын түвшинг илэрхийлнэ.

Ангилал 1 (Class 1) = 0 -3%

Ангилал 2 (Class 2) = 4 -10%

Ангилал 3 (Class 3) = 11-30%

Ангилал 4 (Class 4) = 31-60%

Ангилал 5 (Class 5) = 61-100%

Нийт оноог тооцоолох:

Нийт оноог тооцоходоо чадвар алдалтын хувийг тодорхойлно

Нийт оноог тооцоходоо тус бүр ангиллын оноонуудыг хооронд нь нэмнэ

Хөрвүүлэх хүснэгтийг ашиглан нэгтгэсэн нийт оноог хувь руу шилжүүлнэ.

Жишээ А

Оноо

Дундаж үнэлгээ

1	2	3	3	4	5		=3
---	---	---	---	---	---	--	----

Нийт оноо

Нийт оноо

Чадвар алдалтын хувь

1+	2+	3+	3+	4+	5=	18	22%
----	----	----	----	----	----	----	-----

Жишээ В

Оноо

Дундаж үнэлгээ

1	2	2	3	3	4		=3
---	---	---	---	---	---	--	----

Нийт оноо

Нийт оноо

Чадвар алдалтын хувь

1+	2+	2+	3+	3+	4=	15	15%
----	----	----	----	----	----	----	-----

Жишээ С

Оноо

Дундаж үнэлгээ

1	2	3	5	5	5		=4
---	---	---	---	---	---	--	----

Нийт оноо				Нийт оноо				Чадвар алдалтын хувь			
1+	2+	3+	5+	5+	5=	21	44%				

Хөрвүүлэх хүснэгт

CONVERSION TABLE

		Aggregate Score																													
		6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30					
Class 1	%	0	0	1	1	2	2	2	3	3																					
Class 2	%				4	5	5	6	7	7	8	9	9	10																	
Class 3	%								11	13	15	17	19	22	24	26	28	30													
Class 4	%													31	34	37	41	44	47	50	54	57	60								
Class 5	%																			61	65	70	74	78	83	87	91	96	100		

Иргэний Хариуцлагын тухай хууль 2002- Civil Liability Act 2002 (NSW)

2-р хэсэг. Хүний гэмтлийн хохирол

11 Тодорхойлолт

Энэ хэсэгт гэмтэл нь хүний гэмтэл гэсэн үг бөгөөд дараах зүйлийг багтаана.

(а) нярайн өмнөх гэмтэл,

(б) хүний бие махбодын болон сэтгэцийн байдлын доройтол,

(в) өвчин.

Хувийн гэмтлийн хохирол гэдэг нь хүний нас барсан буюу гэмтсэнтэй холбоотой хохирлыг хэлнэ.

11А хэсгийн хэрэглээ

(1) Энэ хэсэг нь 3В хэсэгт зааснаар энэхүү хэсгийн үйл ажиллагаанаас хасагдсан шагналаас бусад тохиолдолд хүний бие махбодид учирсан хохирлын нөхөн олговрын тухайд хамаарна.

(2) Энэ хэсэг нь хохирлын нэхэмжлэлийг эрүүдэн шүүх, гэрээний дагуу, хууль тогтоомжийн дагуу эсвэл өөр хэлбэрээр гаргасан эсэхээс үл хамаарна.

(3) Шүүх энэ хэсэгт харшлахгүйгээр хохирол, нөхөн төлбөрт хүү тооцох боломжгүй.

(4) Хэсэг 2А-т хамаарах хохирлыг нөхөн төлсөн тохиолдолд (Цагдан хорьж байгаа гэмт хэрэгтнүүдэд зориулсан тусгай заалт) энэ хэсгийг 2А хэсэгт хамааруулан хэрэглэнэ.

2-р хэлтэс Эдийн хохирлыг арилгах

3-р хэлтэс Эдийн бус алдагдлын хохирлыг арилгах (ерөнхий хохирол)

16 Эдийн бус хохирлын алдагдлыг тодорхойлох

Эдийн бус хохирлыг хохирлын ноцтой байдлын хэмжүүр нь ихэнх хүнд хэргүүдийн хувь үнэлгээнд суурилан дор хаяж 15%-ийг эзлэхгүй бол эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхийг хориглоно

Эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь 350,000 ам.доллар боловч хамгийн дээд хэмжээг зөвхөн хамгийн ноцтой хэрэгт л олгох ёстой.

Хэрэв эдийн бус хохирлын ноцтой байдал нь хамгийн хүнд хэргүүдийн 15% -тай тэнцүү эсвэл түүнээс их байвал эдийн бус хохирлыг дараах хүснэгтийн дагуу тогтооно.

Хохирлын үнэлгээний хүснэгт.

Эдийн бус алдагдлын ноцтой байдал (хамгийн хүнд хэргүүдийн хувь хэмжээгээр)	Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх (эдийн бус хохиролд оногдуулж болох хамгийн их дүнгийн хувь хэмжээгээр)
15%	1%
16%	1.5%
17%	2%
18%	2.5%
19%	3%
20%	3.5%
21%	4%
22%	4.5%
23%	5%
24%	5.5%
25%	6.5%
26%	8%
27%	10%
28%	14%
29%	18%
30%	23%
31%	26%
32%	30%
33%	33%
34%–100%	34%–100% respectively

(4) (3) дэд хэсэгт заасны дагуу тодорхойлсон дүнг ойрхон 500 ам.долларын нарийвчлалтайгаар тоймлоно (250 ба 750 ам.долларын дүнг дээд утгаараа тоймлоно).

Тэмдэглэл:

Энэ хэсэгт заасны дагуу эдийн бус хохирлыг үнэлэхэд дараах алхмуудыг оруулав.

Алхам 1: Нэхэмжлэгчийн эдийн бус хохирлыг хамгийн хүнд ноцтой хэргийн хувь хэмжээгээр тодорхойлно. Пропорцыг хувь хэмжээгээр илэрхийлэгдэнэ.

Алхам 2: Хамгийн хүнд хэргүүдийн эдийн бус хохирлын дагуу олгох хамгийн дээд хэмжээг баталгаажуулна. Энэ хэмжээг жил бүр 17-р хэсгийн дагуу индексжүүлдэг.

Алхам 3: Хүснэгтийг ашиглан нэхэмжлэлийн дагуу төлөх хамгийн дээд дүнгийн хувийг тодорхойлно. эдийн бус хохирлын хувьд энэ хэсгийн дагуу төлөгдөх төлбөрийн хэмжээг хамгийн хүнд хэрэгт олгогдох дээд хэмжээг хүснэгтэд заасан хувиар үржүүлж тодорхойлно.

Хүнд хэргийн эзлэх хувь 33% -иас их байвал, төлбөрийн хэмжээ нь хамгийн дээд хувь хэмжээтэй тэнцүү байна.

17 Эдийн бус хохирлын алдагдалтай холбоотой хамгийн их дүнг индексжүүлэх

(1) 16-р хэсгийн (2) зорилгоор, Сайд нь 2002 оны 10-р сарын 1-ний өдрөөс өмнө болон дараагийн жил бүрийн 10-р сарын 1-ний өдрөөс өмнө NSW-ийн хууль тогтоомжийн вэбсайтад нийтэлсэн тушаалын дагуу тогтоогдох өдрөөс эхлэн хэрэглэх хэмжээгээ мэдэгдэх үүрэгтэй.

(2) Зарласан дүн нь мэдэгдэл гарахаас өмнөх 4 улирлын туршид Австралийн статистикийн тооцоолсон насанд хүрэгчид бүтэн долоо хоногийн дундаж орлогын хувиар өөрчлөгдсөн дүнгийн дагуу 16 (2) хэсгийн дагуу хүчин төгөлдөр хэрэгжинэ. (эсвэл энэ хэсгийн дагуу хамгийн сүүлд тохируулсан хэмжээгээр).

(3) Энэ хэсэгт заасны дагуу зарласан дүн нь 16 (2) хэсгийн орхигдуулсан хүрээнд ч мөн хүчин төгөлдөр хамаарна.

(4) Хэрэв Австралийн статистикч дэд хэсэг (2) -д дурдсан дүнг тооцоогүй эсвэл тооцоход алдаа гаргасан бол зарласан дүнг журмын дагуу тогтооно.

(5) Хэсэг 16 (2) -ын дагуу зарлах дүнг тохируулахдаа дэд хэсэг (2) -д заасны дагуу тодорхойлсон дүнг 500 ам.долларын тоймлолтойгоор (250 ба 750 ам.долларын дүнг нэгтгэн) нэгтгэх шаардлагатай.

(6) Жилийн 10-р сарын 1-ний дараа NSW-ийн хууль тогтоомжийн вэбсайт дээр зарлагаар зарласан дүнг хэрэгжүүлэх өдрийг зааж өгсөн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

17А Эдийн бус алдагдлын хохирлын тариф

(1) Эдийн бус хохирлыг тогтооходоо шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохих шийдвэрийг тогтоох зорилгоор тухайн болон бусад шүүхийн урьд нь гаргасан шийдвэрүүдийг дурдаж болно.

(2) (2) Үүний тулд байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч талууд эсвэл тэдний Австралийн хуульчийн мэргэжилтэн шүүхийн өмнөх шийдвэрүүдэд эдийн бус хохирлын талаарх зохих шийдвэрийг харгалзан нөхөн төлбөр олгоход шүүхийн анхаарлыг хандуулж болно.

(3) Энэ хэсэг нь бусад хохирлыг тодорхойлох дүрмийг өөрчлөхгүй.

4-р хэлтэс Хохирлын хүү

18 Хохирлын хүү

(1) Шүүх дараах зүйлийн аль нэгэнд учирсан хохирлын хүүгийн төлбөрийг шаардахгүй.

(а) эдийн бус хохирол,

(б) 15-р хэсэгт заасны дагуу үйлчлэгчдэд үзүүлэх үнэгүй үйлчилгээ (15А хэсэгт хамаарах үйлчлэгчдэд үзүүлэх үнэгүй үйлчилгээнээс бусад),

(в) нэхэмжлэгчийн асрамжид байгаа хүмүүст үнэ төлбөргүй дотоодын үйлчилгээ үзүүлэх чадавх алдах (15Б хэсэгт заасны дагуу) тооцно.

Нэхэмжлэгч нь эдийн бус хохирлоо нэхэмжилж хохирлоо барагдуулахын тулд хууль тогтоомжид заасан босгыг давсан байх ёстой. 2002 оны Иргэний хариуцлагын тухай хууль (NSW), 16-т: «Эдийн бус хохирлын хэмжээ нь онц ноцтой хэргийн гэмтлийн үнэлгээний 15-аас доошгүй хувьтай тэнцэхгүй бол нэхэмжлэгчид эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхгүй» гэж заасан байдаг⁹⁴. Энэхүү хуульд заасан “хамгийн онц ноцтой хэрэг” гэдэг нь хэргийн ангиллыг хэлнэ. Үүнд, нурууны сээр ясны хугарал, тархины хүнд гэмтэл, хүнд хэлбэрийн түлэгдэлт ба сорвижилт зэрэг гэмтлийн дээд хэлбэрийг ангиллыг хэлж байгаа бөгөөд аливаа хэргийн хохирлын хэмжээг тогтоохын тулд хамгийн хүнд зэргийн гэмтэлтэй харьцуулан гэмтлийн зэргийг тогтоох шаардлагатай. Энэхүү гэмтлийн зэрэг хувьчлалыг тогтоосны дараа хуулиар тогтоосон мөнгөн дүнг үржүүлэн тооцох аргачлалыг хэлж байгаа билээ.⁹⁵

Тус хуулийг хэрхэн хэрэглэх талаар шүүгч тайлбарласан нэгэн Австрали Улсын хэргийг авч үзье. Жишээ нь: *Flight Center v Louw* [2011] NSWSC 132 гэсэн хэрэгт шүүх нэхэмжлэгчдийн «сэтгэлийн таагүй байдал, сэтгэлийн зовиур, урам хугарах» зэрэг шинж тэмдгүүд сэтгэц, болон сэтгэл санааны хохиролд тооцож болохыг тогтоожээ.⁹⁶ *Flight Center v Janice Louw* [2011] NSWSC 132-т NSW- гэх хэрэгт анхан шатны шүүх эвгүй байдал, зовлон, урам хугарлын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл нь хүний бие махбодод учирсан хохирлын нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг бүрдүүлж, улмаар Иргэний хариуцлагын тухай хуулийн заалтыг ашиглан нөхөн олговор олгосон байна.

Тэрбээр Шинэ Өмнөд Уэльсийн шүүхэд давж заалдах гомдол гаргахад 2005 оны Иргэний хариуцлагын тухай хуулийн 16 дугаар хэсгийг (NSW) зохимжгүйгээр хэрэглэсэн тул энэхүү нөхөн олговрыг давж заалдах шатны шүүх нь хүчингүй болгожээ. Иргэний хариуцлагын тухай хуулийн 16-р хэсэгт «хамгийн онц ноцтой тохиолдлын» 15%-ийн босго шаардлагыг хангаагүй тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхийг хориглодог.

94 [Civil Liability Act 2002](#) (NSW).

95 https://www1.worksafe.vic.gov.au/vwa/claimsmanual/Claims_Manual/6-specialisedpayments/6.2_Impairment_Benefits/6.2.8_Table_of_maims_claims/6.2.8.9_Pain_and_suffering_for_injuries_from_1_December_1992_to_11_November_1997.htm

96 *Flight Center v Louw* [2011] NSWSC 132

Гэвч энэхүү хэрэгт тохиолдсон сэтгэл санааны хохирол нь хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчний ангилалд багтаагүй бөгөөд мөн 16-р зүйлд заасан эдийн бус хохирлын 15% -ийн босгыг давж чадаагүй байсан тул нөхөн олговор олгох үндэслэлгүй гэж үзсэн байна.

Улсын Дээд шүүхэд тус хуулийн 16-р хэсэг нь зөвхөн хүний биед учирсан хохирлын нөхөн төлбөрийн нэхэмжлэлтэй холбоотой гэж үзэж байгаа бөгөөд түүний нэхэмжлэл нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй хэмээн тайлбар өгчээ. Өөрөөр хэлбэл Иргэний хариуцлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь бие махбодын болон сэтгэцийн гэмтлээс улбаатай сэтгэл дундуур, сэтгэлийн зовлонгоос учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хэмээсэн байна. Шүүгч аливаа нэхэмжлэгчийн эдийн бус хохирол нь хуульд заасан хамгийн бага босгонд хүрснийг тогтоосны дараа тэрээр эдийн бус хохирлыг хууль ёсны үнэлгээний хүснэгтийн дагуу хувь тэнцүүлэн тооцож олгож болно хэмээн тайлбарласан байна.

Тус хуулийн 16 (4) -р хэсэгт шүүгч⁹⁷ “Энэ хэсгийн дагуу эдийн бус хохирол учирсан тохиолдолд оногдуулж болох дээд хэмжээг баталгаажуулах” -ыг үүрэг болгосон байна. Үүний дараа шүүгчид “Хүснэгтийг ашиглан нэхэмжлэлийн талаар төлөх хамгийн дээд дүнгийн хувийг тодорхойлно уу” гэж чиглэл гаргасан. Тус хуулийн 16.4-ийн дагуу эдийн бус алдагдлын төлбөрийн эцсийн дүнг «хамгийн онцгой тохиолдолд олгож болох дээд хэмжээг хүснэгтэд заасан хувиар үржүүлж» тодорхойлно. Шүүгч эдийн бус хохирлын ноцтой байдлыг 33% -иас дээш буюу түүнээс дээш зэрэгтэй гэж үнэлэх тохиолдолд нэхэмжлэгч эдийн бус алдагдлын хамгийн онцгой тохиолдол хэмээн үзэн хохирлын дээд хэмжээг хуульд заасны дагуу хамгийн дээд хэмжээгээр нөхөн олговор авдаг.

Сэтгэл санааны хохиролд нөхөн олговор олгох хууль зүйн зохицуулалт нь нэг сэтгэцийн гэмтэл, болон цэвэр сэтгэцийн хохирол гэсэн тусдаа ойлголтууд юм.⁹⁸

Австралийн Шинэ өмнөд Уэльс, Тасмани, Баруун Австрали, Австралийн нийслэл нутаг дэвсгэр, Викториа, өмнөд Австрали гэсэн муж улсууд нь (Викториа мужаас бусад нь) “мэдрэлийн цочрол” -гэсэн хохирлыг “сэтгэцийн гэмтэл” гэж үзэн, сэтгэцийн гэмтэл нь “тухайн хүний сэтгэцийн байдлын доройтол” гэж хууль тогтоомжид тодорхойлжээ. .

Австралийн зургаан мужууд нь нийтдээ mental harm буюу «сэтгэцийн хохирол» гэсэн хууль зүйн ойлголтын үүднээс хоёр үндсэн ангилдаг байна.⁹⁹

- Consequential mental harm буюу “үр дүнд бий болсон сэтгэл санааны хохирол” гэх хууль зүйн ойлголт нь бие махбодод гэмтэл учруулснаас үүдэх (бие махбодод гэмтэл авсны улмаас сэтгэлийн хямралд ордог); сэтгэцийн хохирол байдаг бол
- “Сэтгэцийн цэвэр гэмтэл”, энэ нь гэрч болж гэмтлийн үйл явдалд оролцож нүдээр харсан эсвэл хайртай хүнээ алах, гэмтээсэн бол мэргэжлийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчнөөр өвдсөн байхыг хэлнэ.

97 Flight Center v Louw [2011] NSWSC 132

98 Mendelson, Danuta. (2005). The modern Australian law of mental harm: parochialism triumphant. Journal of law and medicine. 13. 164-72.

99 Mendelson, Danuta. (2005). The modern Australian law of mental harm: parochialism triumphant. Journal of law and medicine. 13. 164-72.

2002 оны Иргэний хариуцлагын тухай хуулийн 3-р хэсэгт (NSW) зааснаар холбогдох хүн нь амь насаа алдсан, гэмтсэн, аюулд өртсөн хүн бол нэхэмжлэгч нь сэтгэцийн болон мэдрэлийн цочролын улмаас хүлээн зөвшөөрөгдсөн, оношлогдохуйц сэтгэцийн гэмтэл авсан тохиолдолд сэтгэцийн цэвэр хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болно. Цэвэр сэтгэцийн гэмтлээр хохирсон хүн “хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчин”-өөр хохирсон тохиолдолд л нөхөн төлбөрийг олгодог бөгөөд тогтоохын тулд мэргэжлийн шинжээчийн нотолгоо шаардагддаг.

2002 оны Иргэний хариуцлагын тухай хуулийн 3-р хэсэгт (NSW) (“Хууль”) зааснаар Хариуцлагагүй байдлаас улбаалан амь насаа алдсан, гэмтсэн, аюулд өртсөн хүний хамсаатан нэхэмжлэгч нь өөр хүнтэй холбогдуулан сэтгэцийн болон мэдрэлийн цочролын улмаас хүлээн зөвшөөрөгдсөн, оношлогдохуйц сэтгэцийн гэмтэл авсан тохиолдолд сэтгэцийн цэвэр хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болно.

Тус хэсэгт заасны дагуу нэхэмжлэл гаргах үндэслэл нь дараах ангилалд хамаарна.

1. Хэргийн газар хохирогчийн амь насыг нь бүрэлгэсэн, бэртэл учруулсан, гэмтээсэн, аюулд орсныг харсан хүн; (жишээ нь үл таних этгээд өөр хүний хайхрамжгүй байдлаас болж автомашины ослоор гэмтэж бэртсэнийг харсны дараа сэтгэцийн гэмтэл авсан хүн хамаарна). эсвэл

2. Хохирогчийн гэр бүлийн ойрын гишүүн (жишээлбэл, талийгаачийн хохирогчийн хүүхэд, дараа нь эцэг эх нь нас барсан тухай мэдэгдэж, улмаар гэмтлийн дараах стресс, эмгэг зэрэг сэтгэцийн гэмтэл авсан эцэг эх, хамтрагч, хүүхэд, ах эгч).

Гэмтсэн хүн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчний шинж чанараараа хохирол амссан болохыг шинжээчийн нотолгоогоор тогтоосон байх ёстой гэж ерөнхийлөн заасан ч чухам ямар өвчин, сэтгэлийн зовиурыг хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзэх талаар нарийвчлан хууль тогтоомжид тусгаагүй болно. Тодруулбал, гэмт этгээдийн үйлдэл нь хохирогчийг стресст өртөх магадлалтай гэж үзсэн боловч хохирогч нь “хүлээн зөвшөөрөхүйц сэтгэцийн гэмтэл” гэж тусгайлан тогтоогдохгүй бол нөхөн төлбөр олгох боломжгүй байна. Харин хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчнөөр өвчилсөн эсэхийг тогтоохын тулд “Сэтгэцийн эмгэгийг оношлох, статистикийн гарын авлага”-ын тогтмол ашиглах хандлага Австрали Улсын ихэнх мужид ажиглагдаж байна¹⁰⁰. Өөрөөр хэлбэл, тус гарын авлагад хамаарах ангиллаас гадуурх сэтгэцийн гэмтэлд нөхөн төлбөр олгогдохгүй болно. Жишээ нь сэтгэлийн зовиур, түгшүүр, уй гашуу нь “хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчин, гэмтэлд харьяалагдахгүй байх хандлагатай.”¹⁰¹ Сэтгэл мэдрэлийн өвчнийг бий болгоход цочрол хангалттай байдаг тул гэмтлийн дараах стрессийг тус ангилалд хүлээн зөвшөөрсөн байна.

100 Stannard, J. E. (2010). Sticks, stones and words: Emotional harm and the English criminal law. *The Journal of Criminal Law*, 74(6), 533-556.

101 Koch, W.J., Douglas, K.S., Nicholls, T.L. and O'Neill, M.L., 2005. *Psychological injuries: Forensic assessment, treatment, and law*. Oxford University Press.

Сэтгэцийн эмгэгийг оношлох, статистикийн гарын авлага

(Diagnostic and statistical manual of mental disorders)

Хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчин гэж яг юу хэлэх талаар олон улсад нэгдсэн тодорхойлолт арга барил байхгүй. Ихэвчлэн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчин байгаа эсэх тухай асуудлын талаарх сонсгол болоход ихэнх тохиолдолд холбогдох оношилгоо, статистикийн гарын авлагыг мэргэжилтнүүд ашигладаг боловч энэ нь заавал хэрэглэгдэх ёстой цорын ганц эх сурвалж биш юм. Гэвч хууль эрх зүйн хүрээнд байнга ашигладаг оношилгооны хэрэгсэл бол DSM - Сэтгэцийн эмгэгийг оношлох, статистикийн гарын авлага юм.¹⁰² Сэтгэцийн эмгэгийг оношлох, статистикийн гарын авлага (DSM; хамгийн сүүлийн хэвлэл: DSM-5, нийтлэл. 2013) нь нийтлэг хэл, стандарт шалгуураар сэтгэцийн эмгэгийг ангилах зорилгоор Америкийн сэтгэцийн ассоциациас (APA) гаргасан бүтээл юм.¹⁰³ Үүнийг эмч, судлаачид, сэтгэцийн эмийг зохицуулах агентлагууд, эрүүл мэндийн даатгалын компаниуд, эмийн үйлдвэрүүд, хууль эрх зүйн систем, бодлого боловсруулагчид түгээмэл ашигладаг.

DSM нь хүн амын тооллого, сэтгэцийн эмнэлгийн статистик мэдээллийг цуглуулах систем, АНУ-ын армийн гарын авлагаас үүссэн юм. 1952 онд анх хэвлэгдсэнээс хойшх шинэчлэлтүүд сэтгэцийн эмгэгүүдийн тоог нэмж, шүүх эмнэлгийн зорилгоор биш харин эмнэлзүйн нөхцөлд ашиглах хэрэгсэл болох зорилготой байв.¹⁰⁴ DSM-I нь Америкийн сэтгэцийн ассоциациас 1952 онд анх хэвлэгдсэн бөгөөд DSM-3-R нь 1987 онд, DSM-IV 1994 онд тус тус хэвлэгдсэн.¹⁰⁵ Тухайлбал, Америкийн сэтгэцийн ассоциациас гаргасан «Сэтгэцийн эмгэгийн оношилгоо, статистикийн гарын авлага» (DSM IV) -д зааснаар сэтгэлзүйн хямрал, сэтгэлийн түгшүүр гэх мэт гэмт хэргийн улмаас түгээмэл тохиолддог сэтгэцийн эмгэгийн талаар дэлгэрэнгүй тайлбарласан¹⁰⁶ байна. Өвчтөнд сэтгэл гутралын гол эмгэг оношлогдохын тулд 'A' хүснэгтэд заасны дагуу дор хаяж нэг томоохон сэтгэл гутралын шинж тэмдэг ажиглагдсан байх ёстой¹⁰⁷. Өвчтөн сэтгэцийн бухимдал, түгшүүрийн эмгэгийг оношлохын тулд 'B' хүснэгтэд заасан шалгуурыг хангасан байх ёстой. Эдгээр оношилгоо хоёулаа сэтгэл санааны хохирлын сэтгэлзүйн хямралыг хамарч болзошгүй бөгөөд энэ нөхцөл байдал нь «эмнэлзүйн хувьд чухал ач холбогдолтой зовиур» -ыг агуулсан байх ёстой байна.

Хүснэгт «А». Major Depressive Episode- Сэтгэл санааны гутралын гол шинж тэмдэг¹⁰⁸
DSM IV шалгуур¹⁰⁹

Хоёр долоо хоногт өвчтөнд дараахь шинж тэмдгүүд тав буюу түүнээс дээш гарсан бөгөөд энэ нь ердийн функцээс тодорхой өөрчлөлт юм. Сэтгэлийн хямрал, сонирхол буурах эсвэл таашаал авах нь эдгээр таван зүйлийн нэг байх ёстой.

102 Edition, F., 2013. Diagnostic and statistical manual of mental disorders. Am Psychiatric Assoc, 21.

103 Edition, F., 2013. Diagnostic and statistical manual of mental disorders. Am Psychiatric Assoc, 21.

104 Stannard, J. E. (2010). Sticks, stones and words: Emotional harm and the English criminal law. The Journal of Criminal Law, 74(6), 533-556.

105 Teff, H., 1992. Liability for psychiatric illness after Hillsborough. Oxford Journal of Legal Studies, 12(3), pp.440-452.

106 Stannard, J. E. (2010). Sticks, stones and words: Emotional harm and the English criminal law. The Journal of Criminal Law, 74(6), 533-556.

107 Edition, F., 2013. Diagnostic and statistical manual of mental disorders. Am Psychiatric Assoc, 21.

108 Edition, F., 2013. Diagnostic and statistical manual of mental disorders. Am Psychiatric Assoc, 21.

109 Stannard, J. E. (2010). Sticks, stones and words: Emotional harm and the English criminal law. The Journal of Criminal Law, 74(6), 533-556.

<p>Сэтгэлийн байдал. Өвчтөн бараг өдөр бүр ихэнхдээ сэтгэлийн хямралд орсон, бусдад сэтгэлээр унасан байдалтай байдаг гэж мэдээлдэг.</p> <p>Сонирхол. Бараг өдөр бүр ихэнх тохиолдолд сонирхол эсвэл таашаал нь бараг бүх үйл ажиллагаанд эрс буурдаг (өвчтөн эсвэл бусад хүмүүс тэмдэглэдэг).</p> <p>Хооллох ба жин. Хэдийгээр хоолны дэглэм барьдаггүй ч жин хасах буюу нэмэгдэх (нэг сарын дотор таван хувь гэх мэт) эсвэл хоолны дуршил өдөр бүр бараг буурч эсвэл нэмэгддэг.</p> <p>Унтах: Бараг өдөр бүр өвчтөн хэт их унтдаг эсвэл хангалтгүй унтдаг.</p> <p>Тархины үйл ажиллагаа: Бараг өдөр бүр цочромтгой хоцрогдсон байгааг харж болно.</p> <p>Ядаргаа. Бараг өдөр бүр ядаргаа, эрч хүчгүй болдог.</p> <p>Өөрийгөө үнэлэх. Бараг өдөр бүр өвчтөн үнэ цэнгүй эсвэл зохисгүй гэм буруутай мэт санагддаг. Аль эсвэл хуурамчаар тийм байгаа мэт жүжиглэж байж болно.</p> <p>Төвлөрөлт. Өвчтөн бараг өдөр бүр шийдвэргүй, эсвэл бодох, төвлөрөхөд бэрхшээлтэй байдаг.</p> <p>Үхэл. Өвчтөн үхэл (үхэхээс айхаас бусад), амиа хорлох тухай (төлөвлөгөөтэй эсвэл төлөвлөгөөгүй) талаар удаа дараа бодож байсан эсвэл амиа хорлох оролдлого хийсэн.</p> <p>Эдгээр шинж тэмдгүүд нь сэтгэл зүйн хямралыг үүсгэхэд эмнэлзүйн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд ажил, нийгмийн болон хувийн үйл ажиллагааг алдагдуулдаг байна.</p> <p>Тэд Холимог эпизодын шалгуурыг хангаж чадахгүй байна.</p> <p>Энэ эмгэг нь эрүүл мэндийн ерөнхий нөхцөл байдал, эсвэл эмийн жор, түүний дотор бодис хэрэглэснээс шууд үүдэлтэй биш юм.</p> <p>Эдгээр шинж тэмдгүүд нь дотны хүнээ алдсанаас хойш хоёр сарын хугацаанд илрээгүй бол хүнд хэлбэрийн шинжтэй биш (хүнд хэлбэрийн байдал гэдэг нь үнэ цэнгүй мэдрэмжид хэт автах, амиа хорлох санаа, хуурмаг байдал, хий үзэгдэл, сэтгэцийн болон хөдөлгөөний хоцрогдолтой байхад илэрдэг)</p> <p>Хүснэгт 'B'. Ерөнхий түгшүүрийн эмгэгийн DSM IV шалгуур</p> <p>Наад зах нь зургаан сарын дотор хагасаас илүү хоногийн турш өвчтөн хэт их түгшүүртэй болж, хэд хэдэн үйл явдал, үйл ажиллагааны талаар санаа зовдог байх.</p> <p>Тухайн хүн эдгээр мэдрэмжийг хянахад бэрхшээлтэй байдаг.</p>
<p>Энэхүү түгшүүр, түгшүүртэй холбоотойгоор өвчтөнд дараах шинж тэмдгүүдийн гурав ба түүнээс дээш шинж тэмдэг илэрдэг бөгөөд эдгээр шинж тэмдгүүд нь сүүлийн зургаан сарын хагасаас илүү хугацаанд ажиглагддаг.</p> <p>Тайвширсан, ууртай, түлхүүртэй юм шиг санагддаг. Дугуй амархан.</p> <p>Төвлөрөхөд асуудал гарав. Цочромтгой байдал.</p> <p>Булчингийн хурцадмал байдал нэмэгдсэн.</p> <p>Унтах асуудал (анхны нойргүйдэл эсвэл тайван бус, сэргээгчгүй унтах).</p> <p>Шинж тэмдгүүд нь эмнэлзүйн хувьд чухал ач холбогдолтой сэтгэлийн хямралыг үүсгэдэг эсвэл ажил, нийгмийн болон хувийн үйл ажиллагааг алдагдуулдаг.</p> <p>Энэ эмгэг нь эрүүл мэндийн ерөнхий нөхцөл байдал, эсвэл мансууруулах бодис, мансууруулах бодис зэрэг мансууруулах бодис хэрэглэснээс шууд үүсдэггүй.</p> <p>Энэ нь зөвхөн сэтгэлийн хямрал, сэтгэлзүйн эмгэг, гэмтлийн дараах стресс, хөгжлийн тархалтын эмгэгийн үед тохиолддоггүй.</p>

Шүүхийн шийдвэр

1944 онд Шинэ Өмнөд Уэльсийн парламент нь аливаа нэг хэргийн улмаас учирсан мэдрэлийн цочролын хууль ёсны үндэслэлийг тогтоосон бөгөөд үүнд амь насаа алдсан, шархадсан, аюулд өртсөн хүний гэр бүлийн гишүүн нь тухайн хэргийн хажууд байсан эсвэл сонссон байвал “nervous shock” буюу мэдрэлийн цочролд хүрэх боломжтой гэж үзэн нөхөн олговор олгодог болсон байна. Үүнтэй ижил төстэй заалтыг 1955 онд Хойд нутаг дэвсгэр муж улс болон ба Австралийн нийслэл нутаг дэвсгэр муж улсууд баталжээ. Бусад харьяалал нь нийтлэг хуулиар зохицуулагддаг бөгөөд цэвэр мэдрэлийн цочролын тохиолдлуудад анхаарал халамж тавих үүрэгтэй тул нэхэмжлэгчид хэргийн газарт байлцаж, ойрын хамаатныхаа гэмтэл, үхлийг заавал өөрсдөө гэрчилж хажууд нь байж мэдэрсэн байх заавал шаардлагагүй гэж үздэг байна.¹¹⁰

110 Chester v Council of Municipality of Waverley (1939) 62 CLR 1).

Хууль зүйн шинэчлэлийн дагуу зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчнөөр өвчилсөн, мэдэгдэхүйц эмгэгтэй болсон хохирогчид хохирлыг нөхөн төлж болохоор тайлбарласан Австралийн бас нэг алдартай хэрэг бол Дээд шүүхийн *Jaensch v Coffey* (1984) 155 CLR 549¹¹¹ тоот шийдвэр юм. Энэхүү хэрэгт нөхөр нь тээврийн хэрэгслийн осолд хүндээр бэртэх үед хэргийн газар бус гэртээ байсан хатагтай Коффигийн хувьд «сэтгэцийн цэвэр гэмтэлд» нөхөн олговор олгосон байна. Хатагтай Коффи ослын газарт байхгүй ч гэсэн гэмтсэн нөхрөө ослын дараахь эмчилгээнд хамрагдах хугацаанд эмнэлэгт харж асарсан тул сэтгэцийн цэвэр хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой гэж шүүх тогтоов.

Учир нь нөхрийнхөө ослын талаар цагдаагийн байгууллагад мэдэгдсэний дараа хатагтай Коффи хатан Аделаидын эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт очиж, түүнийг хагалгаанд оруулж байгааг харжээ. *Jaensch v Coffey*-ийн шийдвэрийг шүүх гаргасны дараа нэхэмжлэгчид хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж чадсан бөгөөд ослын газарт бие махбодын хувьд байхгүй ч гэсэн энэ нь тэдний хайртай хүмүүс нас барсан, гэмтсэнтэй холбоотой цочролын үр дүнд хохирол гарсан байх ёстой. Гэхдээ нэхэмжлэгчид уг гэмт хэргийн үйл явдлын “шууд үр дагаврыг” харааны эсвэл сонсголын мэдрэхүйгээр мэдэрсэн байх шаардлагыг тавьдаг байна.

4. Куинсланд муж улс

Куинсланд муж улс мөн адил 2003 оны Иргэний хариуцлагын тухай хуулийн 6-р хэсэгт Сэтгэцийн эмгэгийн зэрэглэлийг тодорхойлсон маягт удирдамжийг ашиглахаар хуульчлан заасан байна. Энэхүү хууль тогтоомжид заасан “Сэтгэцийн эмгэгийн зэрэглэлийг тодорхойлсон маягт удирдамж” нь Шинэ Өмнөд Уэльсийн Автомашины ослын газрын бэлтгэсэн гарын авлагатай тун төстэй¹¹². Ялгаатай тал нь хүний сэтгэцийн эмгэгийг бүхэлд нь тооцоолох заавраар дундаж ангиллын оноог хувь үнэлгээ болгон хөрвүүлэхийг шаарддаг бол Иргэний хариуцлагын журам 2003 (Qld) -д заасан арга нь ангиллын медиан оноо болон нийт тооцоолон гаргасан 2 тоон утгыг “Хөрвүүлэх хүснэгт” -ийг ашиглахаас өмнө гарган авдаг байна. Тус хуулийн 61-р хэсэгт (Qld) «2002 оны 12-р сарын 1-ний өдрөөс хойш үүссэн гэмтэлтэй холбогдуулан шүүхээс ерөнхий хохирлыг барагдуулахаар бол шүүх гэмтлийн хуваарийн үнэлгээг 0-ээс 100 хүртэлх шатлалаар үнэлэх ёстой»¹¹³ гэж заасан байна.

111 *Jaensch v Coffey* (1984) 155 CLR 549

112 (1) This section applies if –

(a) a court is assessing an ISV; and

(b) a PIRS rating for a mental disorder of an injured person is relevant under schedule 4.

(2) The PIRS rating for the mental disorder of the injured person is the PIRS rating accepted by the court.

(3) A PIRS rating is capable of being accepted by the court only if it is –

(a) assessed by a medical expert as required under schedules 5 and 6; and

(b) provided to the court in a PIRS report as required under schedule 5, section 12

113 Section 61 of the Civil Liability Act 2003 (Qld)

Журмын 4-ийн 2-р хэсэгт сэтгэцийн эмгэгийн хүндийн зэргийг хэрхэн үнэлэх талаар дараах байдлаар тусгасан болно.¹¹⁴

10-р зүйл - сэтгэцийн онц ноцтой эмгэг (Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягтад үндэслэн 31-100%);
 11-р зүйл - сэтгэцийн ноцтой эмгэг (Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягтад үндэслэн 11-30%);
 12-р зүйл - дунд зэргийн сэтгэцийн эмгэг (Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягтад үндэслэн 4-10%);
 Зүйл 13 - сэтгэцийн бага зэргийн эмгэг (Сэтгэцийн эмгэгийн үнэлгээг тогтоох маягтад үндэслэн 0-3%).

Иймд гэмтлийн хуваарийн үнэлгээг тав ба түүнээс бага гэж үнэлсэн бол масштабын утгыг 1000 ам.доллараар үржүүлнэ. Хэрэв масштабын утгыг 10 ба түүнээс бага боловч таваас дээш гэж үнэлсэн бол 5аас дээш утгыг 1200 ам.доллараар үржүүлж, 5000 ам.доллар нэмнэ. Хамгийн хүнд гэмтлийн хувьд 90-100-ийн хооронд үнэлэгдэх хохирлыг 215,000 ам.доллараар тогтоосон ба 90-ээс хэтэрсэн тоог 3500 ам. доллароор үржүүлнэ.¹¹⁵

5. Өмнөд Австрали муж¹¹⁶

Өмнөд Австрали мужийн Иргэний хариуцлагын тухай хууль 1936
 South Australia Civil Liability Act 1936¹⁷¹
 Агуулга
 Зөрчлийн болон буруугийн үйл хэрэгтэй холбоотой зарим үйлдлийг нэгтгэх тухай хууль.
 51 дүгээр бүлэг. Энэхүү хэсгийн хэрэглээ
 Энэ хэсэг хамаарна.
 (а) дараахь шалтгаанаар үүссэн хувийн гэмтэлд учирсан хохирлыг нэхэмжилсэн тохиолдолд.
 (I) автомашины осол (санаатай болон санамсаргүй байдлаар гарсан)
 (II) бүхэлд нь буюу хэсэгчлэн гаргасан осол
 (А) хайхрамжгүй байдал,
 (В) бусдын санамсаргүй байдлаар хүчирхийлсэн бусад гэмт хэрэг
 гэмтсэн хүнээс илүү,
 (С) асрамжийн гэрээний үүргээ зөрчсөн,
 б) (а) –д заасан журмаар үүссэн хувийн гэмтэл нь үхэлд хүргэж, 5-р хэсэгт заасны дагуу нас барсны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардсан тохиолдолд.
 52 дугаар бүлэг. Эдийн бус алдагдлын хохирол
 (1) Хохирлыг эдийн бус алдагдалд л тооцож болно.
 (а) Гэмтсэн хүний хэвийн амьдрах чадвар дор хаяж 7 хоногийн хугацаанд гэмтсэний улмаас ихээхэн доройтсон; эсвэл
 (б) Гэмтэлтэй холбоотой эмчилгээний зардлыг дор хаяж тогтоосон доод хэмжээнээс багагүй байхаар тооцсон болно.
 (2) Хэрэв MVA автомашины ослын улмаас үүссэн хүний гэмтэл бэртэл гэмтлээс бусад эдийн засгийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр бол дараах байдлаар үнэлнэ.
 (а) Гэмтсэн хүний эдийн бус нийт алдагдлыг 0-ээс 60 хүртэлх масштабаар тоон утга (масштабын утга) (эдийн бус алдагдлын 60 тэнцүү зэрэглэлийг тусгасан хуваарь, эдийн бус хохирол нь гэмтэж бэртсэн хүнд эдийн засгийн хувьд хамгийн хүндээр тооцогдох хохирол учруулсан тохиолдолд учирсан гэм хорыг арилгах үндэслэлтэй байх ноцтой биш юм),
 (б) Эдийн бус алдагдлын хохирлыг масштабын утгыг 1710 ам.доллараар үржүүлж 2002 оны үеэр гарсан ослын улмаас үүссэн гэмтэлтэй холбоотойгоор тооцно.

114 Part 2 of Sch 4 of the Regulation sets out “items” that rate the severity of the mental disorder as follows:
 Item 10 – extreme mental disorder (corresponding to a PIRS rating between 31 per cent and 100 per cent);
 Item 11 – serious mental disorder (PIRS rating between 11 per cent and 30 per cent);
 Item 12 – moderate mental disorder (PIRS rating between 4 per cent and 10 per cent);
 Item 13 – minor mental disorder (PIRS rating between 0 per cent and 3 per cent).

115 Section 62 (n) of the Civil Liability Act 2003 (Qld)

116 Civil Liability Act 1936 <https://www.legislation.sa.gov.au/LZ/C/A/CIVIL%20LIABILITY%20ACT%201936/CURRENT/1936.2267.AUTH.PDF>

- (с) Эдийн бус алдагдлын хохирлыг 2003 оны үеэр гарсан ослын улмаас үүссэн гэмтэлтэй холбогдуулан дараах байдлаар тооцно.
- (i) масштабын утга 10 ба түүнээс бага бол масштабын утгыг 1150 ам.доллараар үржүүлнэ,
 - (ii) масштабын утга нь 20 ба түүнээс бага боловч 10-аас дээш бол - масштабын хэмжээ 10-аас хэтэрсэн тоог 2300 ам.доллараар үржүүлж тооцоолсон дүн дээр 11,500 ам.доллар дээр нэмэхэд,
 - (iii) масштабын утга нь 30 ба түүнээс бага боловч 20-оос дээш бол - масштабын хэмжээ 20-оос дээш гарсан тоог 3450 ам.доллараар үржүүлж тооцоолсон дүнг 34,500 ам.доллар дээр нэмэх замаар,
 - (iv) масштабын утга нь 40 ба түүнээс бага боловч 30-аас дээш бол - масштабын хэмжээ 30-аас хэтэрсэн тоог 4600 ам.доллараар үржүүлж тооцсон дүнг 69,000 ам.доллар дээр нэмэх замаар,
 - (v) масштабын утга нь 50 ба түүнээс бага боловч 40-өөс дээш 5750 ам.доллараар үржүүлж, тооцсон дүн дээр 115,000 ам.доллар нэмнэ.
 - (vi) масштабын утга 60 ба түүнээс бага боловч 50-аас дээш бол 6900 ам.доллараар үржүүлж, тооцсон утга дээр 172,500 ам.долларыг нэмнэ.
- Дараагийн хуанлийн жилд гарсан ослын улмаас үүссэн эдийн бус хохирлын хохирлыг (в) -т заасны дагуу тооцох боловч ирсэн дүнг тохируулах (10 долларын нарийвчлалтайгаар)) өмнөх хуанлийн оны 9-р улирлын хэрэглээний үнийн индексийг 2002 оны 9-р улирлын хэрэглээний үнийн индексээр хувааж авсан пропорцоор үржүүлнэ.
- Жишээ нь:
2003 онд гарсан ослын улмаас А гэмтэж бэртсэн бөгөөд хүний биед учирсан хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжилсэн гэж үзье. Энэ тохиолдол нь эдийн бус хохирлын хохирлыг барагдуулах шалгуурыг хангаж, эдийн бус нийт хохирлыг шүүх 23 гэсэн оноогоор үнэлбэл эдийн бус хохирлын нөхөн төлбөр нь 44,850 ам.доллар болно.
 $\$34,500 + (3 * \$3450) = \$44,850$
- (3) (4) дэд хэсэгт заасны дагуу, хэрэв MVA автомашины ослын улмаас үүссэн хүний гэмтэлтэй холбоотой эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр бол дараахбайдлаар үнэлнэ.
- (а) гэмтсэн хүний эдийн бус нийт алдагдлыг 0-ээс 100 хүртэлх тоон утга; харгалзуулан (гэмтлийн тоон утга) олгох;
 - (б) гэмтлийн хуваарийн үнэлгээг үнэлэхдээ шүүх журамд заасан аливаа дүрмийг хэрэглэх ёстой;
 - (в) эдийн бус алдагдлын хохирлыг дараах байдлаар тооцно.
- (i) гэмтлийн үнэлгээг 31 ба түүнээс бага гэж үнэлсэн боловч 10-аас их гэж үзвэл (дэд хэсгийг үзнэ үү (4)) - гэмтлийн үнэлгээг 1000 ам.доллараар үржүүлж, тооцоолсон дүн дээр 2000 ам.долларыг нэмнэ (индексжүүлсэн).
- (ii) гэмтлийн үнэлгээг 45 ба түүнээс бага гэж үнэлсэн боловч үнэлгээ нь 31 ээс их байвал гэмтлийн хуваарийн утгыг 3000 ам.доллараар үржүүлж, тооцоолсон дүн дээр 2000-ыг 23,000 ам.доллар нэмнэ (индексжүүлсэн).
- (iii) гэмтлийн үнэлгээг 66 ба түүнээс бага гэж үнэлсэн боловч бол үнэлгээ нь 45 аас их байвал гэмтлийн үнэлгээг 5000 ам.доллараар үржүүлж, тооцоолсон дүн дээр 65,000 ам.доллар нэмнэ (индексжүүлсэн).
- (iv) гэмтлийн үнэлгээг 78 ба түүнээс бага гэж үнэлсэн боловч бол үнэлгээ нь 66 аас их байвал гэмтлийн үнэлгээг 10,000 ам.доллараар үржүүлж, тооцоолсон дүн дээр 170,000 ам.доллар нэмнэ (индексжүүлсэн).
- (v) гэмтлийн үнэлгээг 79 ба түүнээс дээш гэж үнэлвэл 300,000 ам.доллар (индексжүүлсэн).
- (4) MVA автомашины ослын улмаас хувийн гэмтэл авсан хүнд гэмтэлтэй холбоотой (3) (а) дэд хэсэгт хамаарах гэмтлийн хуваарийн утга нь 10-аас дээш гарсан тохиолдолд л эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг олгоно.
- (5) Гэсэн хэдий ч шүүх (4) -ийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд өөрөөр хасагдах байсан тохиолдолд эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж болно.
- а) Эдийн бус хохиролтой холбоотой хувийн гэмтлийн үр дагавар нь ижил гэмтлийн бусад хэргүүдтэй харьцуулан дүгнэхэд онцгой байх;
 - б) тухайн дэд хэсэгт заасан босгыг хэрэгжүүлэх нь тухайн тохиолдлын нөхцөлд хатуу бөгөөд шударга бус байх болно
- (6) Дэд хэсгийн (5) дагуу эдийн бус хохирлын үнэлгээг (3) (а) дэд хэсэгт хамаарах гэмтэлтэй холбоотой үнэлгээ нь ховор тохиолдолд 25% -аас их байх ёстой гэмтлийн үнэлгээнд үндэслэсэн байх ёстой.
- (7) (3) дэд хэсэгт хамаарах дүнг (дараа нь “индексжүүлсэн”) гэсэн үг) 2014 оны 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн жил бүрийн 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн тодорхойлсон дүнг үржүүлж тооцно. Тухайн оны 3-р улирлын хэрэглээний үнийн индексийг 2013 оны 3-р улирлын хэрэглээний үнийн индексээр хуваах (ийм хэмжээгээр тохируулсан дүнг 10 ам.долларын нарийвчлалтайгаар тооцсон тохиолдолд)
- (8) (7) дахь хэсэгт заасан дэд хэсгийн үйл ажиллагаатай холбогдуулан тодорхой гэмтлийн талаар хэрэглэх хэмжээ нь тухайн гэмтэл гарсан үед (3) дэд хэсэгт хэрэглэсэн хэмжээ юм.

53 дугаар бүлэг. Сэтгэцийн гэмтлийн хохирол

(1) Хохирлыг зөвхөн гэмтсэн хүн сэтгэцийн хохирол учирсан тохиолдолд л олгоно

(а) ослын улмаас бие махбодийн хувьд гэмтсэн эсвэл осол гарах үед ослын газарт байсан,

(б) ослын улмаас амь үрэгдсэн, шархадсан, аюулд өртөж болзошгүй хүний эцэг эх, эхнэр, нөхөр, гэр бүлийн хамтрагч, хүүхэд юм.

(2) Хохирол нь хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчнөөс бүрдсэн тохиолдолд л оюун санааны цэвэр хохирлыг нөхөн төлүүлж болно.

(3) Хохирол нь хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэцийн өвчнөөс бүрдсэн тохиолдолд л учирсан сэтгэцийн хохирлын улмаас үүссэн эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж болно.

- Автомашинны ослын комиссын тухай хууль 1992 (SA) ба алдааны тухай хууль 1936 (SA)

Автомашинны ослын улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийг хянах хууль ёсны заалтыг 1936 онд батлагдсан «Буруугийн тухай хууль» (SA) -д 35А хэсэгт заасан байна. Тус хуулийн дагуу эдийн засгийн бус хохирлын болох шаналал, амьдралын тохь тухыг алдах; амьдралын сайхан мэдрэмж алдагдах; амьдарлын хэв маяг өөрчлөгдөх зэрэг эдийн бус хохирлыг тус хуулийн 35А (b) (i) заалтын дагуу шүүх тухайлсан мэргэжлийн байгууллага, эмнэлгийн нотлох баримтад үндэслэн үнэлснээр 0-60 оноогоор тооцно хэмээн заасан байна. Тухайлсан оноог нийлбэр мөнгөн дүнгээр үржүүлнэ. Тус хуулийн 35А (в) хэсэгт дараахь зүйлийг заасан байдаг:

Сэтгэцийн болон мэдрэлийн цочролд дараах байдлаас бусад тохиолдолд хохирлын нөхөн олговрыг олгохгүй.

- (i) ослын улмаас бие махбодын хувьд гэмтсэн, осолд өртсөн автомашинны жолооч эсвэл зорчигч байсан, эсвэл осол гарах үед ослын газарт байсан хүн; эсвэл
- (ii) ослын улмаас амиа алдсан, гэмтсэн, аюулд өртөж болзошгүй хүний эцэг эх, эхнэр / нөхөр, хүүхэд.

- Ажилчдын ажлын байран дах осол аваараас үүдэлтэй хохирол тооцох аргачлал:

Зарим муж улсуудад ажлын байран дахь осол гэмтлийн улмаас учирсан хохирлыг "Table of Maims" буюу Маймсын хүснэгтийн дагуу гэмтлийн зэргийг тооцдог байна. Энэхүү хүснэгт нь бие махбодын болон сэтгэл санааны хохирлыг тооцох багц хүснэгт бөгөөд энэхүү гарын авлагын 21р бүлэгт сэтгэцийн гэмтлийн тухай нарийвчлан заажээ.

Энэ нь хуулиар тогтоосон холбогдох мөнгөн дүнгийг хүснэгтийн дагуу тооцсон хохирлын хувиар үржүүлэн гаргаж нэг удаагийн нөхөн олговрыг олгодог байна. Гэмтсэн ажилчдыг үнэлэх, үнэ цэнийн бууралтыг үнэлэх удирдамжийн дагуу үнэлгээний тайланг гаргаж дараах зүйлийг тодорхойлно.

- гэмтэл нь анагаах ухааны дээд түвшинд хүрсэн эсэх
- ажилчны гэмтэл нь үнэ цэнэ буурахад хүргэсэн эсэх
- үнэ цэнийн бууралт байнгын шинжтэй эсэх
- хөдөлмөрийн ослын улмаас үүссэн хүний бүхэл бүтэн үнэ цэнийн бууралтын зэрэг.

Хүний хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэг нь хөдөлмөрийн чадвараа алдсан, эмчилгээний болон үүнтэй төстэй зардлын хоёр жилийн дараа долоо хоног бүр төлбөр авах боломжтой эсэхийг тодорхойлж, эдийн засгийн болон эдийн засгийн бус хохирлын нэг удаагийн төлбөрт хамрагдах боломжийг тодорхойлоход чухал

ач холбогдолтой юм. Хөдөлмөрийн ослын улмаас үүссэн байнгын хөдөлмөрийн чадвар алдалтын түвшинг үнэлэх зорилгоор 2014 онд Ажилд буцаж ирэх тухай хуулийн 22 (3) дэд хэсэгт нийтлэгдсэн болно. Удирдамж нь хөдөлмөрийн ослын улмаас үүссэн байнгын үнэ цэнийн бууралтыг үнэлэх бодитой, шударга, тууштай аргыг бий болгох зорилготой юм. Удирдамжийг голчлон Америкийн анагаах ухааны нийгэмлэгийн гарын авлагад үндэслэсэн болно.

Сэтгэцийн эмгэгийн үнэлгээ¹¹⁷

Ангилал ¹¹⁸	1	2	4	4	5
Гэмтлийн зэргийн хувьчлал	0-5%	10-20%	25-50%	55-75%	75%-аас дээш
Тархи, сэтгэцийн үйл ажиллагаа					
Оюуны чадамж (аливаа зүйлийг ойлгох чадвар)	Хэвийнээс бага зэрэг	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүндэвтэр	Маш хүнд
Эргэцүүлэх (Өөрийн оюун бодолдоо юмыг тунгаан бодох чадвар)	Хэвийнээс бага зэрэг	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүндэвтэр	Маш хүнд
Ойлголт (гадаад болон дотоод мэдээлэлд хариу үзүүлэх тархины чадвар)	Хэвийнээс бага зэрэг	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүндэвтэр	Маш хүнд
Шүүн тунгаах (Тодорхой нэг байдалд үнэлэлт өгөх чадвар)	Хэвийнээс бага зэрэг	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүндэвтэр	Маш хүнд
Ааш зан (Сэтгэл зүйл байдал)	Хэвийнээс бага зэрэг	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүндэвтэр	Маш хүнд
Байгаа байдал (үймүүлэх, уцаартай, сэтгэл гутрах)	Хэвийнээс бага зэрэг	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүндэвтэр	Маш хүнд

Жишээ №1¹¹⁹: тус бүрийн ангилал нь 1 1 1 2 3 3, бол медиан 1.5 гэж үзвэл тоон утга нь 2 луу тоймлогдож, 2-р ангиллын үнэлгээний хувьчлалын (10-20%) дагуу сэтгэцийн эмгэгийн хувьчлал 10% тай болж тооцогдоно гэсэн үг.

Жишээ №3¹²⁰: тус бүрийн ангилал нь 2 2 2 3 3 4, бол медиан 2.5 гэж үзвэл тоон утга нь 3 луу тоймлогдож, 3-р ангиллын үнэлгээний хувьчлалын (25-30%) дагуу сэтгэцийн эмгэгийн хувьчлал 25% тай болж тооцогдоно гэсэн үг.

3.4. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Ром германы эрх зүйн системийн бүлд хамаарах улс орнуудын нэг болох ХБНГУ-ын хувьд тус улсын Иргэний хуулийн 823 дугаар зүйлд “Санаатай эсвэл болгоомжгүйгээр хүний амь насыг хохироох, амь биед нь гэмтэл учруулсан эсвэл эрүүл мэндэд нь гэмтэл учруулсан, эрх чөлөөнд нь гэм хорыг арилгах үүрэгтэй” гэж,¹²¹

117 IMPAIRMENT ASSESSMENT GUIDELINES, Return to Work scheme, IMPAIRMENT ASSESSMENT GUIDELINES Return to Work scheme

118 https://governmentgazette.sa.gov.au/sites/default/files/public/documents/gazette/2015/March/2015_015.pdf

119 Rtwsa.com. 2021. [online] Available at: <<https://www.rtwsa.com/media/documents/Impairment-assessment-guidelines.pdf>> [Accessed 6 April 2021].

120 Rtwsa.com. 2021. [online] Available at: <<https://www.rtwsa.com/media/documents/Impairment-assessment-guidelines.pdf>> [Accessed 6 April 2021].

121 “Non-Class Group LitiGation Under Eu German Law” by Harald Koch Cited: 11 Duke J. of Comp. & Int’l L.355. <http://www.Law.duke.Edu/journals/djcil/articles/>, Fao

Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөхөд “Schmerzensgeld” буюу “шаналал учруулсны хохирлын мөнгөн нөхөн төлбөр” гэсэн нэр томъёог Германы эрх зүйн номлол болон шүүхийн практикт хэрэглэдэг боловч хуульд уг томъёоллоор тусгагдаагүй байна. Германы эрх зүйд шаналал гэдгийг бие махбодын болон сэтгэл санааны өвчин шаналлыг ойлгодог байна. “Шаналал” гэдэг нэр томъёог Германы хууль зүйн зарим сурах бичгүүдэд “мэдрэмжид учирсан гэм хор” /Gefuehlschaden/ гэдгээр мөн хэрэглэдэг байна. Шаналалд төлж буй нөхөн төлбөр нь эдийн бус гэм хортой салшгүй холбоотой бөгөөд бусдын эдийн бус эрх болон баялгийг дордуулсанд төлөх төлбөр гэж үздэг байна.

ХБНГУ-ын хувьд сэтгэл санааны гэм хорыг арилгахад тусгай аргачлал боловсруулсан бөгөөд үүнийг шүүх шийдвэр гаргахдаа мөрдлөг болгодог байна. Хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг байна.

ХБНГУ-ын Иргэний хуулиар сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх асуудлыг шийдвэрлэхдээ хариуцлага ногдуулах үндэслэл болох эдийн бус баялгийг дордуулснаас шаналал үүссэн эсэх, гэм хор учруулагчийн хууль бус үйлдэл байгаа эсэх, тэдгээрийн хоорондын шалтгаант холбоо, гэм хор учруулагчийн гэм буруутай байдал зэргийг шалгадаг байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 847 дугаар зүйлд “Бие, эрүүл мэндэд гэм хор учирсан, түүнчлэн эрх чөлөөг нь зөрчсөн тохиолдолд хохирсон этгээд учирсан эд хөрөнгийн бус шинжтэй гэм хорыг зохих хэмжээний мөнгөөр нөхөн арилгуулахаар шаардах эрхтэй. Энэ эрхийг өөрийг нь айлган сүрдүүлж, хууран мэхэлж буюу хараат байдлыг нь далимдуулж гэр бүлээс гадуур эр эмийн харьцаа тогтоохоор албадсан эсхүл өөрийнх нь эсрэг ёс суртахуунд харш зөрчил хийгдсэн эмэгтэй хүн бас эдэлнэ” хэмээн эдийн бус гэм хорыг арилгуулах тухай тусгажээ.¹²²

ХБНГУ-ын Иргэний хуульд эрүүл мэнд, эрх чөлөөг зөрчсөнөөс үүссэн, эмэгтэй хүнд зарим байдлаар учирсан эдийн бус хохирол гэх мэт зөвхөн зарим эдийн бус хохирлыг арилгах, ингэхдээ тэдгээрийг мөнгөөр үнэлж арилгахаар зохицуулжээ.

Эдийн бус хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үзнэ.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Иргэний хуулийн 249 дүгээр зүйлд¹²³ заасан ашгийг тэнцвэртэй байлгах зарчмыг хэрэглэдэг байна. Өөрөөр хэлбэл хохирогч нь өөр учирсан хохирлоосоо аливаа нэгэн ашиг гаргах ёсгүй гэж үздэг байна. Нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоохдоо өмнөх онд энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээр тогтоосон хэмжээн дээр улсын эдийн засгийн болон нийгмийн байдлын өөрчлөлтийг харгалзаж үздэг байжээ. Тэгсэн хэдий ч шүүхийн олон шийдвэрүүдээр тогтоогдсон хэмжээнүүд нь мөнгөний инфляцын түвшинд баригдах боломжгүй байдал нь хүндрэл учруулсан тул энэ асуудлыг шийдвэрлэхийн тул Шнайдер, Цельнерийн аргыг боловсруулсан байна.¹²⁴ Энэ нь өмнөх шүүхийн шийдвэрээр тогтоогдсон нөхөн төлбөрийн хэмжээг дараагийн хэрэг маргааныг авч хэлэлцэх үеийн хэрэглээний индексийн өөрчлөлттэй уялдуулах арга юм.

122 Civil code of Germany.

123 German Civil Code, BGB, 2011 juris GmbH, Saarbruecken, Section 249

124 Эрделевский А.М “Компенсация морального вреда” Москва, Издательство БЕК, 2000 он, 61 дэх тал

Германы эдийн бус гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын зарим онцлогийг авч үзвэл:

- Эрүүл мэндэд гэм хор учруулсан буюу биед гэмтэл учруулсан тохиолдолд түүнчлэн эмэгтэй хүний эсрэг ёс суртахуунаас гадуур гэмт хэрэг, зөрчил хийсэн, албадан бэлгийн харьцаанд орсон гэх мэт зарим хэдэн тохиолдлуудад хохирол учирсан бол эдийн бус хохиролд тооцон хохирлыг барагдуулдаг байна.
- Эдийн бус хохирлын хэмжээг тогтоохдоо шударга ёсны үндсэнд тогтоодог бөгөөд үүнд хариуцагчийн сайн санаа, шударга ёсонд харшилсан санаа буюу гэм буруу, хохирогчид бий болсон сөрөг үр дагавар, хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг байна.

Мөн Германд гэмт хэргийн улмаас бие эрхтэндээ гэмтэл авсан этгээдэд бий болох өвчин шаналлын хохирлыг “өвчний хохирол” хэмээн нэрлэж мөнгөн хэлбэрээр барагдуулдаг байна.

ХБНГУ-ын шүүх нь сэтгэцийн гэмтлийг ХБНГУ-ын Иргэний хуулийн 823 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндэд хохирол учруулсан гэх ерөнхий байдлаар хохирлыг нөхөн төлүүлдэг байна.¹²⁵

German Civil Code BGB

Германы Иргэний хууль

§ 823. Хохирлын хариуцлага

(1) Бусдын амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө болон өөр эрхийг хууль бусаар санаатай болон хайхрамжгүй байдлаар гэмтээсэн этгээд үүнээс үүдсэн хохирлыг нөгөө талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

(2) Өөр хүнийг хамгаалах зорилготой хүнд хохирол учруулсан тохиолдолд тус этгээд ижил үүргийн хүлээнэ. Хэрэв гэм буруугүй байдлаар хохирол учруулсан болзошгүй бол нөхөн төлбөрийн хариуцлага нь зөвхөн буруутай тохиолдолд л хамаарна.

§ 826. Санамсаргүй байдал мэтээр бусдад санаатайгаар хохирол учруулсан этгээд аливаа хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Нэхэмжлэгч ХБНГУ-ын Иргэний хуулийн § 823-ийн дагуу үндэслэл бүхий нэхэмжлэл гаргахын тулд хүний амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, ашиг сонирхлын аль нэгийн зөрчсөн болохыг нотлох ёстой. Эрүүл мэндэд гэмтэл учруулах нь зөвхөн бие махбодын гэмтэл бус болон сэтгэцийн хэлбэртэй байж болно. Мэдрэлийн цочрол нь эрүүл мэндийн хувьд мэдэгдэхүйц бие махбодын болон сэтгэлзүйн хохиролд хүргэж болзошгүй тул ХБНГУ-ын Иргэний хуулийн § 823-ийн дагуу эрүүл мэндэд гэмтэл учруулсан гэх үндэслэлд багтдаг байна¹²⁶.

Жишээ 1

Сэтгэл санааны хохирлын хувьд зөвхөн стресс хангалтгүй, гэхдээ онцгой тохиолдолд сэтгэлзүйн эмгэг эрүүл мэндийн эсрэг хохиролд багтаж болно.¹²⁷ Энэхүү зарчмыг 1989 онд Bundesgerichtshof гэх дээд шүүхээс шийдвэрлэсэн давж заалдах гомдлын дагуу баталсан байна¹²⁸. Тодруулбал, нэхэмжлэгчийн 22 настай хүү нь зам тээврийн ослын улмаас амь насаа алджээ. Нэхэмжлэгч болон түүний нөхрийн

125 Teff, H. (1998). Liability for Negligently Inflicted Psychiatric Harm: Justifications and Boundaries. *The Cambridge Law Journal*, 57(1), 91-122. Retrieved March 3, 2021, from <http://www.jstor.org/stable/4508422>

126 Diaz, J.A., 2010. Non Physical Damage: a Comparative Perspective.

127 Diaz, J.A., 2010. Non Physical Damage: a Comparative Perspective.

128 Teff, H. (1998). Liability for Negligently Inflicted Psychiatric Harm: Justifications and Boundaries. *The Cambridge Law Journal*, 57(1), 91-122. Retrieved March 3, 2021, from <http://www.jstor.org/stable/4508422>

сэтгэл санааны тааламжгүй байдлаас болж оршуулах ёслолын маргааш эхлэх ёстой байсан амралтыг цуцалжээ. Хариуцагчийн эсрэг хохирол нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд урьд нь амрахаар төлөвлөж байсан амралтын зардлыг нэхэмжлэл багтаасан байна. Гэвч давж заалдах шатны шүүхэд тус хохирлыг нөхөн төлүүлэхээс татгалзаж, хэдийгээр уй гашуу, сэтгэлзүйн дарамтад өртсөн нь эргэлзээгүй боловч илэрч буй шинж тэмдгүүд нь илт эмгэггүй байсан тул ХБНГУ-ын Иргэний хуулийн 823 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндэд гэмтэл учруулсан эсэхэд үндэслэлийг хангахгүй хэмээн татгалзсан болно.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 823 дахь заалт нь маш өргөн хүрээг хамардаг. Тухайлбал, “other rights” буюу өөр эрхүүд гэдэгт нь хүний нэр хүндэд халдах эрх мөн хамаарна. Хүний нэр хүндэд халдсанаар учирсан хохирлыг тооцох тухай шүүхийн шийдвэр нь Schacht-ийн кейс юм¹²⁹.

Schacht case-¹³⁰

Нэхэмжлэгч нь Гитлерийн үед Эдийн засгийн сайдаар ажиллаж байсан доктор Шахтын өмгөөлөгч байв. Шүүгдэгч нь Доктор Шахтын банк байгуулахыг эсэргүүцсэн нийтлэлийг нийтэлсэн долоо хоног тутмын сэтгүүл буюу хуулийн этгээд байсан юм.

Өмгөөлөгч нь Доктор Шахтын өмгөөлөгчийн хувьд хариуцагч руу тус нийтлэлд тодорхой залруулга хийхийг шаардсан захидал илгээхийг даалгаж шаардлага хүргүүлсэн. Гэвч Шүүгдэгч уг захидлын зарим хэсгийг орхигдуулж, үлдсэн хэсгийг нь «Редакторуудад ирүүлсэн захидлууд» гэсэн гарчигтайгаар нийтэлж, улмаар өмгөөлөгч нь хувийн шинж чанартай ажиллаж, доктор Шахтыг дэмжиж, үйлчлэгчийн үзэл бодлоос илүүтэй өөрийн, хувийн үзэл бодлоо илэрхийлсэн гэж ойлгогдох байдлаар буруу сэтгэгдэл төрүүлэхээр нийтлэл гаргасан байна.

Шүүх тус хэргийг хянан үзээд, нийтлэлийг засах ёстой гэж үзсэн байна. Учир нь Холбооны Дээд Шүүхээс гаргасан үндэслэл нь хариуцагч нь нэхэмжлэгчийн хувийн ерөнхий эрхийг зөрчиж, уг захидлыг ийм байдлаар нийтэлж, хуурамч зургийг танилцуулсан байна.

ХБНГУ-ын Иргэний хуулийн §823-т заасны дагуу “бусад эрх”-ийг зөрчсөн буюу “хүний нэр төрд халдах, хувийн нууцад халдсан үед хохирлыг нөхөн төлүүлэх хууль зүйн үндэслэл юм гэдгийн шүүх тайлбарласан байна. §823-т «хувь хүний ерөнхий эрх» -ийг «бусад эрх» -ийн нэг болохыг хүлээн зөвшөөрсөн нь тус хуулийн хамгийн чухал шинэчлэлт, өөрчлөлт гэж судлаачид үздэг байна.

Хүний амь насны эсрэг гэмт хэрэгт хохирол барагдуулах нь

§ 704 (1) ‘Хэрэв хүн санаатай болон хайхрамжгүй байдлаар хууль бус үйлдэл хийсэн бол ... бусдад хор хохирол учруулсан бол ... тухайн хүн учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.’

Хүний амь насанд хохирол учруулсан тохиолдолд амь үрэгдсэн хүнд нөхөн олговор олгох эрхгүй, харин зөвхөн өөрөөс нь хамааралтай байсан гуравдагч этгээдэд л ХБНГУ-ын Иргэний хуулийн 704-т заасны дагуу олгодог байна.¹³¹

ХБНГУ-д хүний амь нас хохирсны нөхөн төлбөрийг хууль заасан тодорхой хамаатан саднаар нь хязгаарладаг байна. Өөрөөр хэлбэл садан төрлийн хэн дуртай нь сэтгэл санааны хохирлын нэхэмжлэлийг гаргадаггүй бөгөөд зөвхөн шалтгаант холбоотой эсэхийг нотолсны дараа хохирлыг барагдуулах үгүйг шийддэг байна.

129 Werner Ebke and Mathew Finkin, Introduction to German Law. (1996) 201.

130 Werner Ebke and Mathew Finkin, Introduction to German Law. (1996) 201.

131 Werner Ebke and Mathew Finkin, Introduction to German Law. (1996) 201.

ХБНГУ-ын Иргэний тухай хуулийн §844-т зааснаар талийгаачийн хуулиар хүлээсэн үүрэг бүхий хүмүүст нөхөн төлбөр авах эрхтэй гэж заасан байдаг.

§ 844 Хүний амь нас хохирсон тохиолдолд гуравдагч этгээдийн нөхөн олговрын нэхэмжлэл.

(1) Үхлийн шалтгаан болсон тохиолдолд хохирол учруулсан этгээд оршуулгын зардлыг эдгээр зардлыг хариуцах үүрэгтэй хүнд нөхөн төлөх ёстой.

(2) Хэрэв амь насаа алдсан хүн гэмтэл бэртэл авах үедээ тухайн этгээдэд асрамжийн үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн, эсхүл үүрэг хүлээх боломжтой байж болзошгүй гэсэн үндэслэлээр гуравдагч этгээдтэй харилцаатай байсан бол гуравдагч этгээд Үхлийн үр дүнд тэжээн тэтгэх эрхээ хасуулсан бол хохирол учирсан этгээд аллагад өртсөн хүн тэтгэвэр тогтоолох үүрэгтэй байсан хэмжээгээр гуравдагч этгээдэд нөхөн төлбөр төлөх ёстой. Түүний амьдралын тухай;

Эдийн бус хохирлыг ХБНГУ-ын Иргэний хууль (BGB) -ийн §253-т заасны дагуу нөхөн төлж болох бүх хохирлын иж бүрэн нөхөн олговор болох “Schmerzensgeld” гэж нэрлэдэг зохицуулалтаар тодорхойлдог¹³². Тус хохирлыг ХБНГУ-ын Иргэний хууль (BGB) -ийн §253-т .

§253-р хэсэг Биет бус хохирол

(1) Зөвхөн хуульд заасан тохиолдолд мөнгөн хохирол учруулаагүй хохирлыг нөхөн төлүүлэхээр мөнгө шаардаж болно.

(2) Хэрэв бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, бэлгийн харьцааг өөрөө тогтоосон гэмтлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах шаардлагатай бол мөнгөн хохирол учруулаагүй хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлтэй мөнгө шаардаж болно.

ХБНГУ-д нэхэмжлэлийн хохирлын шаардлагыг үнэлэх, тодорхойлоход тухайлсан хуулиар тогтоосон хүснэгт, тооцох аргачлал байхгүй тул харин өмнөх шүүхийн прецедент болон журмуудаар тодорхойлдог байна¹³³. Тиймээс шүүх хохирогчийн гэмтлийн хүндийн байдал, хохирогчийн нас, зовлон шаналал, эрч хүч, нийт хохирлын хэмжээнд нөлөөлж болох бусад бүх нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой. Хамгийн ноцтой кейсд олгосон сэтгэлийн өвдөлт, шаналал нь 500,000 еврогоос 600,000 еврогийн хооронд хэлбэлздэг бөгөөд үүнийг тогтмол олгох нэг жилийн үнэлгээ хэлбэрээр олгох боломжтой. Шүүгчид энэхүү үнэлгээг хийхэд хувийн хэвшлийн байгууллагуудаас баталж гаргасан хэргийн тухай нийтэлж гаргасан лавлагаа, эмхэтгэлээр хохирлын үнэлгээг хийхэд ашигладаг.¹³⁴ Гэвч тэдгээр нь заавал мөрдөгдөх хууль ёсны хүчин чадалгүй.

ХБНГУ-ын хууль тогтоомж нь гэмт хэрэг, ослын тухай мэдээг хүлээн авахтай холбоотойтойгоор садан төрлийн хүмүүс сэтгэцийн өвчнөөр өвчилсөн тохиолдолд нөхөн төлбөрийг олгоно гэсэн үзлийг баримталдаг. Садан төрлийн хүмүүсээс эдийн бус хохирлыг нэхэмжлэхэд зөвхөн тодорхой нэг онцгой тохиолдолд олгодог байна. Тухайлбал, хэргийн газар байлцсан садан төрлийн хүмүүс сэтгэл санааны шоконд орж, хэргийн дараах сэтгэл санааны “хэвийн” шаналлын түвшинг давсан тохиолдолд сэтгэцийн стрессийн синдромыг үүсгэсэн хэмээн нөхөн төлбөр авдаг байна.¹³⁵ Тухайлбал, Рейхсгерихт 1931 оны 9-р сарын 21-ний өдөр гаргасан шүүхийн шийдвэртээ долоон настай хүүгээ зам тээврийн ослоор нас барсан тухай мэдээг хүлээн авч мэдрэлийн өвчтэй болсон ээжийн хувьд шүүх нь хүүхдээ гэнэтийн ослоор алдах нь ямар ч эх хүнийг сэтгэл санааны хүнд дарамтад оруулах нь тодорхой гэж шүүх тогтоов. Улмаар сэтгэцийн өвчнийг хоёр тохиолдолд нөхөн олговор олгоно гэсэн байна. Үүнд:

132 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

133 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

134 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

135 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

Нэгдүгээрт, шалтгаант холбоо хангалттай тохиолдолд,

Хоёрдугаарт, мөн энэ төрлийн гэмтэл авах нь урьдчилан тооцоолж чадах эсэх нь тодорхой байвал нөхөн олговрыг олгохоор заасан байна.

ХБНГУ төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанаас учирсан гэм хорын хохирлыг төр хариуцан арилгах тухай үзэл санааг Үндсэн хуулийн түвшинд хуульчилсныг суурь болгон Иргэний хуулиараа зохицуулдаг байна. Тухайлбал,

ХБНГУ-ын хувьд Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлд "... төрийн албан хаагч нь өөрт итгэмжлэн хүлээлгэсэн ажил үүргийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн бол үүнтэй холбоотой учирсан хохирлыг төр хариуцан арилгана" гэж заан "төр"-ийн хариуцлагын үзэл баримтлалыг Үндсэн хуулийн түвшинд хүлээн зөвшөөрснийг ХБНГУ-ын Иргэний хуулийн 839 дүгээр зүйлээр тодотгон, төрийн албан хаагчийн хохирлыг арилгах үүргийг төрд шилжүүлсэн байдаг. Германы эрх зүйд хувийн болон нийтийн эрх зүйн хоорондын ялгаа хатуу тогтсон байдаг учраас хувийн эрх зүйн харилцаа болон төрийн чиг үүргийн харилцааг нарийн гаргадаг.

Германы эрх зүй дэх уг зохицуулалтын нэг чухал онцлог бол гэм хорын хохирогч нь хохирлоо барагдуулах өөр бусад эх үүсвэргүй /даатгал, нийгмийн хангамж зэрэг/ байх явдал байдаг. Өөрөөр хэлбэл, хуулийн дээрх заалтын дагуу нөхөн төлбөр төлөх үүрэг үүсэх нэг үндэслэл нь уг гэм хорыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй байх явдал билээ.¹³⁶

3.5. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

БНФУ 1970 онд Иргэний хуульдаа эдийн хөрөнгийн бус амины эрхийг хамгаалах асуудлыг зохицуулсан хуулийн заалтыг 9 дүгээр зүйлдээ тусган оруулсан байдаг.

Гэм хорыг Иргэний хуульдаа нийтлэг асуудлын хувьд эдийн болон эдийн бус гэж ялгадаггүй боловч БНФУ-ын иргэний эрх зүйн ном зохиолуудад болон шүүхийн практиктаа ялгаж үздэг ба эд хөрөнгийн бус амины эрхийг зөрчсөн гэм хорыг сэтгэл санааны гэм хор /*dommage moral*/¹³⁷ гэж нэрлэдэг байна. Сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн үндэслэл нь гэм хор учруулагчийн гэм буруугийн байдлаас шалтгаалдаг байна. Болгоомжгүйгээр гэм хор учруулсан үндэслэлд дараах 3 зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

1. Гэм хор учруулагч нь хохирогчтой харилцахдаа зохих болгоомж анхаарлыг тавьж харилцах үүрэгтэй эсэх,
2. Энэ үүргийг гэм хор учруулагч зөрчсөн эсэх,
3. Энэ зөрчлийн үр дүнд хохирогчид тухайн гэм хор учирсан эсэх орно.

Сэтгэл санааны гэм хорын нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох асуудал нь нэлээд маргааныг дагуулж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хохирогч бүрийн сэтгэл санаанд учирсан гэм хор нь түүний өөрийнх нь сэтгэл зүйн болон сэтгэцийн байдлаас нь хамаарч янз бүр байдагтай холбоотой байна. Үүнийг 1923 онд Лузитаниатай холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх хуралдаанаас тайлбарлахдаа сэтгэл санааны гэм хорыг "хэмжих эсхүл мөнгөн хэлбэрийн стандартаар тооцоолоход хүндрэлтэй" хэдий боловч тэдгээр нь "маш бодитой" болон нөхөн төлөгдөх ёстой гэдгийг хэзээ ч шийдвэрлэхгүй үлдээж болохгүй гэсэн байна.¹³⁸

136 F.F.Blachly & M.E.Oatman, *Approaches to Governmental Liability in Tort: A Comparative Survey*, 9 *Law and Contemporary Problems* 181-213 (Spring 1942).

137 Эрделевский А.М "Компенсация морального вреда" Москва, Издательство БЕК, 2000, 68 дахь тал

138 Patrick Dumberry. *Compensation for Moral Damages in Investor-State Arbitration Disputes*. *Journal of International Arbitration*. 2010, 247 дахь тал.

БНФУ-ын Иргэний хуулиар сэтгэл санааны гэм хорын асуудлыг бусад гэм хороос ялгаж авч үздэггүй тул нийтлэг зохицуулалтыг хэрэглэдэг байна. Иймд эдийн бус баялгийг дордуулсан сэтгэл санааны гэм хор учирсан эсэх, хууль бус гэм буруутай үйлдэл байгаа эсэхийг шалгана. Шүүх сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх асуудлыг шийдвэрлэхдээ өмнө нь гаргаж байсан шүүхийн шийдвэрээр тогтоосон хэмжээг харгалзаж үздэг байна.

БНФУ-д гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх зохицуулалтыг зөвлөмж хэлбэрээр боловсруулсан байдаг. Хүний амь нас, эрүүл мэндэд учруулсан хор уршигтай холбоотой сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тодорхойлдог хэд хэдэн баримт бичиг байдаг:

1. 2003 оны Эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай;
2. 2005 оны Эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нэр томьёоны тухай;
3. 2016 оны Бие махбодод учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмжийн лавлагаа.

2005 оны Эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нэр томьёоны тухай тайлан нь норматив хэм хэмжээ биш боловч шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ашигладаг. Нэр томьёоны тухай тайлан нь хохирогчид учирсан хохирол болон нөхөн төлүүлэх хохирлын жагсаалтыг тодорхойлсон.

Тус тайланд олгох ёстой нөхөн төлбөрийн хэмжээг заагаагүй бөгөөд зөвхөн хохирогчид учирсан хохирлын улмаас гарч болзошгүй үр дагаврын тухай тайлбарласан байдаг.

2016 онд Бие махбодод учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмжийг (арга зүйн зөвлөмж) боловсруулсан. Энэхүү зөвлөмжийг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс бүрдсэн тусгайлан байгуулсан ажлын хэсэг давж заалдах шатны шүүхийн практикт үндэслэн боловсруулсан. 2016 оны арга зүйн зөвлөмжийг 2005 оны хохирлыг нөхөн төлүүлэх ангиллыг үндэслэн, давж заалдах шатны шүүх дундаж нөхөн төлбөр төлсөн хэмжээгээр тогтоосон болно.

Хохирлын хэмжээг үнэлэхдээ дараах нөхцөл байдлыг харгалзан үзнэ:¹³⁹

- Хохирол шууд хохирогчид эсхүл шууд бус байдлаар бусад этгээдэд учирсан,
- Хохирлын шинж чанар: эдийн болон сэтгэл санааны (эдийн бус),
- Түр зуурын эсвэл байнгын хохирол.

Хохирогч гэж эрүүл мэндэд нь хохирол учирсны улмаас сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх этгээд. Хохирогч нас барсан зарим тохиолдолд хохирогчийн өв залгамжлагчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргаж болдог. Харин амьд үлдсэн тохиолдолд шууд бус байдлаар хохирогчийн ойр дотнын хүмүүст сэтгэл санааны хохирол үүсэж болох бөгөөд хохирлыг нөхөн төлүүлж болно. Францын давж заалдах шатны шүүхийн 1970 оны 2-р сарын 27-ны өдөр гаргасан шийдвэрийн дагуу хохирогчийн ойр дотнын хүнд учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг авахын тулд хохирогчтой холбоотой хувийн, шууд, тодорхой, хуулийн дагуу хохирол учирсан болохыг нотлох шаардлагатай гэж тодорхойлсон.¹⁴⁰

139 Бие махбодын гэмтэл бэртэл, нөхөн төлбөр олгох 2013 оны тайлан, <https://www.vie-publique.fr/sites/default/files/rapport/pdf/034000490.pdf>, Сүүлд үзсэн: 2021.01.28

140 Cass. ch. mixte, 27 février 1970, JCP 1970.II. 16305

Сэтгэл санааны зарим төрлийн хохирлын нөхөн төлбөрийг авахын тулд давж заалдах шатны шүүх хохирогчтой хамтран амьдарсан байх шаардлагыг тавьдаг.¹⁴¹

1). Хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр.

1. Түр зуурын шинж чанартай сэтгэл санааны хохирол.

1.1. Хохирогчийн өдөр тутмын амьдралд түр зуурын шинжтэй хязгаарлалт тогтоосонтой холбоотой сэтгэл санааны хохирол (dificit fonctionnel temporaire).

Нөхөн төлбөр олгох хугацааг хохирогчийн амьдрал хэвийн болох хүртэл хугацааг тооцож олгодог. 2016 онд гаргасан зөвлөмжид заасны дагуу сард 600-900 евро олгохоор тооцсон. Тус хэмжээг хэвийн амьдралаар амьдрах чадвараа алдсан хугацаатайтай дүйцүүлж тооцно. Францын давж заалдах шатны шүүх өдөр тутмын амьдралд түр зуурын шинжтэй хязгаарлалт тогтоосонтой холбоотой сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхэд хохирогчийн дотно харилцааны амьдралтай холбоотой сэтгэл санааны хохирол (préjudice sexuel), хохирогчийн чөлөөт цагийг түр зуурын шинжтэй хязгаарлахтай холбогдон үүсэх сэтгэл санааны хохирол (préjudice d'agrément temporaire)-ыг хамтатган тооцно.¹⁴²

1.2. Эрүүл мэнд сэргээгдэх хүртэл бий болох зовлон, шаналлаас болж үүсэх сэтгэл санааны хохирол (souffrances endurées, pretium doloris).

Эрүүл мэндийн байдал сэргээгдсэний дараа хохирогч өөрийн өдөр тутмын амьдралыг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй байдаг тул тус хугацааны сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг олгодог. Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлоход бүхий л нөхцөл байдлыг харгалзан үздэг. Тухайлбал, гэмтэл хэрхэн авсан, эмнэлэгт хэвтсэн эсхүл мэс засал хийлгэсэн эсэх, хохирогчийн нас гэх мэт. Шүүх шинжилгээний үнэлгээг харгалзан тус нөхөн төлбөрийн хэмжээг тогтоодог¹⁴³

1/7	Маш хөнгөхөн	2 000 евро хүртэл
2/7	хөнгөхөн	2 000 – 4 000 евро
3/7	дунд зэрэг	4 000 – 8 000 евро
4/7	дундаж	8 000 – 20 000 евро
5/7	хангалттай хүчтэй	20 000 – 35 000 евро
6/7	хүчтэй	35 000 – 50 000 евро
7/7	маш хүчтэй	50 000 – 80 000 евро
Онцгой тохиолдол		80 000 евро болон түүнээс дээш

* Зовлон шаналлын дараагийн түвшин бүр өмнөх түвшингээс хоёр дахин их байна. Жишээлбэл, 5-т үнэлэгдсэн хүний зовлон нь 4-тэй харьцуулахад хоёр дахин хүнд байх болно.

1.3. Хохирогчийн гадаад төрхөд түр зуурын шинжтэй гэмтлээс болж үүсэх сэтгэл санааны хохирол (rejudice esthétique temporaire).

141 Civ. 2, 21 novembre 2013, n° 12- 28.168

142 Civ. 2, 5 mars 2015, n° 14-10.758

143 Давж заалдах шатны шүүхийн “Бие махбодид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмж 2016”, 53 дахь тал, <https://clementcousin.files.wordpress.com/2017/03/referentiel-indicatif-de-l-indemnisation-du-prejudice-corporel.pdf>, Сүүлд үзсэн: 2021.01.28.

Хохирогч өөрийн гадаад дүр, төрхөд үүссэн түр зуурын шинжтэй гэмтлээс сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр шаардаж болох бөгөөд гэмтэлтэй хэсгийн зургийг авна нотлох баримт болгон баримтжуулна. Тус гэмтлийн хохирлын нөхөн төлбөрийг зовж шаналсны нөхөн төлбөрт оруулан тооцох боломжгүй гэж иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоосон.

2. Байнгын шинжтэй сэтгэл санааны хохирол.

2.1. Хохирогчийн өдөр тутмын амьдралд байнгын шинжтэй хязгаарлалт тогтоосонтой холбоотой сэтгэл санааны хохирол (dificit fonctionnel permanent).

Хохирогчийн өдөр тутмын амьдралд байнгын шинжтэй хязгаарлалт тогтоосонтой холбоотой сэтгэл санааны хохирол буюу эрүүл мэндэд учирсан хохирлоос болж хохирогч урьдын амьдралын хэв маягийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд үүсэх сэтгэл санааны хохирол.

Давж заалдах шатны шүүхийн “Бие махбодод учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмж 2016”-д тусгасан нөхөн төлбөрийн хэмжээг доорх хүснэгтээр харуулав. Хохирогчийн насыг хэвтээ, хэвийн амьдрах чадвар алдалтыг босоо шугамд байрлуулсан бөгөөд нөхөн төлбөр олгох мөнгөн дэвсгэрт евро байна.¹⁴⁴

2013	0-10 жил	11-20 жил	21-30 жил	31-40 жил	41-50 жил	51-60 жил	61-70 жил	71-80 жил	81 дээш жил
1-5%	2.100	1.950	1.780	1.610	1.440	1.270	1.100	950	800
6-10%	2.425	2.250	2.205	1.850	1.640	1.420	1.200	1.025	850
11-15%	2.750	2.550	2.320	2.090	1.840	1.570	1.300	1.100	900
16-20%	3.075	2.850	2.590	2.330	2.040	1.720	1.400	1.175	950
21-25%	3.400	3.150	2.860	2.570	2.240	1.870	1.500	1.250	1.000
26-30%	3.725	3.450	3.130	2.810	2.440	2.020	1.600	1.325	1.050
31-35%	4.050	3.750	3.400	3.050	2.640	2.170	1.700	1.400	1.100
36-40%	4.375	4.050	3.670	3.290	2.840	2.320	1.800	1.475	1.150
41-45%	4.700	4.350	3.940	3.530	3.040	2.470	1.900	1.550	1.200
46-50%	5.025	4.650	4.210	3.770	3.240	2.620	2.000	1.625	1.250
51-55%	5.350	4.950	4.480	4.010	3.440	2.770	2.100	1.700	1.300
56-60%	5.675	5.250	4.750	4.250	3.640	2.920	2.200	1.775	1.350
61-65%	6.000	5.550	5.020	4.490	3.840	3.070	2.300	1.850	1.400
66-70%	6.325	5.850	5.290	4.730	4.040	3.220	2.400	1.925	1.450
71-75%	6.650	6.150	5.560	4.970	4.240	3.370	2.500	2.000	1.500
76-80%	6.795	6.450	5.830	5.210	4.440	3.520	2.600	2.075	1.550
81-85%	7.300	6.750	6.100	5.450	4.640	3.670	2.700	2.150	1.600
86-90%	7.625	7.050	6.370	5.690	4.840	3.820	2.800	2.225	1.650
91-95%	7.950	7.350	6.640	5.930	5.040	3.970	2.900	2.300	1.700
96% дээш	8.200	7.650	6.910	6.170	5.240	4.120	3.000	2.375	1.750

Шүүхийн практикт үндэслэн сэтгэл санааны хохиролд олгосон нөхөн төлбөрийн дундаж хэмжээгээр тогтоосон.

Жишээ. 25 настай эрэгтэй хүн гэмтсэн бөгөөд үүний үр дүнд хэвийн амьдрах чадвараа 32% алдсан. Нөхөн төлбөрийн хэмжээ: 3,400 евро * 32 = 108,800 евро.

144 Давж заалдах шатны шүүхийн “Бие махбодод учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмжийн лавлагаа 2016”, 55 дахь тал,
<https://clementcousin.files.wordpress.com/2017/03/referentiel-indicatif-de-l-indemnisation-du-prejudice-corporel.pdf>, Сүүлд үзсэн: 2021.01.28.

Хэрэв хохирогч 35 настай хэвийн амьдрах чадвараа 22% алдсан гэж үзвэл, нөхөн төлбөрийн хэмжээ $22 * 2\,570 = 56,540$ евро байна.

2.2. Хохирогчийн гадаад төрхөд гэмтэл учруулснаас болж үүсэх сэтгэл санааны хохирол (préjudice esthétique permanent).

Шүүхийн практикаас харахад энэ төрлийн сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ зовж шаналсны нөхөн төлбөрийн хэмжээтэй ижил байна (souffrances endurées, 1.2-р хүснэгтийг үзнэ үү). Нөхөн төлбөрийн хэмжээг хохирогчийн хүйс, нас, түүний хувийн болон гэр бүлийн байдал, хохирогчийн биед гэмтэл учруулсан газар болон бусад нөхцөл байдлыг харгалзан тогтоогддог. Хэдий гаднах төрх байдалд учруулсан гэмтэл нь хохирогчийн хувьд субъектив байдлаар ойлгогддог боловч шүүх үүнийг объектив байдлаас үнэлж нөхөн төлбөрийн хэмжээг тогтоодог.¹⁴⁵

2.3. Хохирогчийн чөлөөт цагийг хязгаарлахтай холбогдон үүсэх сэтгэл санааны хохирол (préjudiced'agrément).

Сэтгэл санааны хохирлоос болж хохирогч урьдын адил чөлөөт цагаа өнгөрөөх боломжгүй болсон. Тухайлбал, бие тамир, спортоор бүрд, соёлын арга хэмжээнд оролцох.¹⁴⁶ Хохирогч үүнийгээ спортын лиценз, гишүүнчлэл, гэрчилгээ зэрэг баримтаар нотолж шүүх эмнэлгийн шинжээчид мэдэгдэнэ. Шүүх эмнэлгийн шинжээч тухайн этгээдийг цаашид тус үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой эсэх эсхүл ямар нэгэн хязгаарлалт байгаа эсэхийг тогтооно. Францын хохирогчдод туслах нийгэмлэгийн (AIVF) мэдээлснээр нөхөн олговрын хэмжээ 1,000-3,000 еврогийн хооронд хэлбэлзэж болох бөгөөд зарим тохиолдолд 50,000 евро байж болно.¹⁴⁷ Шүүх тус сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээний талаар ямар нэгэн зөвлөмж боловсруулаагүй тул төлбөрийн хэмжээг тус бүрд нь тогтоодог.

2.4. Дотно харьцааны амьдралтай холбоотой сэтгэл санааны хохирол (préjudice sexuel).

Тус сэтгэл санааны хохиролд дараах гурван зүйлийг анхааран авч үзэх шаардлагатай. Үүнд: 1. Бэлэг эрхтний гэмтэл, 2. Бэлгийн харилцаанд орж чадахгүй байх (бэлгийн дур хүсэл буурах, бие махбодын хувьд бэлгийн харилцаанд орох чадвараа алдах), 3. Нөхөн үржихүйн эрхтэнд гэмтэл учрах.¹⁴⁸ Энэ төрлийн сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох жагсаалт байхгүй бөгөөд үүнийг тодорхой тохиолдол бүрд шүүх тогтоодог. Тухайлбал, Лионы давж заалдах шатны шүүх хохирогчид (гэмтэл гарсан нас - 56 нас, нөхөн сэргээх нас - 59) 3,000 еврогийн нөхөн төлбөр олгох шийдвэр гаргасан.¹⁴⁹ Дээр дурдсан гурван гэмтлийг харгалзан үзэн эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах боломжгүй бол сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр 50 000 – 80 000 евро хүрч болно. Парисын давж заалдах шатны шүүхийн 2014 оны 2-р сарын 6-ны өдрийн шийдвэрээр хохирогчийн (гэмтлийн нас 21 байсан, нөхөн сэргээх нас 23) эрүүл мэндийн байдал (бэлгийн

145 Civ. 2, 22 février 1995, Bull. civ. II, n° 61 ; comparer : Civ. 2, 22 novembre 2012, n° 11-21.031, Тус шүүхийн шийдвэрээр шүүх комд орсон хохирогчид гадаад төрхөд гэмтэл учруулснаас болж үүсэх сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр олгохоор тогтоосон.

146 Civ. 1, 8 février 2017, n° 15- 21.528.

147 <https://association-aide-victimes-france.fr/accueil-association-daide-a-lindemnisation-victimes/differentes-postesprejudice-corporel/prejudice-corporel-victime-directe/prejudice-agrement2>

148 Civ. 2, 17 juin 2010, n° 09-15.842).

149 C.A. Lyon, 18 sept. 2014, n° 13-04832.

харьцаа) нөхөн сэргээгдэх боломжгүй байсан тул 60 000 еврогийн нөхөн төлбөрийг олгосон.¹⁵⁰ Хохирогчийн эхнэр, нөхөр эсхүл хамтрагчид сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр гэж 15,000 евро олгодог.

2.5. Амьдрал хэвийн үргэлжлэхтэй холбогдон үүсэх сэтгэл санааны хохирол (préjudice d'établissement).

Эрүүл мэндийн байдлаас болж хохирогч амьдрал зохиох, хүүхэдтэй болох, хэвийн амьдрал зохиох итгэл найдваргүй болох зэрэг хувийн амьдралтай холбоотой шинж чанарыг агуулж байдаг тул гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг бүрэн барагдуулах боломжгүй байдаг. Иймд, хэргийн нөхцөл байдлаас хамаарч сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг олгохоор зохицуулсан. Тухайлбал, давж заалдах шатны шүүхийн 2017 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн шүүхийн шийдвэрээр хэрэв хохирогч сэтгэл санааны хохирлоос болж хүүхэдтэй болж чадахгүйгээс болж хүүхэд өргөж авсан тохиолдолд гэр бүлтэй болох сэтгэл санааны хохирол үүсээгүй гэж тооцно. Хэдий хүүхэдтэй болж чадахгүй байгаа нь сэтгэл санааны хохиролтой шууд холбоотой ч гэсэн хохирогчид хүүхэд үрчлэхтэй холбогдон гарах эд хөрөнгийн хохирлыг барагдуулахаар тогтоосон.¹⁵¹

3. Амьдрахад заналхийлж буй эмгэгийг бий болгосноос үүссэн сэтгэл санааны хохирол (préjudices extrapatrimoniaux involutifs (hors consolidation)).

Нөхөн төлбөр нь ерөнхий шинж чанартай бөгөөд хохирогчийн өдөр тутмын амьдрал дахь хязгаарлалттай холбоотой сэтгэл санаа хохирлыг эс тооцвол хүний оюун санааны бусад бүх зовлонгийн нөхөн төлбөрийг багтаасан байдаг (difficult fonctionnel permanent).¹⁵² Хохирогч эмчлэгдэж байгаа нь түүнд нөхөн төлбөрийг зогсоох үндэслэл болохгүй, учир нь эмчилгээний явцад тухайн хүн өвчний хүнд байдал, амь насанд нь эрсдэл учирч болзошгүй байдалтай холбоотойгоор зовлон, шаналлыг мэдэрч байгаа нь нөхөн төлбөр өгөх үндэслэл болно.¹⁵³ Нөхөн төлбөр олгох нь хувийн шинжтэй бөгөөд тохиолдол тус бүрд янз бүр тогтоогддог.

2). Хохирогчтой холбоотой этгээдэд учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр.

1. Хохирогчийн хамаатан саданд үүссэн зовлон, шаналалтай холбоотой сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр (préjudice d'affection).

Хохирогчийн хамаатан садан болон ойр дотын хүмүүс, мөн түүнтэй сэтгэл зүйн хувьд ойр байсан хүмүүст хэрэв хохирогч нас барсан тохиолдолд учруулсан сэтгэл санааны хохирол болгон нөхөн төлбөр төлүүлдэг. Нөхөн төлбөрийг талийгаачийн эцэг эх, эмээ өвөө, үр хүүхэд, хань ижил, хамтрагч нарт олгох бөгөөд бусад ойр дотно байсан этгээд нөхөн төлбөр авахын тулд үүнийгээ шүүхэд нотлох шаардлагатай. 2016 оны зөвлөмжид заасны дагуу нөхөн төлбөрийн хэмжээ дараах байдалтай байна.¹⁵⁴

150 C.A. Paris, 6 fév. 2014, n°11-03506.

151 Civ. 2, 8 juin 2017, n° 16-19.185.

152 Civ. 2, 18 mars 2010, n° 08-16.169.

153 Civ. 2, 4 juillet 2013, n°12-23.915.

154 Давж заалдах шатны шүүхийн “Бие махбодид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмжийн лавлагаа 2016”, 70 дахь тал, <https://clementcousin.files.wordpress.com/2017/03/referentiel-indicatif-de-l-indemnisation-du-prejudice-corporel.pdf>, Сүүлд үзсэн: 2021.01.28.

Эрх бүхий хүмүүс	Хохирогч (нас барсан)	Нөхөн төлбөрийн хэмжээ
Эцэг/эх	хүүхэд	20 000 - 30 000 евро
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг хүүхэд	Эцэг/эх	25 000 - 30 000 евро
Өнчирсэн насанд хүрээгүй хүүхэд		Дээрх хэмжээ 40 - 60%-иар өссөн
насанд хүрсэн Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг хүүхэд		15 000 - 25 000 евро
насанд хүрсэн Эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхэд		11 000- 15 000 евро
эхнэр, нөхөр/ хамтрагч	эхнэр, нөхөр эсхүл хамтрагч	20 000 - 30 000 евро (хамтран амьдарсан хугацаанаас шалтгаална)
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг ах/ эгч нар	ах/ эгч нар	9 000 - 14 000 евро
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй ах/ эгч нар	ах/ эгч нар	6 000 - 9 000 евро
Ач, зээ нартайгаа тогтмол харьцдаг эмээ, өвөө нар	Ач, зээ нар	11 000 - 14 000 евро
Ач, зээ нартайгаа тогтмол харьцдаггүй эмээ, өвөө нар	Ач, зээ нар	7 000 - 10 000 евро
Өвөө, эмээтэйгээ тогтмол харьцдаг ач, зээ нар	Өвөө, эмээ	6 000 - 10 000 евро
Өвөө, эмээтэйгээ тогтмол харьцдаггүй ач, зээ нар	Өвөө, эмээ	3 000 - 7 000 евро
Хохирогчтой тогтмол холбоотой байдаг бусад хамаатан садан, ойр дотны хүн		3 000 евро хэтрэхгүй


Хэрэв хохирогч амьд үлдсэн бол хохирогчийн хамаатан саданд учирсан сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх боломжтой. Нөхөн төлбөрийн хэмжээ хохирогчийн нөхцөл байдлаас хамаардаг бөгөөд онцгой тохиолдолд хохирогч нас барсан тохиолдолд төлөх байсан нөхөн төлбөрийн хэмжээнээс хэтэрч болдог. Түүнчлэн хохирогчийн өвчнөөс болж хамаатан садных нь амьдралын чанар муудаж байгаатай холбоотой сэтгэл санааны хохирлыг нөхөн төлнө (жишээлбэл, хохирогчийн эхнэр, нөхөр эсвэл хамтрагчийн дотно амьдралтай холбоотой сэтгэл санааны хохирол). Нөхөн төлбөр олгох нь хувийн шинжтэй бөгөөд тохиолдол тус бүрд янз бүр тогтоогддог.

2. Хохирогчийг нас барах хүртэл өвчтэй байх хугацаанд хамаатан саданд үүссэн зовлонгийн нөхөн төлбөр (préjudice d'accompagnement).

Хохирогч нас барахаасаа өмнө хүнд нөхцөл байдалтай байсантай холбогдуулан хохирогчийн ойр орчмын хүмүүсийн амьдрах нөхцөл дордсонтой холбогдуулан хохирлыг нөхөн төлдөг. Нөхөн төлбөр авахын тулд нөхөн төлбөр авах гэж байгаа болон хохирогчийн хоорондын харилцааг тогтоосон нотлох баримт. Нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь хувийн шинж чанарыг агуулж байдаг учир тохиолдол бүрд шүүх тогтоодог.

Европын орнуудын гэмт хэргийн улмаас учирсан хохирол тооцох харьцуулсан судалгаа

Graph 1 – 41-year-old male, employee with annual net income of EUR 40,000; survivors: spouse, two children (6 and 9 years of age), 1 parent, 1 brother




Жишээ 1¹⁵⁵

Дээрх хэргийн тохиолдол болох 41 настай эрийн үхлийн хэрэгт хэрхэн эдийн болон эдийн бус хохирлыг Европын орнууд ялгамжтайгаар барагдуулсныг харж болно. Энэхүү хэрэгт талийгаач жилийн 40.000 Еврогийн орлоготой байгааг харуулсан бөгөөд эхнэр, 6 болон 9 настай хүүхдүүдийн хамт, 1 эцэг эх, 1 төрсөн ах гэр бүлээс нь үлдсэн байна. Энэхүү тохиолдолд анализ хийвэл Итали улс нийт хохирлын нөхөн төлөлтийн тооцооллын хэмжээгээрээ их боловч, харин Испани улс хамгийн бага хохирлын нөхөн төлөлтийг төлсөн байна.

Эдийн бус хохирлын хувьд тухайн тохиолдолд хамгийн дээд хэмжээг Англи улс барагдуулсан бол Испани улс нь хамгийн доод нөхөн олголтыг олгосныг тус графикаас харьцуулан харж болно.

Graph 2 – 17-year-old male, pupil/ apprentice; survivors: parents and 14-year-old sister



155 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

Жишээ 2 ¹⁵⁶

Харин дараах тохиолдол 17 настай сурагч хүүгийн амь насны хохирлын хэмжээг хэрхэн барагдуулсныг харж болно. Тус хохирогч хүүгийн ард эцэг эх, болон 14 настай охин дүү нь үлдсэн байна. Хүний амь нас хохирсон тохиолдолд Итали, Испани, Францад эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг тусгайлан гаргасан хүснэгтийн тусламжтайгаар тодорхойлдог байна.

Тус хэргийн нөхөн олговрын дүнгээс харьцуулан дүгнэвэл Итали улс нь бусад Европын орнуудаас хамгийн өндөр эдийн бус хохирол болон нийт дүнгээрээ хамгийн өндөр тооцооллоор хохирлыг барагдуулсан байна. Тэрч утгаараа Итали улс нь бусад Европын орнуудаас ихээхэн онцлогтой байгаа учир тус улсын гэмтлийн улмаас учирсан хохирлын тооцооллыг судлан үзэх нь зүйтэй. Итали улс нь бүс нутгийн шүүхүүд, ялангуяа Милан мужийн шүүхээс бэлтгэсэн хүснэгтэд үндэслэн өвдөлт, зовлонг хэмждэг байна. Тус тооцох аргачлалын хүснэгтийг заавал даган мөрдөх албагүйч шийдвэр гүйцэтгэх үед тэдгээрийг харгалзан үздэг байна. Тиймээс энэхүү Итали улсын хохирол тооцох аргачлалыг дэлгэрэнгүй авч үзье.

3.6. БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС

БНИУ-ын Миланы шүүхээс гаргасан хүснэгтүүд (Tribunale di Milano) нь (The Court of Milan Tables) хүний биед гэмтэл учруулсан хохирлыг нөхөн төлөх хамгийн чухал хууль зүйн нөхцөлийг бүрдүүлдэг байна. Милан хотын шүүхийн хүснэгтүүдийг 1993 онд хамгийн анх даатгалын компаниуд, ослын хохирогчдын төлөөлөгчид, магистрант, шүүх эмнэлгийн эмч, хуульчдаар бүрдсэн Миланы Шүүхийн Мониторингийн төвөөс анх боловсруулсан байна. Төвөөс хөдөлмөрийн чадвараа алдах ганц цэгийн утгыг байнгын хөгжлийн бэрхшээлийн хүндийн зэргийг харгалзан прогрессив хүчин зүйлээр, гэмтсэн хүний насыг харгалзан регрессийн хүчин зүйлээр тодорхойлох нь зүйтэй гэж санал болгосон байна.

Хөгжлийн бэрхшээлийн эхний үнэлгээний утгыг Миланы шүүхээс өмнө шийдвэрлэсэн прецедентэд суурилан тодорхойлох санал гаргасан байна. 1995 онд хэвлэгдсэн анхны хэвлэлд 13 насны бүлгийг тодорхойлсон бөгөөд хөгжлийн бэрхшээлийн үнэлгээний утгыг залуугаасаа ахмад нас хүртэл хохирлын үнэлгээг 60 хувиар бууруулахаар тооцоог гаргажээ. Өөрөөр хэлбэл, багадаа гэмтэл авсан хүний хохирлын тооцоо нь өндөр настай хүний хохирлын тооцооноос хэд дахин илүү байхаар тооцоолсон байна.

2009 оны хохирол тооцох аргачлалд орсон өөрчлөлт:

2009 онд хамгийн сүүлийн үеийн практик болон хууль тогтоомжийн боловсруулалтыг харгалзан тус тооцооллыг бүрэн шинэчилсэн. 2009 оны шинэ хүснэгтүүд нь өнөөдрийг хүртэл ашиглагдаж байгаа бөгөөд энэ нь стандарт гэмтлийн дундаж мөнгөн дүнгийн жагсаалтаас бүрдэнэ. Одоогийн хүснэгтүүд нь нас бүрт өөр өөр утгатай байгаа хэдий ч үндсэн ойлголт нь өнөөдрийг хүртэл хэвээр байна.

2009 оны шинэ хүснэгтэд орсон өөрчлөлт бол Сан Мартиногийн шийдвэрээс¹⁵⁷ үүдэлтэй бөгөөд Кассацийн шүүх нөхөн олговрын хэмжээг эдийн болон эдийн бус хохирол гэж 2 ангилалд хуваасан байна. Тус хэрэгт үндэслэн Миланы хяналтын төвийн шүүх 2009 оны 6-р сард эдийн бус хохирол гэсэн ойлголтыг нэвтрүүлсэн шинэ хүснэгтүүдийг гаргасан. Эдийн бус хохиролд зөвхөн биологийн, ёс суртахууны болон оршихуйн хохирол зэрэг нөхөн төлбөрийн төрлийг хамруулсан болно.

156 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

157 2008 оны 26972/3/4/5 тоот

Court of Milan – Settlement of non-economic damages – 2009 tables (amounts in euro)

Disability	Biological point 2008 adapted to 2009 CPI	Amount	Non-economic dam age point 2009	Compensation: age groups 1-5						Personalized amount
				1	2	3	4	5	...	
				Reduction						
				1,000	0,995	0,990	0,985	0,980	...	
1	1.068,67	25%	1.335,84	1.336,00	1.329,00	1.322,00	1.316,00	1.309,00		+ max 50%
2	1.135,46	25%	1.419,33	2.839,00	2.824,00	2.810,00	2.796,00	2.782,00		+ max 50%
3	1.202,25	25%	1.502,82	4.508,00	4.486,00	4.463,00	4.441,00	4.418,00		+ max 50%
4	1.269,04	25%	1.586,30	6.345,00	6.313,00	6.282,00	6.250,00	6.218,00		+ max 50%
5	1.335,84	25%	1.669,79	8.349,00	8.307,00	8.265,00	8.224,00	8.182,00		+ max 50%
...										
30	3.840,53	46%	5.607,17	168.215,00	167.374,00	166.533,00	165.692,00	164.851,00		+ max 29%
31	3.932,70	47%	5.781,07	179.213,00	178.317,00	177.421,00	176.525,00	175.629,00		+ max 28%
32	4.024,20	48%	5.955,82	190.586,00	189.633,00	188.680,00	187.728,00	186.775,00		+ max 27%
33	4.116,38	49%	6.133,40	202.402,00	201.390,00	200.378,00	199.366,00	198.354,00		+ max 26%
34	4.207,88	50%	6.311,82	214.602,00	213.529,00	212.456,00	211.383,00	210.310,00		+ max 25%
...										

The complete 2018 edition of the Court of Milan tables, is available at
<https://www.tribunale.milano.it/files/news/TABELLE%20MILANO%20EDIZIONE%202018.pdf>

“Биологийн хохирол” нь бие махбод, сэтгэл санаа, нийгмийн хохиролтой холбоотой. Биологийн хохирлын талаарх хамгийн сүүлийн үеийн тодорхойлолтыг Даатгалын тухай хуулийн 138, 139-р зүйлд тусгасан бөгөөд энэ ангиллын хохирлыг “Хүний эрүүл мэнд, сэтгэлзүйн бүрэн бүтэн байдлыг бууруулж, түр болон байнгын гэмтэл учруулах. хүний орлого олох чадвар.” Биологийн хохирлыг хөдөлмөрийн чадвар түр алдалт, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах гэсэн хоёр дэд ангилалд хуваадаг. “Түр зуурын тахир дутуу болох” -ыг ослоос нөхөн сэргээхэд шаардагдах нийт хоногийн тоог тооцоолох замаар хохирлоо олж авдаг.¹⁵⁸

Бие махбодын нөхөн сэргээх байгалийн чадавх, хохирогчийн анхны сэтгэцийн байдлыг сэргээхэд шаардлагатай эмчилгээ зэргийг харгалзан үздэг бөгөөд үүнийг хоногоор хэмждэг. Хэрэв гэмтсэн хүн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй бол хөдөлмөрийн чадвар түр алдсаныг нэгтгэн тооцно. Гэмтсэн гэмтэл нь хохирогчид зөвхөн зарим төрлийн үйл ажиллагаа эрхлэхээс урьдчилан сэргийлэх тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны хугацааг хязгаарлагдмалд тооцно.

“Тахир дутуугийн хөгжлийн бэрхшээл” гэдэг нь эмчлэх боломжгүй нөхцөлөөр сэтгэцийн болон бие махбодын эрүүл мэндийн байдал буурч байгааг илэрхийлж, үүнийг хувиар илэрхийлнэ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хүний биед учирсан гэмтлийн үнэлгээг анагаахын шинжлэх ухааны шүүх шинжээч хийх ёстой. Үүний эсрэгээр биологийн хохирлын

158 <https://www.tribunale.milano.it/files/news/TABELLE9620MILANO9620EDIZIONE96202018.pdf>

үнэлгээг хуульд заасан урьдчилан тогтоосон шалгуур болох дээрх хүснэгтийг ашиглан шүүхээр шийдвэрлүүлдэг байна.

Хамгийн түгээмэл хэрэглэгддэг шалгуур бол Миланы шүүхээс өгсөн шалгуур бөгөөд тус шалгуур нь “Хувьсах индекс” -т үндэслэсэн бөгөөд энэ нь хөдөлмөрийн чадвар алдалтын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгө юм.

Мөнгөний нийлбэр нь хөгжлийн бэрхшээлийн хувиар нэмэгддэг, гэхдээ энэ нь гэмтсэн хүний наснаас хамаарч буурдаг.

“Ёс суртахууны хохирол” гэдэг нь хүний ерөнхий сайн сайхан байдалд үзүүлэх ёс суртахууны хор хөнөөл, сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн зовиур, гомдлоос бүрдэнэ. Тиймээс ёс суртахууны хохирлын квантын үнэлгээ нь биологийн хор хөнөөлийн хувьтай холбоотойгоор - 20% хүртэл байна.¹⁵⁹ Энэ нь 2005 оны 9-р сарын 7-ны өдрийн (Даатгалын тухай хуулийн 139-р зүйлд нийцсэн болно. 209 нөхөн олговрын нийлбэрийг нэмэгдүүлэх хүчийг өгдөг.

Дүгнэж хэлэхэд, ослын улмаас учирсан хохирлыг тооцох янз бүрийн арга замууд, олон хүчин зүйлийг харгалзан үзэх нь хамгийн чухал бөгөөд үүнд хамгийн чухал нь гэр бүл ба гэр бүлийн бус хохирлыг хооронд нь ялгах явдал юм.

Тахир дутуугийн тодорхой түвшинд хүргэсэн бэртлийн харьцангуй хүндийн дагуу эдгээр хохирлын хэмжээг тогтоосон болно. Тиймээс бага зэргийн гэмтэл авсан тохиолдолд хөдөлмөрийн чадвараа алдсаны 1-9% хүртэлх хэмжээг тогтоон, «ёс суртахууны хохирол»-ын 25%-ийг «биологийн хохирол» дээр нэмэгдүүлж нийт 26%-иас 50% хүртэл хувиар тооцдог бол хүнд хэлбэрийн гэмтэлд хөдөлмөрийн чадвар алдалтын 10%-иас 34% хүртэл тооцож, маш хүнд зэргийн хөгжлийн бэрхшээлд тогтмол 50%-ийн өсөлтийн нөхөн олговроор тооцдог байна (насан туршийн хөгжлийн бэрхшээл нь 35%-иас 100% хүртэл үнэлэгддэг).

Дээрх удирдамжийг Кассацийн шүүх гаргасан бөгөөд энэхүү хүснэгт нь хувь хүнд нь тохирсон уян хатан байдлаар тогтоохоор шинэчилсэн. Нөхөн олговрын хэмжээг дундаж утгын хувиар өсгөх замаар өөрчлөх боломжтой. Жишээ нь төгөлдөр хуурчийн хуруунд гэмтэл учруулсан тохиолдолд хувь хүний онцлог байдлаас шалтгаалан нэмэгдэл нь бага зэргийн гэмтэл авсан тохиолдолд (хөдөлмөрийн чадвараа алдсаны 9% хүртэл) 50% хүртэлх хувиар тооцуулж болох байна. Дараа нь байнгын тахир дутуугийн 10%-аас 34% хүртэл гэмтэл авсан тохиолдолд 49%-иас 25% хүртэл хувиар хувь хүний нөхцөл байдлын тохиргоог оруулж, 100% хүртэлх үнэлгээтэй гэмтэлд хувийн тохиргоонд 25%-ийн тогтмол нэмэгдлийг олгохоор тооцсон байна. (Хүнд гэмтлийн тохиолдлуудад «ёс суртахууны хохиролд 50%-ийг нэмэгдэл олгодог болсон.

Даатгалын зах зээлийн хувьд дор хаяж 2009 оны хүснэгтүүдийн эцсийн бөгөөд нэлээд чухал шинэлэг зүйл бол хүний амь насыг хохироосон гэмтлийн нөхөн төлбөрийн хэмжээ юм. Ач зээ нас барсны төлөө үр шимийг хүртэгчдийн ангилалд өвөө эмээ нэмж оруулахын зэрэгцээ хамгийн бага ба дээд хэмжээг 40 орчим хувиар өсгөсөн. Жишээлбэл, 2008 оны хүснэгтэд хүүхдийн нас барсны төлөө эцэг эхэд төлөх нөхөн олговрын дундаж утга 159,564 евро байсан бол 2009 оны хүснэгтэд мөн адил дундаж хэмжээ 225,000 еврод хүрсэн байна.

Энэхүү хүснэгт нь зарим тохиолдолд хохирлын нөхөн төлөлт нь хоорондоо маш их давхацдаг гэсэн шүүмжлэл агуулж байсан хэдий ч Миланы хүснэгтүүд шаардлагатай хэрэгсэл хэвээр байна.

159 <http://www.tribunale.Milano.It/fales/news/TABELLE9620MILANO9620EDIZIONE96202018.pdf>

2018 онд хохирол тооцох аргачлалд орсон өөрчлөлт:

Милан хотын шүүхийн 2018 оны хүснэгтүүд дөрвөн үндсэн чиглэлд нөхөн олговор олгохоор тооцоолол гаргасан бөгөөд (1) гэмт хэргийн улмаас цаг бусаар нас барсны нөхөн төлбөр, (2) «danno terminale»; (3) хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төрд халдсан хохирол, (4) болгоомжгүй шүүх ажиллагаанаас үүдсэн хохирол хэмээн тус тус ангилан тооцооллыг гаргасан байна.

Disability	Non-economic damages – first year	Non-economic damages – first and second year	Non-economic damages for each additional year	Personalized amount
1	64	111	32	50%
2	135	236	68	50%
3	214	375	107	50%
...				
77	39176	68558	19588	50%
78	39815	69676	19907	50%
...				

Excerpt from Court of Milan Tables, p. 42

1) Хохирлын тооцоолол нь “үндэсний үзүүлэлт” -ийн түвшинтэй адилхан байх ёстой тул Италийн Үндэсний Статистикийн Хүрээлэнгээс мэдээлсэн хэрэглээний үнийн индекс өссөний үр дүнд үнэлгээний утгад хийсэн цорын ганц өөрчлөлт нь (1.2%) байв. Мөн өөр нэг өөрчлөлт нь хэрэв хэргийн улмаас хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсан хэдий ч хэсэг хугацааны дараа өөр шалтгааны улмаас амиа алдвал хохирлыг амьдрах боломжтой байсан наслалт хүртэлх илүүтэйгээр төлөх бус тухайн хэргийн улмаас үүссэн хохиролд нь яг тааруулж тооцуулах шаардлагатай хэмээн үзсэн. Тиймээс шинэ хүснэгтийн дагуу ийм тохиолдолд стандартчилагдсан нөхөн олговрын хэмжээг бууруулахаар тусгасан болно. Хэрэв гэмтсэн хүний нас, наслалт харилцан адилгүй байгаа тул ижил гэмтэлд хүснэгтийн утга харилцан адилгүй байвал биологийн хохирлыг барагдуулахаас өмнө хохирогч нас барвал магадлалын үнэлгээ гэмтсэн хүний наслалттай холбоотой бодит хохирлыг солих ёстой.

Энэхүү логик дээр үндэслэн Милан хотын шүүх энэ сэдэвт хандах хандлагыг стандартчилах зорилгоор 2018 оны хэвлэлд тооцоолох аргыг боловсруулсан бөгөөд эхлэл нь жилийн дундаж нөхөн олговрыг хувьтай харьцуулж харуулсан утгуудын жагсаалт юм. Наснаас үл хамааран байнгын хөгжлийн бэрхшээлтэй болох. Эдгээр тохиолдлуудын хувьд хөдөлмөрийн чадвараа алдсаны хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, эхний жилд нөхөн олговор, хоёр дахь жилд нөхөн олговор, нэмэлт жил бүрт нөхөн олговор олгох, мөн хувь хүний хувийн нөхцөлөөс хамааран боломжит хувиар нэмэгдүүлэх хүснэгтийг боловсруулсан болно.

Danno Terminale¹⁶⁰ хүснэгт

“Danno terminale” including temporary biological component

Days	Overall amount	
Up to 3	Up to 30,000	
Additional days	Amount per day	
4	1,000,00	28
5	991,00	29
6	981,00	30
7	972,00	31
8	962,00	32
9	953,00	33
10	944,00	34

Increase in personalized amount (maximum injury) only for the days after the first 3 days

Excerpt from Milan Court Tables, p. 48

Дээрх хүснэгтээс харах “Danno terminale” гэдэг хохирол тооцох хүснэгт нь гэмт хэргийн улмаас хохирогчийн хохирол учирч, улмаар нас барсан үеэс эхлэн хохирогчийн зовлон шаналлын нөхөн төлбөр хэлбэрээр олгодог хохирлын төрөл юм. Энэхүү хүснэгт нь ихэвчлэн ижил төстэй үзэгдлийг тодорхойлоход хэрэглэгддэг нэр томъёог кодчилох оролдлого байв. Тиймээс биологийн эцсийн хохирлыг бүхэлд нь хамарсан ангилалд багтсан хүмүүст биологийн бүх хохирол, түүнчлэн удахгүй үхэх тухай ойлголттой холбоотой аливаа зовлонг (үүнд биологийн эцсийн гэмтэл, ухамсрын шаналал, ёс суртахууны эцсийн хохирол орно) нөхөн төлнө гэж заасан.

Нөхөн олговрын энэ тал дээр нэгдсэн, стандартчилагдсан хандлагыг санал болгохдоо Милан хотын шүүх хяналтын төв зарим маркеруудыг зааж эхлэв. Энэ нь хохирогчийн амьдралын төгсгөлийн талаарх мэдлэг нь эцсийн эцэст учирсан хохирлыг нөхөн төлөх зайлшгүй урьдчилсан нөхцөл бөгөөд жишээлбэл, хохирогч нас барах хүртлээ ухамсаргүй байх үед ийм нөхцөл байдал үүссэн гэж хэлж болохгүй гэж тодорхой заажээ. Нөхөн төлбөр нь гэмтэл бэртэл, нас баралтын хооронд тодорхой хугацааны дараа автоматаар хийгддэггүй болохыг Хяналтын төвөөс онцоллоо. Энэ нь 100 хоногийг хязгаар гэж тогтоосон бөгөөд энэ нь хохирогч удахгүй үхлийг ухамсартайгаар боловсруулж, эргэцүүлэн бодож зовж, 100 хоногийн дотор нас барна гэсэн үг юм. Энэ хугацааны дараа биологийн түр зуурын хохирол гэх мэт нөхөн төлбөрт хамрагдах бусад зүйл хамаарна.

Эдгээр бодлыг харгалзан Милан хотын Хяналтын төвийн шүүх лавлагаа хүснэгтийг санал болгож байна. Эдгээр шүүхийн үр дүнгээс үзэхэд хохирогч гэмтсэнээс хойш эхний гурван хоногт ухамсартайгаар эсэн мэнд амьдрах гэж нэрлэж болох байдалд байгаа тохиолдолд нөхөн олговрын дээд хязгаар нь 30,000 евро байна. Нэмэлт өдрүүдийн хувьд 100 дахь өдөр биологийн түр зуурын хохирлын тодорхой утгад хүрэх хүртэл буурах өдөр тутмын утгын сүлжээ байна. Дөрөв дэх өдрөөс 100 дахь өдөр хүртэл үнэ цэнэ нь 1,000 еврогоос 98 евро хүртэл буурч

160 Lorenzo Vismara, Gen Re, Milan, 2018, The Court of Milan Tables – Bodily Injury Compensation in Italy, <https://media.genre.com/documents/cfpc1807-en.pdf>.

байгаа нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны өдөр тутмын хэмжээтэй тохирч байна. Энэ тохиолдолд эхний гурван өдрийг эс тооцвол тухайн хүний нөхцөл байдлаас шалтгаалан өдөр тутмын үнэ цэнийг дүнгийн 50% -ийн хязгаарт багтаан өөрчлөх боломжтой бөгөөд энэ нь шүүгчдэд үе үе нөхөн олговрыг тодорхой нөхцөлд тохируулан өөрчлөх боломжийг олгодог байна. Бидний тооцооллоор 2018 оны Миланийн хүснэгтэд энэхүү тодорхой хохирлын зүйлд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу төлөх ёстой нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь боломжит хувийн тохируулсан нийлбэрийг оруулаад ойролцоогоор 110,000 еврод хүрнэ.¹⁶¹

БНИУ-ын хохирол барагдуулах тухай хууль тогтоомж

Зам тээврийн осол болон эрүүл мэндийн салбарын хариуцлага алдсаны улмаас гэмтэл авсан үед эдийн бус хохирлыг нэхэмжлэхэд хохирлыг тооцох тухай аргачлалыг багтаасан Итали Улсын Хувийн даатгалын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд тус хуульд зааснаар¹⁶²

Хувийн даатгалын тухай хууль

(Хууль тогтоомжийн 2005 оны 9-р сарын 7-ны өдрийн 209 тоот тогтоол).

138-р зүйл - (Хүнд гэмтлийн улмаас учирсан санхүүгийн бус хохирол)

1. Ослын хохирогчид учирсан санхүүгийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, даатгалын систем, хэрэглэгчийн зардлыг оновчтой болгох зорилгоор Бүгд Найрамдах Итали Улсын нутаг дэвсгэр даяар хүчинтэй тодорхой нэг хүснэгтийг Ерөнхийлөгчийн зарлигаар боловсруулж, сайдын саналыг үндэслэн Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор энэхүү заалтыг хүчин төгөлдөр болсноос хойш нэг зуун хорин хоногийн дотор батална. Эдийн засгийн хөгжлийн тухай, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд, Хууль зүйн сайдтай тохиролцсоны үндсэн дээр мөн үүнд дараах зүйлийг зааж өгнө.

- a. Арваас нэг зуун онооны хоорондох бие бялдрын болон оюун санааны бүрэн бүтэн байдал алдагдах;
- b. Хөдөлмөрийн чадвар алдалтын цэг бүрийн мөнгөний үнэ цэнэ, үүнд хохирогчийн нас харгалзах өөрчлөлтийн коэффициент орно.

2. Улсын дээд хүснэгтүүдийн тогтоосон хэргийн тухай хуулийн дагуу санхүүгийн бус гэмтлийг үнэлэх шалгуурыг харгалзан үндэсний нэг хүснэгтийг гаргана.

Дараах зарчим, шалгуурын дагуу,

- a. Хүснэгтэд заасан биологийн хохирол нь хүний эрүүл мэнд, сэтгэцийн бүрэн бүтэн байдалд гэмтэл учруулж болзошгүй эм, эрх зүйн үнэлгээгээр тогтоогдох, өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа болон динамикт сөргөөр нөлөөлөх аливаа гэмтлийг хэлнэ. Мөн орлого олох чадавхид нь ямар нэгэн хариу үйлдэл үзүүлэхээс үл хамааран хохирогчийн амьдралын харилцааны талууд,
- b. Эдийн засгийн үнэ цэнийн хүснэгтийг хөгжлийн бэрхшээлийн нас, зэргээс хамаарч онооны системд үндэслэнэ,
- c. Цэгийн эдийн засгийн үнэ цэнэ нь хөгжлийн бэрхшээлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх функц байх бөгөөд хохирогчийн амьдралын динамик болон хүмүүсийн хоорондын харилцааны доройтлын тохиолдол нь үр дагаврын

161 Lorenzo Vismara, Gen Re, Milan, 2018, The Court of Milan Tables – Bodily Injury Compensation in Italy, <https://media.genre.com/documents/cfpc1807-en.pdf>.

162 Article 139 of the Italian Insurance Code, https://www.ivass.it/normativa/nazionale/primaria/CAP_EN.pdf?language_id=3.

өсөлттэй харьцуулахад пропорциональ байдлаас илүү нэмэгдэх болно,

- d. d) Цэгийн эдийн засгийн үнэ цэнэ нь тогтоосон хүүгийн хэмжээтэй тэнцэх дахин үнэлгээний хувь хэмжээгээр ISTAT-ийн гаргасан нас баралтын хүснэгтийн дагуу тухайн хүний нас буурах функц байх ёстой,
- e. д) Бие махбодын бүрэн бүтэн байдалд гэмтэл учруулсны улмаас үүссэн материаллаг бус хохирлын бүрэлдэхүүн хэсгийг авч үзэхдээ биологийн гэмтэлд харгалзах хувь хэмжээг шалгуурын дагуу тогтооно,
- f. e) Биологийн түр зуурын хохирлыг 100 хувиас бага байвал хөдөлмөрийн чадваргүй байдлын өдөр тутамд хүлээн зөвшөөрсөн хувиар тооцно.

3. Хэрэв зарласан үнэ цэнийн бууралт нь баримтжуулж, бодитойгоор баталгаажуулсан тодорхой динамик болон хүн хоорондын харилцаанд чухал нөлөө үзүүлсэн бол 2-р хэсэгт дурдсан үндэсний нэг хүснэгтийн дагуу тооцсон хохирлын хэмжээг шүүх гучин хувь хүртэл нэмэгдүүлж болно. Хохирогчийн субъектив нөхцөлийг шударга, үндэслэлтэй үнэлсний үндсэн дээр.

4. Энэ зүйлд заасны дагуу олгосон нийт хохирлын хэмжээ нь бие махбодод гэмтэл учруулснаас үүссэн хохирлыг багтаасан болно.

5. Үндэсний нэг хүснэгтэд харуулсан дүнг ЭШХ-ын сайдын тушаалаар жил бүр ISTAT-ийн үнэлгээ хийсэн бичиг хэрэг, гар ажилчдын гэр бүлийн хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлтийн дагуу шинэчлэн батална.

139-р зүйл - (Бага зэргийн гэмтлийн улмаас учирсан санхүүгийн бус хохирол)

1. Автотээврийн хэрэгсэл, гар урлалын улмаас гарсан ослоос үүдсэн хөнгөн гэмтлийн биологийн хохирлын нөхөн төлбөрийг дараах шалгуур, хэмжилтийн дагуу тооцно.

- a. биологийн байнгын хохирлын хувьд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүртэй харьцуулахад пропорциональ хэмжээнээс их хэмжээгээр нэмэгдүүлсэн нөхөн төлбөрийг 9 хувиас доош буюу түүнээс доош хувьтай тэнцэх үнэ цэнийн бууралтын үр дагаварт төлнө; энэ хэмжээг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт 6-р хэсэгт заасан хамаарлын дагуу холбогдох коэффициентийг ашиглан тооцно. Ийнхүү тооцоолсон хэмжээ нь хүний нас нэмэгдэх тусам жил бүр 0.5 хувиар буурч байна. арван нэгэн наснаас. Эхний цэгийн утга нь 795.91 евро;
- b. түр зуурын биологийн хохирлын хувьд хөдөлмөрийн чадваргүй болсон хоног тутамд 39.37 еврогийн нөхөн төлбөр олгоно; хөдөлмөрийн чадвараа түр алдалт 100% -иас бага тохиолдолд нөхөн төлбөрийг хөдөлмөрийн чадвараа өдөр бүр хүлээн зөвшөөрсөн хувиар тооцно.

2. 1 дэх хэсэгт заасан зорилгоор биологийн гэмтэл гэдэг нь хүний эрүүл мэнд, сэтгэцийн бүрэн бүтэн байдалд гэмтэл учруулж болзошгүй эм, эрх зүйн үнэлгээгээр тогтоогдох, өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх аливаа гэмтэл тэдгээрийг хэлнэ. Хохирол учруулсан тал нь түүний орлогыг бий болгох чадавхад ямар нэгэн хариу үйлдэл үзүүлэхээс үл хамааран түүний амьдралын динамик болон харилцааны талууд.

Энэ нь тийм ч хөнгөн гэмтэл биш юм объектив багажийн эмнэлзүйн тандалтад ертөмтгий, эсвэл нүдний хараагаар баталгаажуулж чадахгүй, сорви гэх мэт гэмтлийн хувьд ямар нэгэн багаж хэрэглэлгүйгээр объективаар тогтоогдох боломжтой тул биологийн байнгын хохирлыг нөхөн төлүүлж чадахгүй.

3. Хэрэв зарласан үнэ цэнийн бууралт нь баримтжуулсан, бодитойгоор тогтоогдсон, эсвэл бие махбодын болон сэтгэл санааны маш хүчтэй зовлон учруулсан, эсвэл динамик, хувь хүмүүсийн хоорондын тодорхой талуудад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн бол үндэсний нэг хүснэгтийн дагуу тооцсон хохирлын хэмжээг шүүхээр нэмэгдүүлж болно. Хохирогчийн субъектив нөхцөлийг шударга, үндэслэлтэй үнэлсний үндсэн дээр 20 хувь хүртэл. Энэ зүйлд заасны дагуу олгосон нийт хохирлын хэмжээ нь бие махбодод гэмтэл учруулснаас үүссэн санхүүгийн бус хохирлыг багтаасан болно.

4. Ерөнхийлөгчийн зарлигаар Эрүүл мэндийн сайдын саналыг үндэслэн Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн бодлогын сайд, Хууль зүйн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайдтай тохиролцон тодорхой хүснэгтийг хөгжлийн бэрхшээлийн 1-9 цэгийн хоорондох бие бялдар, оюун санааны бүрэн бүтэн байдлыг алдагдуулж тооцно.

5. 1-р зүйлд үзүүлсэн дүнг жил бүр Эдийн засгийн хөгжлийн сайдын 602 дугаар тушаалаар шинэчлэн, ISTAT-ийн үнэлгээ хийсэн бичиг хэрэг, гар ажилчдын гэр бүлийн хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлттэй уялдуулан шинэчилнэ.

6. 1-р хэсгийн а) хэсгийн дагуу тооцох зорилгоор хөдөлмөрийн чадвар алдалтын 1 нэгжид үржүүлэх коэффициент 1, тахир дутуугийн 2 нэгжид 1.1-ийн үржүүлэх коэффициент, 1.2-т үржүүлэх коэффициент хамаарна. тахир дутуугийн 3 нэгж хувь хүртэл, хөдөлмөрийн чадвар алдалтын 4 нэгжид 1.3-ыг үржүүлэх коэффициент, 5 хувь тахир дутамд 1.5-ийн үржүүлгийн коэффициент, 6 нэгжид 1.7-ийн үржлийн коэффициент, а үржлийн коэффициент 1.9 бол хөдөлмөрийн чадвар алдалтын 7 пункт, 2.1-ийн үржлийн коэффициент 8 хувь, тахир дутуугийн 9 нэгжид 2.3-ийн үржүүлгийн коэффициент хамаарна.

3.7. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

БНХАУ-ын хувьд эдийн бус гэм хорыг тооцох аргачлалгүй ч тухайн хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүхээс тогтоодог аж.

БНХАУ-д шүүхэд хэрэглэгддэг шүүхийн оюун санаа болон сэтгэцийн доголдол үнэлэхдээ American Medical Association- Америкийн эмнэл зүйн нийгэмлэгээс гаргасан олон улсад хэрэглэгддэг оюун санаа болон сэтгэцийн доголдол үнэлэх зааварчилгаа AMA Guides¹⁶³ гэдэг албан ёсны нэршилтэй хохирол тооцох 3 түвшний үнэлгээний аргачлалыг ашигладаг байна. Энэ нь:

I. Үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ.

Үүнд сэтгэл санаа, нийтийн болон ажил мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээг сэтгэц судлалын эрүүл мэндийн талаас үнэлнэ. Гадны нөлөөт болон бие физиологийн гэмтэл хамаарахгүй.

100-91 Бүх төрлийн үйл ажиллагаанд өндөр түвшинд оролцоно. Шинж тэмдэг байхгүй.

90-81 Шинж тэмдэг байхгүй эсвэл маш бага (Жишээ нь: шалгалтын өмнөх бага зэргийн сэтгэл зовнил зэрэг), амьдралын идэвхтэй, ерөнхийдөө амьдралд сэтгэл хангалуун, өдөр тутмын хэвийн асуудлаас өөр зүйл байхгүй.

- 80-71 Хэрвээ шинж тэмдэг илэрвэл энэ нь түр зуурынх ба байж болох асуудлын хариу урвалд үүссэн (гэр бүлийн маргааны дараа төвлөрч чадахгүй байх) нийтийн, ажил мэргэжлийн болон сургуулийн орчинд бага зэргийн хоцрогдолтой байх
- 70-61 Хөнгөн шинж тэмдгүүд илрэх (сэтгэл санаагаар унах, хөнгөн зэргийн нойргүйдэлт зэрэг) эсвэл нийтийн, ажил мэргэжлийн болон сургуулийн орчинд бага зэрэг асуудалтай (гэр дотроос хулгай хийх, хааяа хүмүүстэй маргалдах зэрэг), гэхдээ ерөнхийдөө амьдрах чадвартай, өөрт нь чухал хүмүүстэй харилцан холбоотой
- 60-51 Дунд зэргийн шинж тэмдгүүд (сэтгэл хөөрөл байхгүй, яриандаа төөрөгдөх, хааяа багтарч сандрах) эсвэл нийтийн, ажил мэргэжлийн болон сургуулийн орчинд асуудалтай (цөөн найз нөхөд, ажлын хүмүүстэй маргаантай зэрэг)
- 50-41 Хүнд зэргийн шинж тэмдгүүд (амиа хорлох сэдэлтэй, ойр ойрхон хулгай хийх) эсвэл нийтийн, ажил мэргэжлийн болон сургуулийн орчинд хүнд зэргийн асуудалтай (найз нөхөдгүй, ажил эрхэлж чадахгүй)
- 40-31 Харилцаа холбооны зарим асуудалтай (утгагүй, хэрэггүй зүйлийн талаар ярих) эсвэл ажил мэргэжил, сургууль ба гэр бүлийн харилцаа, сэтгэл санааны байдал, шүүж дүгнэлт хийх чадвар, бодох чадвар зэрэгт асуудал ихээр үүсэх (сэтгэл санааны гутралд орж найз нөхдөөсөө холдох, гэр бүлээ орхин хаягдуулах, ажил эрхлэх чадваргүй болох, насанд хүрээгүй хүүхэд өөрөөсөө бага насны хүүхдүүдийг зодох, сургуульдаа хоцрогдох, үгэнд орохгүй байх)
- 30-21 Хий үзэгдэл харах, түүндээ итгэн үйлдэл хийх эсвэл харилцааны болон шүүж дүгнэх чадварт маш хүнд зэргийн асуудалтай байх (амиа хорлохыг завдах, тогтворгүй, маш бүдүүлэг байх) эсвэл ихэнх амьдралын энгийн үйл ажиллагаанд оролцох чадваргүй байх (өдөржингөө орондоо байх, ажилгүй, гэр оронгүй эсвэл найз нөхөдгүй байх)
- 20-11 Бусдыг болон өөрийг гэмтээх аюултай (нас барах талаар бодолгүйгээр амиа хорлохыг завдах, догшин ширүүн болон хэрцгий үйлдлүүд гаргах, маник хэлбэрийн сэтгэл хөөрөлтэй байх) эсвэл энгийн хувийн ариун цэврийг хааяадаа сахиж чадахгүй байх эсвэл харилцааны том доголдолтой байх (ярихгүй байх эсвэл огт утгагүй зүйлийн талаар ярих)
- 10-1 Бусдыг болон өөрийг байнгын гэмтээх аюултай (ойр ойрхон хэрцгий, догшин үйлдлүүд гаргах) эсвэл энгийн хувийн ариун цэврийг огт сахижгүй байх эсвэл нас барах талаар мэдсээр байж амиа хорлох гэж завдах

II. Сэтгэцийн доголдлын үнэлгээ¹⁶⁴

6 зүйл дээр үнэлгээг 1-5 хүртэлх оноотой үнэлнэ:

1. Хувийн ариун цэвэр, өөртөө санаа тавих, өдөр тутмын ердийн үйл ажиллагаа;
2. Амьдралын идэвх, нийтийн болон хувийн сонирхлын үйл ажиллагаанд оролцох;
3. Гадны орчинтой харьцаатай байх;

4. Бусадтай харилцаатай байх;
5. Төвлөрөх чадвар, тууштай байдал болон сэтгэн бодох хурд;
6. Дасан зохицох чадвар, ажил эрхлэлт.

Энэхүү 6 зүйлүүдийг хамгийн багаас ихрүү нь жагсааж, дунд нь байгаа 2 үзүүлэлтүүдийг хооронд нь нэмснээр үнэлгээг гарна

Sum of PIRS mind-point score	PIRS impairment score
2	0%
3	5%
4	10%
5	15%
6	20%
7	30%
8	40%
9-10	50%

Эдгээр 6 зүйлийг үнэлэхэд тус бүр анхаарах тайлбарууд:

1. Хувийн ариун цэвэр, өөртөө санаа тавих, өдөр тутмын ердийн үйл ажиллагаа.
 - 1) Асуудалгүй, эсвэл хүн бүрт байдаг энгийн асуудалтай.
 - 2) Хөнгөн зэргийн доголдолтой. Бие даан амьдрах чадвартай, өөрийгөө арчлах чадвартай, хааяа эмх цэгцгүй, бохир байх тохиолдол бий, хааяа хоол идэхгүй өнжих эсвэл гаднаас хоол авах.
 - 3) Дунд зэргийн доголдолтой. Бие даан ганцаараа амьдрах чадваргүй. Өдөр тутам усанд орж, цэвэрхэн хувцас өмсөхөд бусдаар ятгуулах шаардлагатай. Өөрийнхөө хоол хүнсийг бэлдэх чадваргүй, ойр ойрхон хоол идэхгүй өнждөг. Долоо хоногт гэр бүлийн гишүүн эсвэл асрагч ирж энгийн хувийн ариун цэвэр сахиж байгаа үгүйг шалгах шаардлагатай.
 - 4) Хүнд зэргийн доголдолтой. Хамтран амьдран санаа тавих хэрэгтэй.
 - 5) Бүрэн доголдолтой. Хооллох, ариун цэврийн өрөөг ашиглах мэт энгийн амьдралын үйл ажиллагаанд туслалцаа, асаргаа шаардлагатай.
2. Амьдралын идэвх, нийтийн болон хувийн сонирхлын үйл ажиллагаанд оролцох:
 - 1) Асуудалгүй, эсвэл хүн бүрт байдаг энгийн асуудалтай. Өөрийн нас, хүйс, соёлд таарсан байнгын нийгмийн оролцоотой. Янз бүрийн гишүүнчлэлд хамрагдсан бөгөөд түүндээ идэвхтэй оролцдог байж болно.
 - 2) Хөнгөн зэргийн доголдолтой. Хааяа хувийн сонирхлын үйл ажиллагаанд бусдын туслалцаагүйгээр оролцдог боловч түүндээ идэвхтэй оролцоотой биш (бүжиглэх, дуртай спортын багаа дэмжих зэрэг)
 - 3) Дунд зэргийн доголдолтой. Хувийн сонирхлын үйл ажиллагаанд ховорхон явдаг бөгөөд тэр нь ихэвчлэн гэр бүлийн гишүүн эсвэл дотны найзын хүсэлт, ятгалгаагаар оролцдог. Туслалцаа өгөх хүнгүйгээр явахгүй. Идэвхгүй, чимээгүй бас хөндий.

- 4) Хүнд зэргийн доголдолтой. Оршин сууж байгаа газраасаа хэзээ ч гардаггүй. Зөвхөн гэр бүлийн гишүүн эсвэл дотны найзын хүрээлэлд байж чадах бөгөөд өөр хүн ирэхэд зайлсхийдэг.
 - 5) Бүрэн доголдолтой. Өөр хүнтэй хамт амьдрах ямар ч чадваргүй бөгөөд дотны гэр бүлийн гишүүний хүрээлэлд ч маш тавгүй байдаг.
3. Гадны орчинтой харьцаатай байх:
- 1) Асуудалгүй, эсвэл хүн бүрт байдаг энгийн асуудалтай. Шинэ газарлуу бусдын туслалцаагүйгээр гарч явах чадвартай.
 - 2) Хөнгөн зэргийн доголдолтой. Бусдын туслалцаагүйгээр гарч чадна гэхдээ зөвхөн өөрийн мэддэг орчин руу, жишээ нь дэлгүүр, хөрш айл гэх мэт.
 - 3) Дунд зэргийн доголдолтой. Өөрийн оршин суудаг газраасаа бусдын туслалцаагүйгээр гадагш гарах чадваргүй. Ихэвчлэн их хэмжээний түгшүүртэй эсвэл танин мэдэхүйн доголдолтойгоос болдог.
 - 4) Хүнд зэргийн доголдолтой. Өөрийн оршин суудаг газраасаа гарахад хүндрэлтэй санагддаг ба өөрийн найдвартай хүний хамт гарахад ч хэцүү санагддаг.
 - 5) Бүрэн доголдолтой. Гадагш гарахад 2 ба түүнээс дээш хүний туслалцаа шаардагдана.
4. Бусадтай харилцаатай байх:
- 1) Асуудалгүй, эсвэл хүн бүрт байдаг энгийн асуудалтай. Дотно харилцааг үүсгэх ба хадгалахад хүндрэлгүй, жишээ нь хосын харилцаа, удаан хугацааны дотно нөхөрлөл гэх мэт.
 - 2) Хөнгөн зэргийн доголдолтой. Хувийн харилцаанд зарим асуудал үүснэ. Хостойгоо, эсвэл дотно гэр бүлийн гишүүнтэйгээ маргалдах, зарим нөхөрлөлийн харилцаа тасрах зэрэг.
 - 3) Дунд зэргийн доголдолтой. Хувийн харилцаанууд маш асуудалтай болсон, бусдаас хөндийрсөн, эсвэл гэр бүлийн хүчирхийлэлтэй. Нөхөр/ эхнэр, хамаатан садан эсвэл асрамжийн газар өөрийнх нь оронд хүүхдүүдийг нь асарч харж байгаа зэрэг.
 - 4) Хүнд зэргийн доголдолтой. Урт удаан хугацааны харилцаа тогтоох эсвэл хадгалж явах чадваргүй. Бусдыг асрах чадваргүй, хүүхдээ эсвэл эцэг эхээ.
 - 5) Бүрэн доголдолтой. Нийгэмд оролцох чадваргүй. Хүн ихтэй газраас хол амьдардаг, бусадтай харилцахаас зайлсхийдэг.
5. Төвлөрөх чадвар, тууштай байдал болон сэтгэн бодох хурд:
- 1) Асуудалгүй, эсвэл хүн бүрт байдаг энгийн асуудалтай.
 - 2) Хөнгөн зэргийн доголдолтой. Дахин суралцах курс эсвэл энгийн сургалтад арай бага хурдтайгаар суралцаж чадна. Оюун ухаан шаардсан даалгаварт 30 минут хүртэлх хугацаанд төвлөрч чадна, түүний дараа ядарсан мэдрэмж авах эсвэл толгой нь өвдөх.
 - 3) Дунд зэргийн доголдолтой. Сонин сэтгүүлийн нийтлэлээс ихийг уншиж чадахгүй. Нарийн зааварчилгааг дагах нь бэрхшээлтэй санагдана.
 - 4) Хүнд зэргийн доголдолтой. Зөвхөн хэдэн эгнээ зүйлийг л төвлөрч уншиж чадна. Энгийн зааварчилгааг дагахад хүндрэлтэй. Богино ярилцлагын

үед ч төвлөрөхөд бэрхшээлтэй байгаа нь илт харагдана. Ганцаараа амьдарч чадахгүй бөгөөд байнгын бусдын туслалцаа хэрэгтэй болно.

5) Бүрэн доголдолтой. Байнгын асаргаатай асрамжийн газарт байрлах шаардлагатай.

6. Дасан зохицох чадвар, ажил эрхлэлт:

1) Асуудалгүй, эсвэл хүн бүрт байдаг энгийн асуудалтай. Бүтэн цагаар ажиллаж чадна. Ажил эрхлэлтийн энгийн шаардлагыг биелүүлэх чадвартай. Гэмтсэн хүний боловсролтой дүйцэхүйц ажлын үүрэг даалгавар, биелүүлэлтийн үзүүлэлттэй.

2) Хөнгөн зэргийн доголдолтой. Бүтэн цагаар ажиллаж чадах ч ажлын ачаалалд өөрчлөлт оруулсан, эсвэл тухайн ажлын байрандаа бага цагаар ажиллах чадвартай.

3) Дунд зэргийн доголдолтой. Тухайн ажлын байрандаа ажиллаж огт чадахгүй. Магадгүй арай бага ачаалал, шаардлагатай ажил эрхлэх боломжтой.

4) Хүнд зэргийн доголдолтой. Ямар ч ажилд тогтсон хугацаанд ажил эрхэлж чадахгүй.

5) Бүрэн доголдолтой. Огтхон ч ажил эрхэлж чадахгүй.

Эдгээрийг үнэлэхэд олон эх сурвалжаас мэдээлэл авч үнэлнэ:

- Өвчтөний өөрийнх нь үнэлгээ;
- Өвчтөний түүхийг өөр хүнээс асуумж авах (оюун санааг үнэлэх);
- Ажиглах болон хэвийн үйл ажиллагааны чадварыг үнэлэх тест;
- Бие даах чадварыг үнэлэх тест;
- Ажлын талаарх түүх, мэдээлэл;
- Нийгмийн үйл ажиллагаа, оролцооны талаарх мэдээлэл;
- Оюун санааны байдлын ажиглалт;
- Бусад бичиг баримт.

Эдгээрийг үнэлэхдээ эмнэлзүй болон шалтгаан хоорондоо хамааралтай эсэхийг үнэлэх нь чухал.

III. Сэтгэцийн товч үнэлгээ¹⁶⁵

Энэхүү үнэлгээ нь сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдийн сэтгэцийн гаралтай шинж тэмдгүүдийг үнэлдэг.

24 зүйлийг 1-7 хүртэл үнэлгээ өгнө.

1- байхгүй

2- маш бага

3- бага

4- дунд зэрэг

5- хүндэвтэр

6- хүнд

7- маш хүнд

Эцэст нь нийлбэр дүнгээр үнэлгээ нь гарна.

165 www.ama-assn.org

Шинж тэмдэг		Дүн						
1.	БМБ-д илрэх шинж тэмдэг, өвдөлт зэрэг ∞	1	2	3	4	5	6	7
2.	Сэтгэл түгшил ∞	1	2	3	4	5	6	7
3.	Сэтгэл гутрал ∞	1	2	3	4	5	6	7
4.	Амиа хорлох сэдэл ∞	1	2	3	4	5	6	7
5.	Гэмших мэдрэмж ∞	1	2	3	4	5	6	7
6.	Дайсагнал, өшөөрхөл	1	2	3	4	5	6	7
7.	Сэтгэл санаа хөөрөх	1	2	3	4	5	6	7
8.	Агуу ихийн дэмийрэл	1	2	3	4	5	6	7
9.	Хардах мэдрэмж	1	2	3	4	5	6	7
10.	Хий харах	1	2	3	4	5	6	7
11.	Хэвийн бус бодол төрөх	1	2	3	4	5	6	7
12.	Ердийн бус зан авир гаргах	1	2	3	4	5	6	7
13.	Өөртөө хайхрамжгүй хандах	1	2	3	4	5	6	7
14.	Орчны харьцаа алдагдах	1	2	3	4	5	6	7
15.	Утга учиргүй бодлууд, яриа*	1	2	3	4	5	6	7
16.	Сэтгэл хөдлөлөө идэрхийлж чадахгүй, үзүүлэхгүй байх	1	2	3	4	5	6	7
17.	Бусдаас өөрийгөө тусгаарлаж, сэтгэл хөдлөлөө өөртөө хадгалах	1	2	3	4	5	6	7
18.	Үйл хөдөлгөөн удаашрах	1	2	3	4	5	6	7
19.	Дарамттай байгаа мэдрэмж* ∞	1	2	3	4	5	6	7
20.	Хамтран ажиллах чадваргүй*	1	2	3	4	5	6	7
21.	Сэтгэлийн хөөрөл ихтэй*	1	2	3	4	5	6	7
22.	Амархан сатаарах *∞	1	2	3	4	5	6	7
23.	Үйл хөдөлгөөн хэт ихсэх *	1	2	3	4	5	6	7
24.	Биеийн байрлал, үйл хөдөлгөөн, яриа *	1	2	3	4	5	6	7

Тодруулсан нь – хохирол барагдуулах өвчтнүүдэд хамгийн хамаралтай байдаг.

* - ажиглалтаар үнэлгээг өгнө

∞ - түлхүүр зүйлс

Нийт оноо	Хувь
24-30	0%
31-35	5%
36-40	10%
41-45	15%
46-50	20%
51-60	30%
61-70	40%
71-168	50%

Эцсийн нийлбэр үнэлгээ: Нийт 3 шалгуурын хувь оноог багаас нь ихрүү жагсаан дундаж оноог сонгосноор эцсийн үнэлгээ дүн нь болно.

Дээрх судалгааны гуравдугаар бүлгийг товч дүгнэхэд:

Дээрх бүлгийн судалгаанаас дүгнэлт хийхэд Дэлхийн өндөр хөгжилтэй зарим улс орнууд нь өөр өөрийн гэсэн эдийн бус хохирлын нөхөн төлбөрийг тооцон барагдуулдаг эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгон хүний зөрчигдсөн эрхийг хамгаалан хэрэгжүүлж байгаа нь чухал ач холбогдолтой байна. Тухайлбал, Австрали Улс нь Иргэний хариуцлагын тухай хууль (2002 он), Ажилчдад олгох нөхөн олговрын тухай хууль, Автомашинны ослын нөхөн төлбөрийн тухай хууль (1999 он), Бүгд Найрамдах Итали Улс нь хохирол барагдуулах тал дээр хөгжсөн тогтолцоо нь даатгалын тогтолцоо бөгөөд, Хувийн даатгалын тухай хууль, (Хууль тогтоомжийн

2005 оны 9-р сарын 7-ны өдрийн 209 тоот тогтоол), ИБУИНВУ-д гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг “2012 оны Эрүүгийн гэмтлээс үүдэх хохирлын нөхөн төлбөрийн схем”, БНХАУ-д шүүхэд хэрэглэгддэг шүүхийн оюун санаа болон сэтгэцийн доголдол үнэлэхдээ American Medical Association- Америкийн эмнэл зүйн нийгэмлэгээс гаргасан олон улсад хэрэглэгддэг оюун санаа болон сэтгэцийн доголдол үнэлэх зааварчилгаа AMA Guides гэдэг албан ёсны нэршилтэй хохирол тооцох 3 түвшний үнэлгээний аргачлал, зэрэг хууль болон журмуудаар зохицуулж өгснөөрөө иргэдийн сэтгэл санааны хохирлоо нэхэмжлэх, барагдуулах боломж нь илүү нээлттэй хүртээмжтэй болсон нь хохирол барагдуулахад чухал ач холбогдолтой болсон байна.

Австрали Улс гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрт хамгийн ноцтой тохиолдолд дунджаар 658,000 ам.доллар олгодог байна. Зарим мужид үүнээс өндөр олгох тохиолдол байдаг. Тухайн улсын муж улсууд нь эдийн бус хохирлыг тооцох нэгдсэн нэг хууль тогтоомж байхгүй, өөр өөрсдийн муж улсуудын парламентаас батлан гарсан хууль тогтоомжийн дагуу ялгавартайгаар зохицуулдаг байна. Тухайлбал, Хуулиар тогтоосон үнэлгээний хувьчлал бүхий босгыг давсан байх ёстой бөгөөд тэр нь муж улс бүрээсээ хамаараад 5%, 10%, 15% бүхий ялгаатай босготой байгаа нь онцлог байна. Гэсэн хэдий ч тооцох аргачлалын хувьд тогтсон нэг хандлага, нэгдсэн нэг арга барил байна. Тодруулбал, заавал мэргэжлийн байгууллагаас батлан гаргасан хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэл зүйн болон сэтгэцийн гэмтэл байгаа тохиолдолд хохирлыг нөхөн барагдуулахаар хууль тогтоомждоо тусгасан байна. Харин “хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэл зүйн гэмтэл” гэсэн ойлголтыг хууль тогтоомжидоо нарийн тусгаагүй ч Америкийн эмнэл зүйн холбооноос хэвлэн гаргасан Сэтгэцийн эмгэгийг оношлох, статистикийн гарын авлага.(DSM)-ыг тогтмол хэрэглэдэг бөгөөд хохирол барагдуулах нөхөн төлбөрийг тооцох үнэлгээний хүснэгтийг ашигладаг байна. Сэтгэл санааны хохирлыг тооцох гарын авлага, удирдамж дээр үндэслэдэг байна. Тухайн гарын авлагыг шууд хэрэглэх аль эсвэл эрх бүхий байгууллагаас тус гарын авлагатай адил агуулга бүхий маягт, гарын авлагыг боловсруулж, хохирол тооцох үнэлгээг гаргаж авах нь түгээмэл ажиглагдаж байна.

Тус гарын авлага дээр үндэслэн мэргэжлийн эмч нар нь урьдчилан заасан объектив үнэлгээг үндэслэн, сэтгэл санааны хохирлын зэрэг, үнэлгээг хувьчлан тогтоодог байна. Тухайн мэргэжлийн байгууллагын гэмтлийн зэрэг, үнэлгээн дээр суурилан шүүхээс мөнгөн дүнгийн нөхөн олговрыг тогтоох бөгөөд гэмтлийн үнэлгээний хувь нь өндөр байх тусам өндөр хэмжээний нөхөн олговрыг тогтоодог болох нь судалгаанаас харагдаж байна.

Мөн гадаадын орнуудын туршлага практикаас харахад хохирол барагдуулах тухай хууль тогтоомжид Зам тээврийн осол болон эрүүл мэндийн салбарын хариуцлага алдсаны улмаас гэмтэл авсан үед эдийн бус хохирлыг нэхэмжлэхэд хохирлыг тооцох тухай аргачлалыг боловсруулсан байна. Тухайлбал:

Бүгд Найрамдах Итали Улс нь хохирол барагдуулах тал дээр хөгжсөн тогтолцоо нь даатгалын тогтолцоо бөгөөд, Хувийн даатгалын тухай хууль гарснаар иргэдийн хохирол барагдуулах боломж нь илүү нээлттэй хүртээмжтэй болсон байна.

ИБУИНВУ-д гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг “2012 оны Эрүүгийн гэмтлээс үүдэх хохирлын нөхөн төлбөрийн схем” нь шүүхийн практик болон инфляцыг харгалзан тогтмол шинэчлэгддэг бөгөөд зөвхөн зөвлөмжийн шинж чанартай байдаг байна. Гэсэн хэдий ч практикт шүүгчид дээрх зөвлөмжийг дагаж мөрддөг. Гэхдээ хэргийн тодорхой нөхцөл байдлаас хамаарч

талууд хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх эсхүл буруулах талаар маргаж болдог. Сэтгэл санааны хохирлын нийт хэмжээг “шударга болон үндэслэл” бүхий байх зарчмыг баримтлан тодорхойлдог нь судалгаагаар харагдаж байна.

Эдийн бус хохирлын хувьд тухайн тохиолдолд хамгийн дээд хэмжээг ИБУИНВУ барагдуулсан бол Испани улс нь хамгийн доод нөхөн төлбөр олголт өгсөн туршлага байна.

Гэхдээ Итали улс нь Европын бусад орнуудаас хамгийн өндөр эдийн бус хохирол болон нийт дүнгээрээ хамгийн өндөр тооцооллоор хохирлыг барагдуулсан байна. Тэрч утгаараа Итали улс нь Европын бусад орнуудаас ихээхэн онцлогтой байгаа учир тус улсын гэмтлийн улмаас учирсан хохирлын тооцооллыг нарийвчлан судлан үзэх нь зүйтэй болов уу.

ХБНГУ-ын Иргэний хуулийн §823-ийн дагуу үндэслэл бүхий нэхэмжлэл гаргахын тулд хүний амь нас, бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө, ашиг сонирхлын аль нэгийн зөрчсөн болохыг нотлох ёстой. Эрүүл мэндэд гэмтэл учруулах нь зөвхөн бие махбодын гэмтэл бус болон сэтгэцийн хэлбэртэй байж болно гэж үзсэн нь илүү тодорхой нээлттэй боломжуудыг хуульдаа зааж өгсөн байна.

Мөн хүний амь насанд хохирол учруулсан тохиолдолд амь үрэгдсэн хүнд нөхөн олговор олгох эрхгүй, харин зөвхөн өөрөөс нь хамааралтай байсан гуравдагч этгээдэд л ХБНГУ-ын Иргэний хуулийн 704т заасны дагуу олгодог байна.¹⁶⁶

Тухайлбал, ХБНГУ-д хүний амь нас хохирсны нөхөн төлбөрийг хууль заасан тодорхой хамаатан саднаар нь хязгаарладаг байна. Өөрөөр хэлбэл садан төрлийн хэн дуртай нь сэтгэл санааны хохирлын нэхэмжлэлийг гаргадаггүй бөгөөд зөвхөн шалтгаант холбоотой эсэхийг нотолсны дараа хохирлыг барагдуулах үгүйг шийддэг байна.

Франц Улсад хохирогч нас барсан зарим тохиолдолд хохирогчийн өв залгамжлагчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргаж болдог байна. Харин амьд үлдсэн тохиолдолд шууд бус байдлаар хохирогчийн ойр дотнын хүмүүст сэтгэл санааны хохирол үүсэж болох бөгөөд хохирлыг нөхөн төлүүлж болно гэж үздэг хууль эрх зүйн зохицуулалт байдаг байна.

АНУ-д Эдийн бус хохирлын хязгаарлалт нь эмнэлгийн мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдаагүй аливаа хариуцагч авах боломжгүй бөгөөд мөн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид ногдуулсан мэргэжлийн хариуцлага хүлээлгэх ажиллагааны улмаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд шаардагдах нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь 1 сая ам.доллараос хэтрэхгүй байна гэж үзсэн байна. Үүний жишгээс харахад Монгол Улсад ч мөн адил ийм тогтолцоог нэвтрүүлэх нь илүү оновчтой болох нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан улсуудын хохирол барагдуулж байгаа нөхөн төлбөрийн дээд доод хязгаарыг дүгнэн авч үзэхэд, Тухайлбал,

АНУ нь эдийн бус хохирол нь тэр дундаа эмнэлгийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон тохиолдлуудад олон мужууд 250,000-750,000 ам.доллар ба түүнээс дээш долларын хооронд хязгаар тогтоодог байна¹⁶⁷.

166 Werner Ebke and Mathew Finkin, Introduction to German Law. (1996) 201.

167 *Morgenstern, Michael* (9 September 2015). “[Medical Malpractice Damages Caps: A State By State Comparison](#)”. *The Expert Institute*. Retrieved 2 July 2017.

ИБУИНВУ-д гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг дээд хэмжээ нь 110,000 фаунт стерлингийг нөхөн төлбөрт олгодог байна.

ХБНГУ-д нэхэмжлэлийн хохирлын шаардлагыг үнэлэх, тодорхойлоход тухайлсан хуулиар тогтоосон хүснэгт, тооцох аргачлал байхгүй тул харин өмнөх шүүхийн прецедент болон журмуудаар тодорхойлдог байна.¹⁶⁸ Тиймээс шүүх хохирогчийн гэмтлийн хүндийн байдал, хохирогчийн нас, зовлон шаналал, эрч хүч, нийт хохирлын хэмжээнд нөлөөлж болох бусад бүх нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой. Хамгийн ноцтой кейсд олгосон сэтгэлийн өвдөлт, шаналал нь 500,000 еврогоос 600,000 еврогийн хооронд хэлбэлздэг бөгөөд үүнийг тогтмол олгох нэг жилийн үнэлгээ хэлбэрээр олгох боломжтой. Шүүгчид энэхүү үнэлгээг хийхэд хувийн хэвшлийн байгууллагуудаас баталж гаргасан хэргийн тухай нийтэлж гаргасан лавлагаа, эмхэтгэлээр хохирлын үнэлгээг хийхэд ашигладаг.¹⁶⁹ Гэвч тэдгээр нь заавал мөрдөгдөх хууль ёсны хүчин чадалгүй байдаг онцлогтой гэж үзсэн байна.

БНФУ гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санаа, эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах боломжгүй бол сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр 50,000 – 80,000 евро хүртэл хэмжээгээр хохирлыг барагдуулдаг. Онцгой тохиолдолд 80,000 еврогоос дээш хэмжээгээр хохирол барагдуулж болдог байна. Нөхөн төлбөр олгох хугацааг хохирогчийн амьдрал хэвийн болох хүртэл хугацааг тооцож олгодог. 2016 онд гаргасан зөвлөмжид заасны дагуу сард 600-900 евро, БНСУ(Судалгаанд ороогүй)-ын хувьд сэтгэл санааны хохирлын суурь төлбөрийг 80 сая вонн зэрэг тус тус тооцон олгодог жишиг үнэлгээнүүдийн дагуу хохирол барагдуулдаг шүүхийн практик тогтолцоо нэгэнт бий болон хэрэгжиж байна.

Монгол Улсад төрийн албан хаагчийн буруу шийдвэр, эрх мэдлээ урвуулан ашигласан болон төрийн алдаатай буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан эдийн болон эдийн бус гэм хор, хохирол гарсаар байна. Үүнийг дагаад хохирогчид учирч байгаа сэтгэл санааны хохирлыг барагдуулах ажил хангалтгүй байна.

Энэ талаар судалгаанд хамрагдаагүй ч гэлээ Япон (судалгаанд ороогүй улс) Улс нь төрийн албан хаагчийн буруу шийдвэр, эрх мэдлээ урвуулан ашигласан болон төрийн алдаатай буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан гэм хор хохирол төлөн барагдуулах хууль эрх зүйн зохицуулалтыг Япон Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд “Хүн бүр төрийн албан хаагчийн хууль бус актын улмаас учирсан хохирлоо төлүүлэхээр төрийн болон нийтийн байгууллагад хандан гомдол гаргах эрхтэй” гэж заасан¹⁷⁰ хүрээнд 1947 оны нөхөн төлбөрийн тухай хууль батлагджээ. Уг хуулийн 1 дүгээр зүйлээр төрийн албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэхдээ бусдад учруулсан гэм хорыг төр хариуцах талаар заасан бөгөөд төрөөс хохирлоо төлүүлэхээр шаардах эрхийн үндэслэл нь энэхүү тусгайлсан хуулиар тодорхойлогдоно гэж иргэний эрх зүйн судлаачид нь тайлбарладаг.¹⁷¹ Хэдийгээр бусдад учруулсан хохирлыг төрийн албан хаагчийн өмнөөс төр арилгаж байгаагаараа уг зохицуулалт нь Иргэний хуулиар тодорхойлсон ажил олгогч, асран хамгаалагч этгээдийн хариуцлагатай хэлбэрийн хувьд төстэй мэт боловч ийнхүү тусгайлан зохицуулах зорилго нь тухайн ажилтныг хамгаалах бус, харин гэм хорын улмаас хохирсон этгээдийн хувьд төрийн албан хаагчийн эсрэг шаардлага гаргахад

168 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

169 Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10.

170 Япон Улсын Үндсэн хууль (орчуулсан П.Амаржаргал, хянан тохиолдуулсан Н.Лүндэндорж), 2011 он, х. 12.

171 Shiyomi yoshio, Saiken Kakuron II, Fuhou kouii hou, (2007).

үүсэх хүндрэлтэй, сул талыг арилгахад чиглэсэн гэж тайлбарлан Иргэний хуулиар тодорхойлсон ажил олгогчийн болон бусдын өмнөөс хариуцлага хүлээдэг бусад төрөлтэй адилтган үзэх боломжгүй гэж үзсэн¹⁷² байгааг дурдахгүй өнгөрч боломгүй юм.

Мөн БНХАУ, БНСУ(судалгаанд ороогүй улс) зэрэг улсуудын хувьд дээрхийн адил төрийн албан хаагчийн учруулсан гэм хорыг Төрийн хариуцлагын талаарх тусгай хуулийн хүрээнд зохицуулах хандлага байна. Жишээлбэл, БНХАУ-ын Иргэний хуульд гэм хорын асуудлыг хуульчлалгүйгээр бие даасан “Төрөөс нөхөн төлөх тухай хууль”-аар тухайн эрх зүйн асуудлыг зохицуулж, захиргааны болон төрийн тусгай байгууллагуудаас иргэнд учруулсан амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хариуцлагыг төр шууд хариуцан арилгахаар хуульчилсан байгаа нь сайн талтай юм.

БНСУ-ын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлээр төрөөс хохирлоо шаардах эрхийг баталгаажуулж¹⁷³ Төрийн нөхөн төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлээр төрийн албан хаагчийн учруулсан, 5 дугаар зүйлээр албан байгууллагын учруулсан хохирлыг төр хариуцан арилгахаар заасан байх бөгөөд шүүх Иргэний хуулийн бусад зохицуулалтуудыг давхар баримталсан байдал харагдаж байна.¹⁷⁴

БНСУ-д сэтгэл санааны хохирлыг тооцох тусгай аргачлалтай. БНСУ-д хохирогчид сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр олгоод зогсохгүй хохирогчийн гэр бүлийн гишүүн бүрт нь тооцож өгдөг байна. Өөрөөр хэлбэл, хохирогчид үүссэн сэтгэл санааны тавгүй байдал гэр бүлийн гишүүдэд нөлөөлдөг хэмээн үзжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хүний ам нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлын үнэлгээг АНУ, ХБНГУ, Япон Улс зэрэг орнуудад хохирлын үнэлгээг тогтоодог хууль зүйн шинжилгээний тусгай лабораторийг ашигладаг бөгөөд Монгол Улсад ч гэсэн бий болгон эдийн бус хохирол болон сэтгэл санааны хохирол гэм хорыг тооцон барагдуулдаг, хохирлын үнэлгээг тогтоодог арга, аргачлал, хууль хэрэгжилтийн тогтолцоог бүрэн хангаж ажиллах эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгож хэрэгжүүлж ажиллах нь Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд гол үүрэг рольтой төдийгүй хүний эрхийг хангах тэр дундаа зөрчигдсэн эрхийг хамгаалахад нэн чухал ач холбогдолтой алхам болно гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

172 Wagatsuma Takashi, Ariizomu Tohru, Shimizu Makoto, Kommentaru Minpou: Sousoku, Bukken, Saiken, (2006) pp. 1262-1263.

173 БНСУ-ын Үндсэн хууль (орчуулсан Б. Энхчулуун), 2011 он, х. 17.

174 Decisions of the Trial and Appellate Courts: Volume I, Supreme Court Library, Republic of Korea (2011) pp. 1-11.

ДҮГНЭЛТ

Орчин үед дэлхий нийт техник технологийн өндөр хөгжилтэй уялдан хүн амын төвлөрөл, үйлдвэржилтийг дагасан амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн эрсдэл нийгмийн аюулгүй байдал зэргээс шалтгаалан бий болсон хүний эрхийг хангах түүний зөрчигдсэн эрхийг хамгаалах үүднээс улс орнууд эрх зүйн тогтолцоондоо гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол, гэм хорыг арилгах асуудал түүнийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн хувьд нарийн тогтолцоог улам боловсронгуй болгон хөгжиж байна.

Эрх зүй өндөр хөгжсөн зарим улс оронд гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоог өөрийн оронд бүрэн нэвтрүүлэн хэрэгжүүлбэл зохилтой байна.

Судлагдсан улс орнуудын туршлагыг харахад шүүхээр дан ганц хохирол барагдуулахаас гадна бусдад учруулсан гэм хорыг арилгах учирч болзошгүй аюулыг саармагжуулахын тулд гэм хорын даатгалын тогтолцоог хөгжүүлж, хохирлыг нийт нийгэмд тараан үүрүүлэхээс гадна¹⁷⁵ тухайн хохирогчид гэм хорыг төрийн албан хаагчийн зүгээс учруулснаас болон үүсэх сэтгэл санааны хохирлыг төр бас давхар хариуцах бүрэн боломжтой байгаа нь гадны улсуудын жишгээс харагдаж байна.

Олон улс орнууд эдийн бус хохирлын хэмжээг тусгайлсан хуулиар тогтоон хохирлыг барагдуулдаг байна.

Судалгаанаас харахад эдгээр зохицуулалтад нийтлэг байдлаар тодорхой төрлийн үйлдлийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын шинж чанар, хохирол учруулсан нөхцөл байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэн дээд болон доод хэмжээг тусгаж өгч тэр хүрээнд шүүх нотлох баримт, нөхцөл байдлыг үнэлэн нөхөн төлбөрийг ногдуулж байхаар хуульчилсан байна.

Гадаадын зарим оронд гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг тооцон барагдуулахдаа 50,000-125,000 мянган ам.доллороос эхлээд олон сая ам.доллороор тооцож хохирлын нөхөх төлбөрийг барагдуулж байна.”

Дээрхээс дүгнэхэд төрийн албан хаагчийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төрд хариуцуулах гол зорилгыг иргэний эрхийг хамгаалах үндсэн зорилготой холбон авч үзэх чиг хандлага иргэншсэн улс орнуудад нэгэнт тогтжээ. Мөн төрийн буруутай үйл ажиллагаанаас үүдсэн хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүднээс Засгийн газар нь нөхөн төлбөр олгох “хохирлын сан” “хохирол барагдуулах сан” зэрэг санг бий болгон байгуулж түүндээ хуримтлал бий болгож байгаа сайн жишиг байна.

Монгол Улсад хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримт зэргийг харгалзан хохирлыг тогтоож байна. Мөн Эрүүгийн хэргийн хохирогчийн хувьд бодит хохирлыг шүүх шийдвэрлэж байгаа ч эдийн бус хохирлын хэмжээг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна. Зөвхөн хуульд холбогдох заалтыг тусгаснаар сэтгэл санааны хохирлыг тооцох, барагдуулах эрх зүйн орчин бүрдсэн гэвэл өрөөсгөл талтай байна.

175 Kenneth S. Abraham, Twenty-First-Century Insurance and Loss Distribution in Tort Law in Exploring Tort Law ed. M.Stuart Madden, 2005 p.82

Сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын шинж чанар, хохирол учруулсан нөхцөл байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоож байхаар хуульчилсан байна. ХБНГУ-ын хувьд сэтгэл санааны гэм хорыг арилгахад тусгай аргачлал боловсруулсан бөгөөд үүнийг шүүх шийдвэр гаргахдаа мөрдлөг болгодог байна. Хохирлын хэмжээг тодорхойлохдоо хариуцагчийн эд хөрөнгийн байдал зэргийг харгалзан үздэг. Энэ талаар уг судалгаанд ороогүй улс болох БНСУ хувьд сэтгэл санааны хохирлын суурь төлбөрийг 80 сая вонноор үнэлдэг аж. /Монголоор 176,000,000/ сая төгрөг.

Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг 2016 онд (Төсөл хэлбэрээр байгаа тул хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг тус холбооны гүйцэтгэх захирал М.Бизаагундаа дурьдаж) боловсруулсан төсөл байдаг.

Ингэхдээ:

- Алдагдсан боломжийн үнэлгээ
- Сэтгэл санааны хохирлын үнэлгээ
- Шууд зардал буюу баримтаар нотлогдох бодит хохирлуудыг багтаан

эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол үнэлгээг тодорхой томьёонд оруулан тооцоолох байдлаар бодож тооцохоор тогтоосон аргачлалыг санаачлан боловсруулж байсан байна.

Гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол хүлээсэн этгээд нь өөрт учирсан хохирлоо тэр бүр нэхэмжилдэггүй, гаргасан цөөн нэхэмжлэлийг шүүхээс хэрэгсэхгүй болгох, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхийг заах төдийгөөр шийдвэрлэж байгаа нь хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад учир дутагдалтай байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн хохирсон чигээрээ үлдэж байгаа нь тэднийг хууль шүүхийн байгууллагад итгэх итгэлийг үгүй хийж нийгэмд хандах хандлагыг сөргөөр бий болгох үндэс бүрдэж байна. Иймд эрх нь зөрчигдсөн иргэдийн эрх ашиг нь заавал хангагддаг, хохирлыг барагдуулдаг байх хууль эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ зайлшгүй бий болж байна.

Монгол Улсын тухайд Иргэний хууль, ИХШХШТХ, Эрүүгийн хууль, ЭХШХШТХ-ийн зүйл, заалтууд болон Улсын дээд шүүхийн гаргасан тайлбар үндэслэл нь бодитой, тодорхой бус байгааг нэг мөр болгон хүний эрхийг хангах зөрчигдсөн эрхийг бүрэн хамгаалдаг тогтолцоог бий болгоход анхаарч эрх зүйн шинэтгэлийн үзэл баримтлалыг түүнд чиглүүлэх нь хамгийн оновчтой асуудал болох болов уу.

Иймд гадаадын улс орны сайн туршлагыг албан ёсны харилцааны шугамаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хамтын ажиллагааны хүрээнд хүсэлт тавин гаргуулан авч өөрийн орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинжлэх ухааны онол арга зүйн үүднээс судалж хүний эрхийн суурь зарчимд бүрэн нийцүүлсэн байр сууринаас боловсруулан үр дүнг практикт нэвтрүүлэх нь манай хууль зүйн шинжлэх ухааны өмнө тулгарч буй нэн тэргүүний асуудал болсон байна.

Судалгаанаас ажиглаж байхад ослын улмаас учирсан хохирлыг тооцох янз бүрийн арга замууд, олон хүчин зүйлийг харгалзан үзэх нь хамгийн чухал бөгөөд үүнд хамгийн чухал нь гэр бүл ба гэр бүлийн бус хохирлыг хооронд нь ялгах явдал чухал юм гэж үзсэн байна.

Мөн дээрх судлагдсан улсуудын практикаас харвал гэмт хэргийн улмаас хохирсон хүний санаа сэтгэл, бие эрхтний эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр

нөхөн төлж арилгах эрх зүйн зохицуулалтыг Иргэний хууль, Гэм хорын хариуцлагын тухай акт, Хөдөлмөрийн тухай хуулиудаар зохицуулж байна. Хохирол барагдуулах тухай хууль тогтоомж, Зам тээврийн осол болон эрүүл мэндийн салбарын хариуцлага алдсаны улмаас гэмтэл авсан үед эдийн бус хохирлыг нэхэмжлэхэд хохирлыг тооцох тухай аргачлалыг багтаасан Улсын болон хувийн Даатгалын тухай хуулиар зохицуулдаг байна. Уг зохицуулалтад нийтлэг байдлаар тодорхой төрлийн үйлдлийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлэн дээд болон доод хэмжээг тусгаж өгч тэр хүрээнд шүүх нотлох баримт, нөхцөл байдлыг үнэлэн нөхөн төлбөрийг ногдуулж байна. Ингэхдээ дээд доод интервалыг тогтоох нь нөгөө талаар шүүгчийн субъектив үнэлэмж орох магадлал өндөр учир маш нарийн системчлэн тогтоож өгөх тооцох аргачлалтай болох зайлшгүй шаардлагатай байна.

САНАЛ

Судалгаагаар авч үзсэн асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо дараах шалгуурыг харгалзан үзэх талаар эрх зүйн хэм хэмжээний актад тусгаж өгөх.
- Үүнд: Гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ, хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодын болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ хэмжээ, бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодын болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ шинж чанар, шударга ёсны шаардлага зэрэг,
- Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас эдийн болон эдийн бус хохирол учирсан иргэдэд Засгийн газрын зүгээс хохирол барагдуулах сан бий болгон тус сангаас нөхөн төлбөр олгох эрх зүйн боломжийг нээж өгч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах,
- Даатгалын системд сэтгэл санааны хохирлын талаарх нөхөн олговрын эрсдлийн үнэлгээг шинээр бий болгох түүнийг нийгэмд бодитойгоор хэрэгжүүлэх тал дээр гадны улс орны нийтлэг жишиг сайн туршлагыг нэвтрүүлэх,
- Шүүхийн журмаар хөдөлмөрийн харилцааны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлын маргааныг авч хэлэлцдэг болгох түүнийг заавал шийдвэрлэдэг байх үүднээс хуульчилж өгөх,
- Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлын талаарх гомдлоо эрүүгийн хэргийн шүүхэд гарган сэтгэл зүйн гэмтлийн зэргийг тогтоолгодог байх,
- Эдийн бус хохирлын үнэлгээг тогтоодог хууль зүйн шинжилгээний тусгай лабораторийг ашигладаг болох
- ЭХХШтХ-ийн 27 дугаар бүлэг, 27.1 дүгээр зүйлд гэмт хэргийн улмаас бусдад учирсан сэтгэл санааны хохирол буюу эдийн бус /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, болон бие эрхтэнд үүссэн гэмтэл зовиур, шаналал, өвчин буюу өвдөлтийн зэрэг/ хохирлын хэмжээг тогтоолгохоор нэхэмжилсэн тохиолдолд шүүх /шүүхийн шинжилгээг заавал хийлгэх/ эмнэлгийн дүгнэлт гаргуулах талаар тусган оруулах,
- Иргэний хуулийн 497, 511 дүгээр зүйлд сэтгэл зүй, бие эрхтэнд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй байхаар нэмж оруулах нь зүйтэй байна.
- Иргэний хуульд сэтгэл санааны хохирлын үнэлгээний тарифыг хуульчлан оруулж өгөх, эдийн бус хохирлын нөхөн төлбөрийн ямар хэлбэрээр барагдуулах тухай журмыг боловсруулж хуульчлах хэрэгтэй байна.
- Түүнчлэн гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлын талаарх нотлох баримтыг мөрдөгч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу цуглуулах, бүрдүүлэх ажиллагааг дутуу дулимаг хийдэгтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, оруулах замаар мөрдөн байцаах ажиллагаанд эдийн бус хохирлыг тогтоох нотлох аргыг илүү нарийн зааж өгөх хэрэгтэй байна. Иймд дээрх ажиллагааг бүрэн гүйцэд

хийлгэх тал дээр анхаарч сургалт, семинар зохион байгуулах, санал зөвлөмжийг бий болгох шаардлага гарч байна.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулан Сэтгэл санааны хохирлыг хэрхэн барагдуулах заалтыг тодорхой болгон оруулан журамлаж өгөх нь илүү ач холбогдолтой болов уу
- Мөн ЭХХШтХ-ийн 45 дугаар бүлэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн гэж явцууруулсан заалтаас шүүгч, прокурор, мөрдөгчийн гэсэн үгийг авах замаар тус хуульд нэмэлт, өөрчлөлт, оруулах замаар төрийн бүх байгууллагын албан хаагчийн болон албаны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан эдийн болон эдийн бус гэм хор, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх хохирлыг арилгах заалтыг илүү нарийн тодорхой болгох хэрэгтэй байна.

Ийнхүү гадны өндөр хөгжилтэй зарим улс орнуудын гэмт хэргийн улмаас учирсан хохирол тооцох оновчтой арга, аргачлалыг хэрхэн хуульчилсан байдлыг нь өөрийн орны эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэхийн тулд төрийн бодлогын хэмжээнд авч үзэн судлан нарийн судалгаа шинжилгээний хүрээнд боловсруулан гаргаж ирж шүүхийн практикт хэрэглэх нь нэн тэргүүний зорилт шаардлага болсон байна.

НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ, Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он;
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. УБ., 1946 он;
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он;
4. Иргэний хууль. УБ., 2002 он;
5. Эрүүгийн хууль. УБ., 2015 он;
6. Эрүүгийн хууль. УБ., 2019 он;
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2015 он;
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2019 он;
9. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он;
10. Монгол Улсын хөрөнгийн тухай хууль. УБ., 2010 он;
11. Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль. УБ., 1999 он;
12. Гэр бүлийн тухай хууль. УБ., 1999 он;
13. Улсын Дээд шүүхийн тогтоол, дугаар 15, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”. УБ., 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн;
14. БНБУ-ын Эрүүгийн процедурын хуулийн 73, 74; 76; 67; 382(10);
15. Civil Laws (Wrongs) Act 2002 (ACT);
16. Civil Liability Act 2002 (NSW);
17. Personal Injuries (Liabilities and Damages) Act 2003 (NT);
18. Law Reform Act 1995 (Qld) and Civil Liability Act 2003 (Qld);
19. Civil Liability Act 1936 (SA);
20. Civil Liability Act 2002 (Tas);
21. Wrongs Act 1958 (Vic);
22. Civil Liability Act 2002 (WA) and Volunteers and Food and Other Donors (Protection from Liability) Act 2002 (WA);
23. Commonwealth Volunteers Protection Act 2003 (Cth);
24. Fair Work Act 2009 (Cth) s 108 Entitlement to be absent from employment for engaging in eligible community service activity.

Ном, өгүүлэл, нийтэл, диссертаци:

1. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага. УБ., 2017 он;
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн тусгай анги. УБ., 2011 он;
3. Б.Буянхишиг. “Үүргийн эрх зүй (Ерөнхий анги), УБ., 2013 он;
4. Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2006 он;
5. Ё.Кают. Э.Шпанглер нар. “Монгол Улсын иргэний хуулийн тайлбар”. УБ., 2010 он;

6. Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, “Стрессийг үүсгэх шалтгаан ба оношлогоо, тусламж: Мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага”. УБ., 2010 он;
7. Б.Батсайхан, М.Дэлгэржав. Ерөнхий сэтгэл судлал. Анхны хэвлэл. УБ., 2013 он;
8. Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК). Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ. УБ., 2013 он;
9. Гүнтер Кристиан Шварц, Манфрэд Вандт. Хуульд зааснаар үүсэх үүргийн эрх зүй: Зөрчлийн улмаас үүсэх үүрэг буюу гэм хорын эрх зүй. 3 дахь хэвлэлт., УБ., 2017 он;
10. Г.Мягмарсүрэн, Монгол Улсад иргэний нэр төр, алдар хүндийг хуулиар хамгаалж ирсэн түүхэн уламжлал., “Сэтгэл санааны хохирлыг эргэн төлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь”., Монголын төр, эрх зүй сэтгүүл., №02, 2020 он;
11. Ч.Отгонсүрэн. Хүний амь нас сэтгэл санааны хохирлын үнэлгээний онол, практикийн тулгамдсан зарим асуудал. Гэмт явдалтай тэмцэх асуудал / Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл/ №2, 2019 он;
12. Д.Ганболд, Ажлын байран дахь дарамт шахалт, түүнийг шийдвэрлэх боломжууд., Монголын төр, эрх зүй сэтгүүл., №04, 2020 он;
13. С.Базарханд, “Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах хууль зүйн үндэслэлийн зарим асуудал”., Монголын төр, эрх зүй №1, 2018 он;
14. Н.Баярсүрэн, “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх ба гадаад орнуудын хуулийн зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №2, 2018 он;
15. Ш.Оюунханд, “Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ” Монголын төр, эрх зүй №3, 2013 он;
16. А.Баярцэцэг, Гадаадын зарим орнуудын гэмт хэргийн улмаас учирсан эрүүл мэнд амь насны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөрийн тогтолцоо., Монголын төр, эрх зүй сэтгүүл., №4, 2018 он;
17. Б.Зориг, Доромжлох гүтгэх гэмт хэргийг шийдвэрлэж ирсэн түүхэн уламжлал шинэчлэлийн асуудалд., Монголын төр, эрх зүй сэтгүүл., №1, 2015 он;
18. Н.Амарзаяа, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт”, Монголын төр, эрх зүй., №2, 2014 он;
19. Ц.Батчимэг, Б.Энхбаяр нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, УБ., 2005 он;
20. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол. (Сургалтын гарын авлага), УБ., 2008 он;
21. Үндсэн хууль ба эрх зүйт ёс-XI, УБ., 2020 он;
22. Law Enforcement, (Law enforcement university mongolia), УБ., №2, 2015 он
23. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги. УБ., 2011 он;
24. Л.Дарьсүрэн, “Эдийн бус гэм хорын маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэж буй практик асуудал”, Монголын төр, эрх зүй., №1, 2014 он
25. Хүний эрхийн цуврал нийтлэл. МУХЭҮК, УБ., 2013 он;

26. Э.Золзаяа, “Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №4, 2013 он;
27. Хууль дээдлэх ёс, (ХЗҮХ), №2 (72), 2002 он;
28. Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал I дэвтэр, УБ., 1999 он;
29. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Адмон хэвлэл, УБ., 2007 он;
30. Ц.Одмаа. Нийтийн эрх зүйн бүлийн зарим улс дахь эдийн бус гэм хорыг арилгах талаарх эрх зүйн зохицуулалт., Хууль дээдлэх ёс, УБ., 2009 он;
31. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/, УБ., 2010 он;
32. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. УБ., 2016 он;
33. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. УБ., 2017 он;
34. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн үйл ажиллагааны өнөөгийн байдал. УБ., 2017 он;
35. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал. УБ., 2017 он;
36. Д.Тамир, “Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал”, Хууль дээдлэх ёс №2, 2010 он;
37. Ж.Оюунтунгалаг, “Гэм хорын эрх зүйн зорилго: эрх зүй, эдийн засгийн хандлага” Шүүх эрх мэдэл №1, 2019 он;
38. Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, УБ., 2013 он;
39. Ш.Үнэнтөгс, “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт” Монголын төр эрх зүй сэтгүүл №2, 2018 он;
40. Б.Отгонзул. Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2011 он;
41. Ослын улмаас учирсан хохирол үнэлгээ 2015 он с (125-131);
42. Европын Сэтгэл зүйчдийн Холбоо, БНБУ-ын тайлан – 2018 он;
43. БНБУ-ын Дотоод хэргийн яамны албан ёсны цахим хуудас;
44. Давж заалдах шатны шүүхийн “Бие махбодид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай зөвлөмжийн лавлагаа”., 2016 он;
45. Бие махбодын гэмтэл бэртэл, нөхөн төлбөр олгох Франц Улс., 2013 оны тайлан.

Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, цахим эх сурвалжууд:

1. Betsy J. Grey, The Future of Emotional Harm, 83 Fordham L6 Rev6 2605 (2015);
2. John J. Kircher, The Four Faces of Tort Law: Liability for Emotional Harm, 90 Marg. L. Rev. 789 (2007);
3. M.Lee Huffaker. Recovery for Infliction of Emotional distress: A com-ment on the mental anguish accompanying such a claim in Alabama. (2003);
4. Francis X. Ciinch and Jodie L6 Johnson, Compensation of Emotional Distress in Montana: Distinctions between Bystanders and Direct Victims, 47 Mont. L. Rev. (1986);

5. Black's law dictionary 542, (7th ed. 1999);
6. Morgenstern, Michael (9 September 2015). "Medical Malpractice Damages Caps: A State By State Comparison". The Expert Institute. Retrieved 2 July 2017;
7. Mendelson, Danuta. (2005). The modern Australian law of mental harm: parochialism triumphant. *Journal of law and medicine*. 13. 164-72;
8. - Stannard, J. E. (2010). Sticks, stones and words: Emotional harm and the English criminal law. *The Journal of Criminal Law*, 74(6), 533-556;
9. *Chester v Council of Municipality of Waverley* (1939) 62 CLR 1);
10. Lorenzo Vismara, Gen Re, Milan, 2018, The Court of Milan Tables – Bodily Injury Compensation in Italy;
11. Diaz, J.A., 2010. Non Physical Damage: a Comparative Perspective;
12. Teff, H. (1998). Liability for Negligently Inflicted Psychiatric Harm: Justifications and Boundaries. *The Cambridge Law Journal*, 57(1), 91-122. Retrieved March 3, 2021, from;
13. W.Va. Code Ann. §55-7B-8 (West);
14. Werner Ebke and Mathew Finkin, *Introduction to German Law*. (1996) 201;
15. Civ. 2, 21 novembre 2013, n° 12- 28.168;
16. Civ. 2, 5 mars 2015, n° 14-10.758;
17. C.A. Paris, 6 fйv. 2014, n°11-03506; / Шүүхийн шийдвэр/
18. Civ. 2, 8 juin 2017, n° 16-19.185;
19. Civ. 2, 18 mars 2010, n° 08-16.169;
20. Civ. 2, 4 juillet 2013, n°12-23.915;
21. Civ. 1, 8 fйvrier 2017, n° 15- 21.528;
22. Civ. 2, 17 juin 2010, n° 09-15.842);
23. C.A. Lyon, 18 sept. 2014, n° 13-04832; /Шүүхийн шийдвэр/
24. Cass. ch. mixte, 27 fйvrier 1970, JCP 1970.II. 16305;
25. Ministry of justice, *The Criminal Injuries Compensation Scheme 2012*;
26. Civ. 2, 22 fйvrier 1995, Bull. civ. II, n° 61 ; comparer : Civ. 2, 22 novembre 2012, n° 11-21.031;
27. Vismara, L. (2014). A Comparison of Compensation for Personal Injury Claims in Europe. *GenRe*, 1-10;
28. Civ. 2, 22 fйvrier 1995, Bull. civ. II, n° 61 ; comparer : Civ. 2, 22 novembre 2012, n° 11-21.031;
29. Civ. 1, 8 fйvrier 2017, n° 15- 21.528;
30. Civ. 2, 17 juin 2010, n° 09-15.842);
31. C.A. Lyon, 18 sept. 2014, n° 13-04832;
32. Mannelqvist, R., *Compensation for victims in public legislation and as a civil right*. *Scandinavian Studies in Law*, 50, 423-434, (2007);
33. COUNTRY BASELINE UNDER THE ILO DECLARATION ANNUAL REVIEW: BULGARIA (2016-2019);
34. Google Scholar. Retrieved 3 October 2017;

35. Austin Lovegrove, *Judicial decision making sentencing policy and Numerical guidance*, Springer-Verlag;
36. Joel Samaha, *Criminal Procedure*, Wadsworth (VIII ed., 2012), P. 475
37. [Manual_on_Victimization_surveys_2009_web.pdf](#);
38. FAZLIYSKI v. BULGARIA JUDGMENT 10 November 2005;
39. “Best v. Taylor Mach. Works 689 NE 2d 1057, 179 Ill. 2d 367 (1997)”;
40. <https://police.gov.mn/resource/policegovmn/File/2018/11/06/n3vvggzukdbbb4vmw/1.%202018.10%20sar%20medee%20Burtgedsen%20hereg.pdf>;
41. <http://www.wvlegislature.gov/WVCODE/ChapterEntire.cfm?chap=55&art=7B§ion=8>;
42. <http://www.jstor.org/stable/4508422>;
43. <https://emergencylaw.wordpress.com/civil-liability-legislation-in-each-state/>;
44. <http://www.lawcom.gov.uk/app/uploads/2015/04/cp137.pdf>;
45. <https://law.justia.com/codes/maryland/2010/courts-and-judicial-proceedings/title-11/subtitle-1/11-108>;
46. <https://clementcousin.files.wordpress.com/2017/03/referentiel-indicatif-de-l-indemnisation-du-prejudice-corporel.pdf>;
47. <https://www.legislation.sa.gov.au/LZ/C/A/CIVIL%20LIABILITY%20ACT%201936/CURRENT/1936.2267.AUTH.PDF>;
48. <http://www.lawcom.gov.uk/app/uploads/2015/04/cp137.pdf>;
49. <https://law.justia.com/codes/maryland/2010/courts-and-judicial-proceedings/title-11/subtitle-1/11-108>;
50. <https://media.genre.com/documents/cfpc1807-en.pdf>;
51. <http://www.jstor.org/stable/4508422>;
52. <https://clementcousin.files.wordpress.com/2017/03/referentiel-indicatif-de-l-indemnisation-du-prejudice-corporel.pdf>;
53. <https://association-aide-victimes-france.fr/accueil-association-daide-a-lindemnisation-victimes/differents-postesprejudice-corporel/prejudice-corporel-victime-directe/prejudice-agrement-2>;
54. <https://www.vie-publique.fr/sites/default/files/rapport/pdf/034000490.pdf>;
55. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/808343/criminal-injuries-compensation-scheme-2012.pdf?fbclid=IwAR0a47xYkPhCvO4Ago0B3LV_6SxhA-jj0954sxTI7CeAVdGKCZHpvcame5g;
56. <https://www.mvr.bg/psychology/en/activities/activities-and-functions/criminal-psychology>;
57. <https://polis.osce.org/country-profiles/bulgaria>;
58. file:///e:/nli/lawpenal_procedure_code_am2011_en.pdf;
59. https://e-justice.europa.eu/content_claiming_damages_from_the_offender-494-bg-en.do?member=1;
60. file:///e:/nli/lawpenal_procedure_code_am2011_en.pdf.

